АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН
(2014 оны жилийн эцэс)

**НЭГ. НИЙТ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ:**

| *Гэрээнд тусгагдсан нийт арга хэмжээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр хүрэх түвшин* | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин | *Жинхэнэ гүйцэтгэл (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин)* | |
|---|---|---|---|
| **1** | **2** | **3** | **4** |
| **Нэг. *"Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад геологийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг нь хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах"* гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:** | | | |
| **1.1. Ашигт малтмалын хайгуулын ажлын хөрөнгө оруулалтыг өсгөн нэмэгдүүлж, хайгуулын ажлыг ерөнхий болон нарийвчилсан үе шаттайгаар хийж, улсын эрдэс баялгийн сан хөмрөгийг өсгөн нэмэгдүүлнэ /ЗГҮАМХ – 37.1-р заалт/** | | | |
| 1.1.1. Улсын төсвийн хөрөнгөөр /УТХ/ 2014 онд хийгдэх геологи, судалгааны ажлын /ГСА/ төлөвлөгөөний төслийн саналыг боловсруулан УУЯ-д хүргүүлэх, УТХ-өөр гүйцэтгэж буй төслүүдийн санхүүжилтийн нэгтгэх, | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа - I-IV улирал<br>Чанар - Тооцоо үндэслэлсайтай, хугацаандаа багтсан байна | - 2014 онд УТХ-өөр шинээр хийгдэх 1:50000-ны геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын 17 төсөл, сэдэвчилсэн судалгааны 4 төсөл, хамтын ажиллагааны 1 төсөл нийт 22 төслийн геологийн судалгааны ажлын гэрээ байгуулж, судалгааны ажлыг эхлүүлсэн ба шинээр эхэлсэн Булган-50, Дөрөө нуур-50, Баян-Индэр-50, Буурал Хайрхан-50 төслүүдийн хээрийн шуурхай хяналт хийсэн.<br>- 22 төслийн хээрийн материалыг хүлээн авсан.<br>- 2015 онд УТХ-өөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын төсвийн төсөөллийг 2014.05.12-ны өдрийн 4-3259 тоотоор УУЯ-нд хүргүүлсэн. | |
| 1.1.2. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны 54 төслүүдийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хээрийн ажлын явцад шуурхай хяналт хийх, хээрийн материалыг хүлээн авах, газар дээр нь мэргэжлийн зөвлөгөө өгөх, дүгнэх, | Тоо хэмжээ – 2 ажил үйлчилгээ<br>Хугацаа - III-IV улиралд<br>Чанар - Хууль журмын дагуу | Булган-50, Дөрөө нуур-50, Баян-Индэр-50, Буурал Хайрхан-50, Дэлгэрхаан-50, Хайрхан уул-50,Хамарын толгод-50, Улаанбадрах-50, Баяндалай-50,Сайнцагаан-50, Бурхант толгой-50, Онц уул-50, Дэвсгийн нуруу-50, Цогт-50,Шивээт-50, Хөх нуур-50,Тогоо хайрхан-50 төслүүдийн хээрийн ажлын явцад газар дээр нь шуурхай хяналт хийж, нийт 62 төслийн хээрийн материалыг хүлээн авсан. | |
| 1.1.3. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа геологийн зураглал болон бусад судалгааны ажил хийгдсэн үр дүнгийн тайлангуудыг хүлээн авах, | Тоо хэмжээ – Төслүүдийн тоогоор<br>Хугацаа – жилдээ<br>Чанар – Геологийн даалгавар, тавигдах | -Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн Баянзүрх, Дадал, Хутаг өндөр, Баянмөнх, Донгой гол, Манлай, Мандалговь зэрэг талбайд хийгдсэн 1.50000-ны масштабын зураглалын ажлын тайлангууд, мөн УУЯамны захиалгаар гүйцэтгэж буй Баруун-Монгол-IY,Төв-Монгол-IY, Өмнөд-Монгол-YI, Дорнод- Монгол-IY, Дорнод- Монгол-Y, "3D төсөл" зэрэг | |

| | | |
|---|---|---|
| | шаардлагад нийцсэн | төслүүдийн үр дүнгийн тайлангууд, стратегийн Эрдэнэт, Таван толгойн Цанхийн хэсгийн тодотгол тооцоо, Шарын гол, Төмөртэйн төмрийн орд ашиглах ТЭЗҮ зэрэг 19 төслийн ажлын тайлан, бичвэр, дагалдах CD-ийн хамт хянаж хүлээн авлаа. |
| 1.1.4. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон бусад судалгаа хийгдсэн ажлын үр дүнгийн тайлангуудаас орд, илрэлийн мэдээллийн санд нэмэлт баяжуулалт хийх, | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа - тогтмол<br>Чанар – Шуурхай зохион байгуулсан байна | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн 1:50000-ны Дайргат, Дуулгат уул, Намалзах, Баянмөнх, Баянзүрх, Дадалын талбайн үр дүнгийн тайлангаас мэдээллийн санд шинээр 174 орд, илрэлийн бүртгэлийг нэмж оруулан мэдээллийн санг баяжууллаа.<br>-УГЗ-200 Өмнөд-IY төсөл, Өмнөд-Y төсөл, Баруун-Монгол-IY төсөл, Дорнод-Монгол-IY төслүүдийн талбайг судалгааны картограммд буулгаж, шинээр хэвлэн гаргалаа.<br>-Мөн 1:50000-ны масштабын 17 тайлангаас хэтийн төлөвтэй талбай ялгаж, байр зүйн зураг дээр давхцуулан буулгах ажилд оролцож, зураг хэвлэж өглөө.<br>-Эрдсийн хуримтлалтай байх магадлалтай 42 талбайн а/м-ийн зургийг 1:100 000-ны лист дээр боловсруулалт хийж, хэвлэв. |
| 1.1.5. Ашигт малтмалын нөөцийг бүртгэсэн төрийн захиргааны байгууллагын тушаал, шийдвэрийг үндэслэн нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэх, нөөцийн хөдөлгөөнийг 2010-2012 оны байдлаар гаргах, | Тоо хэмжээ – 2 ажил үйлчилгээ<br>Хугацаа - тогтмол<br>Чанар –Тавигдах шаардлагад нийцсэн байна | -Хувийн хөрөнгөөр геологийн хайгуулын ажил хийж, ЭБМЗ-ийн хурлаар үр дүнгийн тайлангаа хэлэлцүүлж, нөөц батлуулсан 141 ордын тайлан, 128 ордын ТЭЗҮ, нөөцийн хөдөлгөөний 8 тайлан, бусад судалгааны 9 тайланг тус тус дагалдах бичиг баримтуудыг заавар, журмын дагуу хүлээн авч, улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэлээ.<br>- Геологийн архивт 2013-2014 онуудад шинээр тушаагдсан тайлангаас 243 ордын нөөцийн тухай мэдээллийг 25 асуултын дагуу оруулж, мэдээллийн санг баяжуулсан.<br>*Нөөцийн хөдөлгөөн хийх ажлын хүрээнд*:<br>2005-2009 онд нийт 23 төрлийн ашигт малтмалын 471 ордод нөөцийн хөдөлгөөны тэнцэл хийсэн. Үүнд: зэс-12, молибден-9, төмөр-33, цайр-7, хар тугалга-4, кадми-3, стронци-1, мөнгө-13, алтны үндсэн орд-35, цагаан тугалга үндсэн-2, цагаан тугалга шороон -11 бүлэг орд 53, гянтболд үндсэн-13, гянтболд шороон-6 бүлэг орд 24, хайлуур жоншны-84, давсны-23, мөсөн шүү-14, гөлтгөнө-9, элс-хайрга-48, барилгын чулуу-10, цементийн түүхий эд-4, тоосгоны шавар-48, шохойн чулуу-21, баластын түүхий эд-1.<br>Нийтдээ 1400 ордын нөөцийг протоколтой тулгалт хийж, зөрүүтэй, алдаатай орсонг тодруулж, засвар хийж дуусгав. |
| 1.1.6. Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээнд аж ахуйн нэгж, | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ | - Хувийн хөрөнгөөр хийгдсэн ГХА-ын 2013 оны жилийн тайлан 1667ш тайлан ирүүлэх ёстойгоос /хүчин төгөлдөр ТЗ-н тоогоор/ 1134 тайлан |

| | | |
|---|---|---|
| байгууллагаас ирүүлэх төлөвлөгөө, тайлангийн болон эрдэс баялгийн судалгааны мэдээллийн нэгдсэн санг нэмэлт мэдээллээр баяжуулж шинэчлэх, | Хугацаа - тогтмол<br>Чанар –Мэдээлэл үнэн зөв байна | ирж төлөвлөгөө, тайлангийн мэдээллийн нэгдсэн санд 1072ш тайлан бүртгэгдсэн.<br>- 2014 онд хийх хайгуулын ажлын 1120 төлөвлөгөө ирж хянагдсанаас МХЕГ-т хянагдсан 834 төлөвлөгөө санд бүртгэгдсэн. |
| 1.1.7. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа геологийн судалгааны ажлуудын нэгдсэн тайланг улирал тутам гаргаж УУЯ, СЯ-нд хүргүүлэх, | Тоо хэмжээ – 4 удаа<br>Хугацаа - Улирал бүр<br>Чанар –Тайлан үнэн зөв байна | - 2014 оны 4-р улирлын тайланг 2015 оны 1-р сард хүргүүлнэ.<br>2014 оны 3-р улирлын тайланг 2014.11.11-ний өдрийн 4-6136 тоот албан бичгээр, 2014 оны 2-р улирлын тайланг 2014.07.25-ны өдрийн 4-4353 тоот албан бичгээр, 2014 оны 1-р улирлын тайланг 2014.04.22-ны өдрийн 4-2927 тоот албан бичгээр УУЯ-нд хүргүүлсэн |
| 1.1.8. Монгол орны ашигт малтмалын нөөцийн талаарх ерөнхий мэдээллийг гаргаж олон нийтэд мэдээлэх, хувийн хөрөнгөөр хийсэн геологийн судалгааны ажлуудтай холбоотой тойм мэдээлэл бэлтгэх, | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар – Салбарын тайлан мэдээ гарсан байна | <u>*Нөөцийн талаар*</u><br>- УУЯ, ТӨХ, ЦЕГ, Алт үйлдвэрлэгчдийн холбоо болон бусад газарт 2013 онд шинээр ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн ордуудын мэдээлэл, голлох 12 ашигт малтмалын мэдээлэл<br>УУЯ-нд Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооны гишүүн компаниудийн зээл авах хүсэлт гаргасан 28 компанийн нөөцийн талаарх мэдээлэл, СБТГ-т голлох 10 ашигт малтмалын нөөцийн талаарх мэдээлэл<br>Стратегийн ордод хамааруулах гэж буй ГХЭ-н ордын судалгааны материал, танилцуулга, нөөцийн мэдээлэл<br>ЦЕГ-ын Монгол орны ГХЭ-н талаарх судалгааны материал, нөөцийн мэдээ, ТЗ эзэмшигчийн талаарх мэдээлэл<br>2009-2014 онд нөөц нь бүртгэгдсэн 12 голлох ашигт малтмалын нөөцийн мэдээлэл<br>Бүрэнхааны орд, ГХЭ-н, алтны шороон ордын үлдэгдэл нөөцийн, өнгөлгөөний чулууны 25 ордын, шатах занарын ордуудын нөөцийн мэдээ<br>Ховд аймгийн талаарх УТХ-өөр хийсэн геологийн судалгаа, хувийн хөрөнгөөр хийж буй хайгуулын ажлын талаарх болон нөөцийн талаарх мэдээлэл,<br>Гацууртын болон Шаазгайтын алтны үндсэн ордын нөөцийн мэдээ.<br>УУ-н сайдын зөвлөх Б.Бат-Эрдэнэд металл бус болон барилгын 25 ордын нөөц болон хайгуулын ажлын зардлын мэдээ<br><u>*Мэдээлэл бэлтгэсэн талаар*</u><br>-Германтай хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн төслүүдийн,<br>-ГХЭ-ийн ордуудын мэдээлэл,<br>-ЭБМЗ-ийн хэлэлцсэн тайлангууд дүгнэлт, тушаалын мэдээлэл,<br>- 2012, 2013 оны ГХА-н жилийн тайлангийн, БОНСэргээлтийн зардлын |

| | | |
|---|---|---|
| | | мэдээ,<br>-“Урт нэртэй” хуулинд хамрагдсан 789 хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн,<br>-Хайлуур жоншны хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн,<br>-Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн, Улсын төсвийн хөрөнгөөр болон хувийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулын ажлын мэдээлэл.<br>-Канадын болон Гонконгийн хөрөнгө оруулалттай компаниудын мэдээлэл<br>- Баян-Өлгий аймгийн нутаг дахь тусгай зөвшөөрлүүдийн талаарх мэдээлэл<br>-Нээлттэй хаалганы өдөрлөгт зориулсан Геологийн албаны мэдээлэл<br>-2008-2013 оны хувийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардал, жилийн тайлан, төлөвлөгөө, үр дүнгийн тайлангийн үйлчилгээгээний орлогын мэдээ<br>-УУ-н сайдын 2014.06.02-ны өдрийн тушаалаар батлагдсан ажлын хэсэгт антрацитын нүүрсний 3-н ордын геологи, нөөцийн мэдээлэл<br>- МҮГХ-ны ерөнхийлөгчийн хүсэлтийн дагуу геологи хайгуулын ажлын талаарх мэдээлэл<br>“Билүүт майнинг” ХХК, Пибоди винсвэй ресорсез”, “Монголросцветмет, ХК, “Алтан нар” төсөл, Эрдэнэ ресорсиз” ХХК-ний мэдээлэл, бэлтгэсэн.<br>-Авлигатай тэмцэх газарт “Хан Ресорсиз” ХХК-ий тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн хайгуулын ажлыг газар дээр нь тулган баталгаажуулж байсан талаархи мэдээлэл<br>-УУЯ-нд “Шинэ сэдлийг хөгжүүлэх төв” ТББ-с ирсэн албан бичгийн дагуу Монгол улсын вольфрамын орд илрэлүүдийн хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшиж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны судалгаа<br>-Эрүүгийн цагдаагийн газарт байгалийн өнгөт, үнэт, эрдэнийн чулууны ангилалын талаарх мэдээлэл |
| 1.1.9. Эрдэс чулуулгийн лабораторийн шинжилгээ, судалгааг боловсронгуй болгож олон улсын түвшинд хүрсэн чанарын болон тоон шинжилгээг иж бүрэн хийдэг болно. Мөн геологийн дээжинд шинжилгээ хийж байгаа бусад лабораториудын үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, арга | Тоо хэмжээ – 2 арга хэмжээ<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар – Лабораторийн шинжилгээ, судалгаа олон улсын түвшинд хүрсэн байна | - Монгол улсын хэмжээнд эрдэс чулуулгийн шинжилгээ, судалгаа хийж байгаа итгэмжлэгдсэн лабораториудын жагсаалтыг гаргаж, үйл ажиллагаанд нь дүн шинжилгээ хийж, зөвлөмжийг 33 аж ахуйн нэгжүүдэд хүргүүлсэн бөгөөд итгэмжлэгдсэн лабораториудын шинжилгээний ажлын талаарх санал, зөвлөмжийг хавсаргасан.<br>- Лабораториудын товч танилцуулга, хүчин чадал, ажлын ачаалал, нэр төрөл, хаяг байршлын мэдээллийг нэгтгэн боловсруулж цахимаар болон |

| | | |
|---|---|---|
| аргачлалын хяналт тавьж ажиллах | | 2014 оны 10-р сарын 31-ний өдрийн 4996 тоот албан бичгээр УУЯ-нд хүргүүлсэн. |
| **1.4. Гадаадын зарим орнуудтай хамтарч Геологи, судалгааны чиглэлээр тодорхой төслүүд хэрэгжүүлнэ** | | |
| 1.4.1. БНЧех улстай хамтарсан 1:50 000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн "Монгол Алтай-50" төслийн 2014 оны хээрийн судалгааны ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, оролцох | Тоо хэмжээ –1 төсөл<br>Хугацаа - II-IV улиралд<br>Чанар –Төслийн ажил үргэлжлэн хийгдсэн байна | Геологийн судалгааны төв - Чехийн геологийн алба хамтран хэрэгжүүлж байгаа төслийн төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн 2014.03.28-ны 3-р хурлаар хэлэлцүүлсэн. Хээрийн ажилд оролцох бүрэлдхүүнийг /13/ гаргаж, Чехийн талаас 6 геологичийн ажиллах зөвшөөрлийг УИБМТ-өөс гаргуулсан, Монголын талаас 4 оюутан, 3 геологич хээрийн ажлыг эхлүүлж, 5-р сарын 22-ноос 7-р сарын 22 хүртэл хугацаанд 2 дахь жилийн ажлыг хийж дуусган, дээжүүдийг шинжилгээнд өгсөн. |
| 1.4.2 Польш улстай хамтарсан Хасагтын талбайн геологийн судалгааны ажлыг үргэлжүүлэх, хээрийн судалгааны ажилд оролцох | Тоо хэмжээ –1 төсөл<br>Хугацаа – II-IV улиралд<br>Чанар –Төслийн ажил үргэлжлэн хийгдсэн байна | Польшийн Геологийн албанд 2014 оны тайлан ирүүлэх тухай албан тоотоор бичиг хүргүүлсэн. "Хасагт-50" талбайд 2013 онд хийсэн ажлын тайланг хүлээн авч, эцсийн үр дүнгийн тайланг хүлээн авахаар Польшийн талтай тохирч, эрлийн цогц ажлын тайланд арга зүйн зөвлөгөө өгөхөөр ГА-ны 2 мэргэжилтэн 2015 оны 1-р улиралд явахаар шийдвэрлэгдсэн. |
| 1.4.3. ОХУ, БНХАУ, БНКазУ, БНСУ-тай хамтран төрөлжсөн зургийг тайлбар бичгийн хамт зохиох "Хойд-Төв-Зүүн Азийн 3 хэмжээст геологийн структурууд ба металлогени" олон улсын төслийн хүрээнд төслийн ажлыг үргэлжлүүлэх, оролцох | Тоо хэмжээ –1 төсөл<br>Хугацаа - II-IV улиралд<br>Чанар –Төслийн ажил үргэлжлэн хийгдсэн байна | "Хойд-Төв-Зүүн Азийн 3 хэмжээст геологийн структурууд ба металлогени" олон улсын төслийн 2-р үе шатны тайланг хүлээн авч хянан, эцсийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2014.01.29-ны хурлаар хэлэлцүүлж, УУ-н сайдын тушаал гарч, гэрээг дүгнэн УУЯ-нд хүргүүлсэн.<br>"Хойд-Төв-Зүүн Азийн 3 хэмжээст геологийн структурууд ба металлогени" олон улсын төслийн 3 дахь үе шатны ажлыг гүйцэтгэх гэрээг хүлээн авч, ажлыг эхлүүлэн, явцын шуурхай хяналтыг хийж, үүрэг даалгавар өгсөн. |
| **1.5. Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх эдийн засгийн бүсчлэл, хүдрийн дүүрэг, талбайн хэмжээнд ашигт малтмалын төрөл, гарал үүслийн сонгодог төрлүүдээр гүйцэтгэхэд чиглэсэн болон сэдэвчилсэн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлнэ** | | |
| 1.5.1. Өмнөд говийн бүсэнд Баян-овоо, Даланзадгад, Ханбогд, Номгон, Хүрмэн, Манлай сумдын 70565,56 кв.км талбайд 1:200000-ны геологи, гидрогеологи, геоэкологийн иж бүрдэл зураг зохиох, геоэкологийн үнэлгээ өгөх төслийн эцсийн үр дүнгийн тайланг хүлээн авч хянах, ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх, | Тоо хэмжээ –1 төсөл<br>Хугацаа – 12 сард<br>Чанар – Холбогдох дүрэм журам, геологийн даалгаварт заасны дагуу | Өмнөд говийн бүсийн 1:200000-ны геологи, гидрогеологи, геоэкологийн иж бүрдэл зураг зохиох, геоэкологийн үнэлгээ өгөх төслийн төсвийн тодотголыг 2014.04.11-ний өдрийн ЭБМЗ-ийн 5-р хурлаар хэлэлцэж баталсан, тушаалыг хүргүүлсэн, үр дүнгийн тайлан 2014 оны 12-р сард багтаан ЭБМЗ-өөр хэлэлцүүлнэ. |
| 1.5.2. Монгол орны баруун бүсэд цул сульфидын хүдэржилтийн тархалтыг судалж, 1:1 000 000 масштабын хэтийн | Тоо хэмжээ –1 төсөл<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар – Холбогдох | Монгол орны баруун бүсэд цул сульфидын хүдэржилтийн тархалтыг судалж, 1:1 000 000 масштабын хэтийн төлвийн зураг зохиох, үнэлгээ өгөх, цаашдын судалгааны обьектийг тодруулах төслийн геологийн |

| | | |
|---|---|---|
| төлвийн зураг зохиох, үнэлгээ өгөх, цаашдын судалгааны обьектыг тодруулах төслийн геологийн даалгаврыг боловсруулах, хээрийн судалгааны ажлыг эхлүүлэх, | дүрэм журам, геологийн даалгаварт заасны дагуу | даалгаврыг боловсруулан УУЯ-нд хүргүүлж, гэрээ байгуулан, хээрийн судалгаа ажлыг эхлүүлж, хээрийн судалгааны ажлын материалыг хүлээн авсан. |
| 1.5.3. Баян-Өлгий, Ховд аймгийн нутгийг хамарсан M-45-XXXVI, M-46-XXXI, L-46-I, II, L-46-VII, VIII хавтгайд 1:200 000-ны масштабтай агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг Ховд-I талбайд шинээр хийх ажлын геологийн даалгаврыг боловсруулах, хээрийн судалгааны ажлыг эхлүүлэх | Тоо хэмжээ –1 төсөл<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар – Холбогдох дүрэм журам, геологийн даалгаварт заасны дагуу | Агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлын геологийн геологийн даалгаврыг шинээр боловсруулан УУЯ-нд хүргүүлж, хээрийн судалгааны ажлыг эхлүүлэн, хээрийн судалгааны материалыг хүлээн авсан. |
| 1.5.4. УТХ-өөр гүйцэтгэж буй “Монгол орны газрын ховор элементийн металлогени, түүний хэтийн төлвийн судалгаа” төслийн ажлын төсөл, төсвийг хүлээн авч хянах, хээрийн судалгааны ажлыг үргэлжүүлэх, | Тоо хэмжээ –1 төсөл<br>Хугацаа - II-IV улиралд<br>Чанар – Геологийн даалгаварт заасны дагуу | 2014.04.11-ний өдрийн ЭБМЗ-ийн 5-р хурлаар төсвийн тодотголыг хэлэлцэж баталсан сайдын тушаалыг хүргүүлсэн,үр дүнгийн тайланг 2014 оны 12-р сард багтаан ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлнэ.<br>ШУТИС, АМГ хамтран “Газрын ховор элемент 2013” сургалтыг зохион байгуулсан. 2014.09.25-нд. |
| 1.5.5.УТХ-өөр 2013-2016 онд хэрэгжих “Монгол орны геологийн мэдээллийн сан” төслийн хүрээнд геологийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг үргэлжүүлэх, | Тоо хэмжээ –1 төсөл<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар – Геологийн даалгаварт заасны дагуу | УУЯ-ны ТНБД-ын 2014.04.01-ны өдрийн 3/728 тоотоор уг төслийн гэрээ, геологийн даалгавар ирсэн. 2014.04.14-нд шинэчилсэн геологийн даалгавар батлагдаж, 2014.05.30-ны өдрийн ЭБМЗ-ийн 7-р хурлаар ажлын төсөл, төсвийн тодотголыг баталсан. Төслийн явцад шуурхай хяналт хийсэн. |
| 1.5.6. Үйлчилгээнд ашиглагдаж байгаа газар зүйн мэдээллийн систем (GIS)-д тулгуурласан цахим мэдээллийн санг шинэчлэх, баяжуулах, нэмэлт мэдээлэл бэлтгэх,<br>/9 сери, аймаг, картограммууд, гэх мэт/ | Тоо хэмжээ –1 арга хэмжээ тогтмол<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар – Шуурхай, үнэн зөв | -1:50 000-ны масштабын картограммын зургийг шинэчлэх зорилгоор 154 тайлангуудын координатыг тодруулж, 354 тайлангаас зураглалын ажлын өртөг, талбайн хэмжээг гаргаж, 1741 хуудас протокол хувиллаа.<br>-УГЗ-200 төсөлд зориулсан серийн легенд, судалгааны зурагт баяжуулалт хийж, хэвлэв.<br>-УУЯ, БОНХЯ-ны захиалгаар 7 талбайн зургийг кадастрын зурагт буулгаж өглөө<br>-Даргын зөвлөхөд Au.Cu.Fe.Mo.Ag.CaF.ГХЭ-ийн мэдээлэл бэлтгэж өгөв.<br>-Мөн албан бичгээр ирсэн 4 талбайн түгээмэл тархацтай ашигт малтмалын мэдээлэл бэлтгэв.<br>-Бүтээлийн жагсаалт 21 удаа гаргав.<br>**<u>Гадны байгууллагуудын захиалгаар:</u>**<br>-Орд, илрэлийн сангаас Монгол орны шатдаг занарын 10 орд, 66 илрэл, |

| | | |
|---|---|---|
| | | гөлтгөний 16 орд, 89 илрэл, барилга материалын 1 орд, 87 илрэл, өнгөт чулууны 25 мэдээлэл, марганцын мэдээлэл<br>-Сайдын илтгэлд шаардагдах алт, мөнгө, зэс, молибден, уран, төмөр, хар тугалга, цайр, нүүрс, хайлуур жоншны нөөцийг бүс нутгаар гаргаж зургийн хамт мэдээлэл бэлтгэсэн.<br>-Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор ХК-ын захиалга, Зүүн гурван аймгийн судалгааны зураг, гөлтгөний орд илрэлийн зураг, Булган аймгийн түгээмэл тархацтай орд, илрэлийн мэдээлэл, Засаг захиргааны зураг, “Шинэ шивээ” ХХК улсын төсвийн хөрөнгөөр хийсэн зураг, ОХУ-н геологийн архивын 209 тайлангийн шүүлт,<br>-УУЯ-ны захиалгаар эрдсийн хуримтлалтай талбайн зураг, Улсын тусгай хамгаалалттай газрын орд, илрэлийн мэдээлэл, Засаг захиргааны 1:1000 000-ны масштабын зураг, агаарын геофизикийн болон соронзон, хүндийн хүч, цацраг идэвхжилийн зураг тус тус боловсруулан гаргав.<br>-Литийн, шаврын, мангаан, холимог металлын, түгээмэл тархацтай а/м-ын мэдээлэл, ГХЭ-ийн ордын мэдээлэл, Алтны мэдээлэл 5 удаа, давс, мөсөн шүү, фосфорит, өнгөт чулууны ордын мэдээллүүдийг захиалгын дагуу боловсруулж, хэвлэж өглөө.<br>-Магма майнз ХХК-ний захиалгаар соронзон, хүндийн хүч, цацраг идэвхижлийн зургуудыг боловсруулан хэвлэж өглөө.<br>-Гадны байгууллагын захиалгаар 9 серийн мэдээлэл бэлтгэж, хэвлэж өглөө.<br>-Хөх Турк ХХК-ний захиалгаар түгээмэл тархацтай а/м-ийн мэдээлэл бэлтгэв.<br>-Бог уулын 3 хэмжээст зураг, хүндийн хүчний зураг, сарсарын зургийн боловсруулалтын ажлыг захиалгын дагуу хийж өглөө.<br>Гээпэл ХХК-ний захиалгаар УБ, Төв аймгуудын түгээмэл тархацтай а/м-ын зураг бэлтгэж, хэвлэж өгөв.<br>-9 сери а/м-ын мэдээлэл шинэчлэх зорилгоор суурь зургийг бэлтгэж байна.<br>-Албан хүсэлтийн дагуу мэдээллийн сангаас металл бус а/м-ын 539 ордын паспорт хэвлэв.<br>-УУЯ-ны захиалгаар 69 орд, 115 илрэлийн мэдээлэл<br>-ГА-ны даргад нүүрсний 85 ордын мэдээлэл<br>-АМГ-ын даргад БӨ, Архангай аймгуудын мэдээлэл<br>-Онцгой байдал, ГХЭ-ийн холбоо, төмөр замын газарт трастын зураг захиалгаар хэвлэж өгөв. |

| | | |
|---|---|---|
| | | - Шохой цагаан булаг, Эрдэнэ минас, Тэнүүн байгаль зэрэг ХХК-ний албан тоотод хариу өгөх<br>-Эрдэнэ Монгол ХХК-ний 16956Х тоот ТЗ-ийн талбайн 31 сувгийн координатыг хөврүүлж, нэгтгэж, боловсруулалт хийлээ.<br>Түгээмэл тархацтай а/м-ын мэдээлэл УУЯ-нд хүргүүлэх зэрэг ажлуудыг хийлээ. |
| 1.5.7 Монгол орны геологийн 3 хэмжээст зургийг 1:1000000-ны масштабаар зураглах, дагалдах мэдээллийн санг бий болгох, | Тоо хэмжээ –1 төсөл<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар – Геологийн даалгаварт заасны дагуу | 2014.04.11-ний өдрийн ЭБМЗ-ийн 5-р хурлаар, 2014.05.30-ны өдрийн 7-р хурлаар төсвийн тодотголыг хэлэлцэж баталсан,төсөл үргэлжлэн хэрэгжүүлж, төслийн явцал шуурхай хяналт хийсэн. |
| **1.7. Монголын Үндэсний геологийн албыг шинээр байгуулах асуудлыг судалж шийдвэрлэнэ / ЗГҮАХХАХТ – 39.1-р/** | | |
| 1.7.1. Монголын Үндэсний Геологийн албыг шинэчлэн зохион байгуулахад идэвхтэй оролцож ажиллах, | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар - Шуурхай, үр дүнтэй оролцож ажиллана | УУЯ-нд Монголын Үндэсний Геологийн албыг шинэчлэн зохион байгуулах, түүний бүтэц, үйл ажиллагааны талаар санал өгсөн. |
| **1.8. Геологи, эрдэс баялгийн судалгааны стандарт, норм, нормативыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах** | | |
| 1.8.1. Ордын гидрогеологийн заавар боловсруулах ажлыг эхлүүлэх | Тоо хэмжээ –1 төсөл<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар - Тавигдах шаардлагад нийцсэн байна | Энэ ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч 2014 онд УТХ-өөр гүйцэтгэх ГСА-ын санхүүжилтээс хасагдсан тул гүйцэтгэх боломжгүй болсон. |
| 1.8.2. Хүн ам ихээр төвлөрсөн, томоохон хот суурин газарт том масштабын геоэкологийн судалгаа хийх талаар санал боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлэх, | Тоо хэмжээ – 1 судалгааны ажлын санал<br>Хугацаа – III-IV улиралд<br>Чанар -Судалгаа бодитой байна | Хүн ам ихээр төвлөрсөн, томоохон хот суурин газарт том масштабын геоэкологийн судалгаа хийх санал боловсруулж УУЯ-нд хүргүүлсэн боловч 2014 оны төлөвлөгөөнд ороогүй, 2015 оны УТХ-өөр гүйцэтгэх ГСА-ын төлөвлөгөөнд Улаанбаатар хотын геоэкологийн судалгаа хийх саналыг УУЯ-нд хүргүүлсэн. |
| 1.8.3. Геофизикийн хээрийн судалгааны ажлыг явуулах түр заавсрыг боловсруулах ажлыг эхлүүлэх. (Соронзон хайгуул, Грави хайгуул, Цооногийн геофизик, Цахилгаан хайгуул, Сейсмо хайгуул) | Тоо хэмжээ – 1 зааврын төсөл<br>Хугацаа - I-II улиралд<br>Чанар -Үндэслэл сайтай, хэрэгжих боломжтой | Энэ ажлыг гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч 2014 онд УТХ-өөр гүйцэтгэх ГСА-ын санхүүжилтээс хасагдсан тул гүйцэтгэх боломжгүй болсон. |
| 1.8.4. УТХ-өөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлын норм, норматив зохиох ажлыг эхлүүлэх | Тоо хэмжээ –1 төсөл<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар – Ажил эхэлсэн | Голлох 5 төрлийн ашигт малтмалын инструкц /заавар шаардлага/ боловсруулах, геологийн судалгааны ажлын норм, нормативыг зохиох геологийн даалгаврыг боловсруулж файлаар 2014-02-12-нд, албан |

| | | |
|---|---|---|
| | байна | бичгээр 2014-02-26-нд /4-933/ УУЯ-нд хүргүүлсэн, 2014 оны ГСА-ын төлөвлөгөөнд ороогүй. |
| 1.8.5. Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн ашигт малтмалын ордуудын ажлын хэмжээ, зарцуулсан төсвийн нэгдсэн бүртгэл гаргах / стратегийн 34 орд болон бусад /1 сард 10 ордын зардлын хэмжээ гаргана/ | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ Хугацаа – Жилдээ Чанар - Мэдээлэл үнэн зөв, бодитой байна | Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн Дорнод, Мардай, Тэвшийн говь, Таван толгой ордын Баруун, Цанхийн хэсэг, Асгат, Адуунчулуун, Шивээ-Овоо, Багануур, Нарийн сухайт, Цайдам нуур, Бороо, Талбулаг, Хөөт, Хөөтийн хонхор, Чандгана тал, Налайх, Алаг тогоо, Зээгт, Могойн гол, Сайхан овоо зэрэг стратегийн 32 ордуудын зарцуулсан өртгийн тооцоог гаргаж, 138 ш бусад ордуудын мэдээлэл бэлтгэж, улсын төсвийн хөрөнгөөр судалгаа хийгдсэн нийт ажлын хэмжээ, зарцуулсан өртөгийн хэмжээг гаргаж, ACCESS программд бүртгэж оруулллаа. |
| **Хоёр. "*Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уул уурхайн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг нь хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах*" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | |
| **2.1.Татварын зохицуулалт хийх замаар түүхийгээр гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ /ЗГҮАМХ – 40.7-р заалт/** | | |
| 2.1.1. Түүхийгээр гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшингийн судалгаа хийх | Тоо хэмжээ – 1 судалгаа Хугацаа - жилдээ Чанар -Үндэслэл сайтай, хэрэгжихүйц бодитой байна | Түүхийгээр гаргаж байгаа төмрийн хүдрийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлэх боломжийг судлах ажлын хүрээнд төмрийн хүдрийн стандарт, төмрийн хүдрийн ангилал, татварын орчин, ногдуулж буй татварууд болон хөнгөлөлт, чөлөөлөлт, нөөцийн төлбөр, эцсийн бүтээгдэхүүний НӨАТ-ыг "0" болгох тухай судалгааны материалуудыг бүрдүүлж судлан, төмрийн хүдрийн 3 уурхайн эдийн засгийн тооцоолол хийж татварын зохицуулалт буюу ачаалал бууруулах боломжийн санал боловсруулан УУЯ-ны мэргэжилтэн н.Ачитсайханд 2014.08.20-нд achitsaikhan@mm.gov.mn цахим хаягаар хүргүүллээ. |
| **2.2. Уул уурхайн олборлох үйлдвэрийн бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр тэргүүн ээлжинд дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлдэг болно. / ЗГҮАХХАХТ -40.8-р/** | | |
| 2.2.1. Дотоодын боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн судалгаа хийх (зэс, төмөр) | Тоо хэмжээ – 2 судалгаа Хугацаа - жилдээ Чанар -Үнэн бодитой, хэрэгжихүйц бодитой байна | Дотоодын хайлуур жонш, төмрийн боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх уул уурхайн гаралтай бүтээгдэхүүний зах зээлийн судалгааг хийх ажлын хүрээнд хайлуур жонш болон төмрийн хүдрийн дотоодод борлуулсан үнийн дүнг Уулын ажлын тайлангаас нэгтгээд байна. Судалгааны ажил нэгтгэх ажлыг гүйцэтгэж байна. |
| **2.3. Байгаль орчны аудитаар дамжуулж уул уурхайн үйлдвэрлэлд байгаль орчинд сөрөг нөлөөлөл ихтэй технологийг ашиглуулахгүй байх арга хэмжээг авна. /ЗГҮАХХАХТ -40.10-р/** | | |
| 2.3.1. Байгаль орчинд сөрөг нөлөөлөл ихтэй | Тоо хэмжээ – 1 санал | 1. Уулын ажлын тайлан төлөвлөгөө, 117 аж ахуйн нэгжүүдийн ТЭЗҮ, |

| | | |
|---|---|---|
| техник, технологийн судалгаа хийх (метал ашигт малтмал) | Хугацаа - жилдээ<br>Чанар -Үндэслэл сайтай, хэрэгжихүйц бодитой байна | БОНБНҮ-нд тусгагдсан техник, технологийн мэдээллийг авч мэдээллийн сан нэгтгэв.<br>2. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт туссаны дагуу Байгаль орчны аудитыг байгалийн нөөц ашиглан үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн $10^1$дүгээр зүйлийг үндэслэн: Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн А-126 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд санал хүргүүлсэнээр 2013-2014 онд үйл ажиллагаа явуулж буй Бороогоулд, Тавантолгой, Оюу толгой, Энержи ресорс, Гацуурт зэрэг аж ахуй нэгжүүдэд байгаль орчны талаар хийгдсэн ажилд аудитыг 2015-2016 онд зохион байгуулах ажлын бэлтгэл ажлыг хийлээ. |
| **2.4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд тавигдах шаардлагыг өндөржүүлж, нөлөөллийн үнэлгээгээр олборлолт, ашиглалтын технологи нь байгаль орчинд сөрөг нөлөөлөл ихтэй уурхайн технологи, стандартын мөрдөлтөд аудит хийж тодорхой арга хэмжээ авна. / ЗГҮАХХАХТ -40.11-р/** | | |
| 2.4.1. Байгаль орчинд сөрөг нөлөөлөл ихтэй техник, технологийн судалгаа, мэдээллээр холбогдох байгууллага, ажлын хэсгийг хангаж ажиллах. | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа – тухай бүр<br>Чанар -Үр дүнтэй, шуурхай зохион байгуулна | 2013 оны тайлан, 2014 онд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулсан элс, хайрга, дайрга-20, гянтболд-1, шавар-5, цагаан тугалга-2, гантиг чулуу-1, шохойн чулуу-1 төмөр-8, холимог металл-4, жонш-25, зэс-3, алт-27 нийт 97 аж ахуй нэгжүүдийн БОНБҮ-ний тайлангаас нөлөөллийн судалгааг авав.<br>1. Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн 8 зүйлийн 8.4 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 48 зүлийн 48.6.2, 48.6.3 дах заалт Газрын даргын 2014 оны а-80 дугаар тушаалыг тус тус үндэслэн байгаль орчны нөлөөллийн маягтыг батлуулан 2015 онд үйл ажиллагаа явуулахаар ирүүлсэн уулын ажлын төлөвлөгөөнөөс мэдээлийг авч мэдээллийн санд нэгтгэж байна.<br>2. Баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдэд аудит хийх санал, байгаль орчны нөлөөлөл болон бусад холбогдох мэдээ, мэдээллийг БОНХЯ-ний мэргэжилтэн Б.Эрдэнэбаясгаланд 2014 оны 10 дугаар сарын 25-нд erdenebayasgalan .ganj@yahoo.de цахим хаягаар хүргүүлэв. |
| 2.4.2. БОНБҮ-нд тавигдах шаардлагыг өндөржүүлэх чиглэлээр санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх. | Тоо хэмжээ – 1 судалгаа<br>Хугацаа – жилдээ<br>Чанар -Үр дүнтэй, шуурхай зохион байгуулна | |
| **2.5. Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын Холбооны стандартыг нутагшуулж мөрдүүлнэ. / ЗГҮАХХАХТ -40.12-р /** | | |
| 2.5.1. Олборлох, боловсруулах технологийн судалгааг ашигт малтмалын төрөл бүрээр боловсруулах (алт, жонш, холимог метал) | Тоо хэмжээ – 1 судалгааны ажил<br>Хугацаа - II-IV улиралд | 1. Европын холбооны болон ХБНГУ-ын аргачлалыг нутагшуулах, судалгаа хийх “Байгаль орчинд учруулсан хохирол тооцох аргачлал” шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн 6 удаагийн хэлэлцүүлэгт |

| | | |
|---|---|---|
| | Чанар – Үнэн зөв, бодитой байна | оролцож Монгол улсын уурхайлалтын технологийн сул тал, онцлог, нөхөн сэргээлт хийсэн туршлагатай газар дээр нь танилцаж ажиллахад хүндрэлтэй талууд болон ололттой талын мэдээлэл хүргүүлэн ажиллаа. Аргачлалын төсөл боловсруулах ажлын хэсгийн хүрээнд дараах төсөлүүдэд саналаа өгч ажиллав.<br>Үүнд:<br>• Европын Холбооны Улсын болон Эдийн Засаг Хамтын Ажиллагааны Холбооны Улсууд дахь байгаль орчны хариуцлагын эрх зүйн орчин<br>• Уул уурхайгаас болон уул уурхайн хог хаягдлаас үүдэлтэй байгаль орчинд учруулсан цэвэр хохиролын асуудал " Байгаль орчны хариуцлагын заавачилгаа 2004*35/EX" гэсэн хууль.<br>• Уул уурхайн байгаль хамгааллын асуудалтай холбоотой бусад хууль эрх зүйн баримт бичиг болох "Бохирдлоос урьдчилан сэргийлэх болон хянах заавачилгаа 2008/1/EX<br>• Боловсруулах үйлдвэрээс гарах хаягдлын менежментийн заавачилгааны тухай хууль (MWD and directive 2006/21/EC)<br>• ХБНГУ-ын Хессен мужийн нөөцөөс нөөцөд болон үйлчилгээнээс үйлчилгээнд гэсэн зарчим дээр тулгуулсан хэсгийг тус бүр орчуулан монгол улсын батлагдсан хууль эрх зүйн орчинтой харьцуулан журам аргачлалын төсөл<br>2. Стандарчлал хэмжил зүйн газрын Стандартчлал, техникийн зохицуулалтын хэлтсээс ирүүлсэн дараах стандартуудын төсөлүүдэд 2014 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 6-4741 тоот албан хүсэлтээр саналаа өгч ажиллав.<br>Үүнд:<br>• "MNS A:2014 уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламж"<br>• "MNS B 2014 Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламж, ерөнхий шаардлага"<br>• "MNS C:2014 Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийн шороон боомтын хийц материалын нягтруулга. Техникийн шаардлага"<br>• "MNS D:2014 Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийн геонийлэг доторлогоо"<br>• "MNS E:2014 Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийн ашиглалтын үйл ажиллагааны хяналт, |
| 2.5.2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын Холбооны стандартыг судлах | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - Тухайн үед<br>Чанар - Тавигдах шаардлагад нийцсэн байна | |
| 2.5.3 Монгол улсад нутагших бүрэн боломжтой Европын Холбооны олборлох, боловсруулах салбарын стандарыг боловсруулж буй байгууллага, ажлын хэсгийг судалгаа, мэдээллээр хангаж ажиллах | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа - Тухайн үед<br>Чанар – Шуурхай, хэрэгцээтэй мэдээллээр хангасан байна | |

| | | |
|---|---|---|
| | | шинжилгээ. Техникийн шаардлага”<br>• “MNS F:2014 Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийг хааж нөхөн сэргээх ба хаасны дараах хяналт, шинжилгээ. Техникийн шаардлага”<br>• “MNS L:2014 Арьс, шир болон үслэг боловсруулах үйлдвэрлэлийн хаягдлын ерөнхий ангилал, тавих шаардлага”<br>• “MNS M:2014 Газрын тос боловсруулах үйлдвэрийн хаягдлын ерөнхий ангилал, түүний хаягдлын байгууламжид тавигдах шаардлага”<br>• “MNS CEN 13983:2003 хаягдал лагийн ангилал-Эвдэрсэн газрын хөрсний нөхөн сэргээлтэд хаягдлын лагийг ашиглахад дэвшилтэд туршлага” стандартуудын төсөлтэй танилцан холбогдох саналаа тусган 6-4741 тоотоор албан хариу хүргүүллээ. |
| **2.6. Ашигт малтмалын тухай хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ордын тодорхойлолтыг судалгаанд үндэслэн боловсронгуй болгож, эрчим хүчний болон коксжих нүүрс, зэс, төмрийн хүдэр, газрын ховор элемент зэргийг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ангилалд оруулна. /ЗГҮАХХАХТ -40.14-р заалт/** | | |
| 2.6.1. Ашигт малтмалын тухай хуульд заасан стратегийн ач холбогдол бүхий ордын тодорхойлолтыг судалгаанд үндэслэн боловсронгуй болгох санал боловсруулж УУЯ-нд хүргүүлэх | Тоо хэмжээ – 1 санал<br>Хугацаа - II-IV улиралд<br>Чанар - Тавигдах шаардлагад нийцсэн байна | 1. Эрдэс баялгийн салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичигт “стратегийн ашигт малтмал” гэсэн томъёолол тусаагүй ба шинээр боловсруулж УИХ-аар батлагдан 7-р сараас эхлэн мөрдөж байгаа Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтүүдэд Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын эрх зүйн байдлыг өөрчлөхөөр тусгаагүй байна. Эдгээр ордуудын эрх зүйн байдал хэвээр үлдэх нь тодорхой болж байх тул зэс, төмөр, газрын ховор элементийн ордууд бүхэлдээ бус харин хуулийн шалгуур шаардлагуудыг хангасан ордууд хамрагдах хэвээр үлдэв. Тухайн хуулийн төслүүд болон бодлогын баримт бичгийн төслийг боловсруулах ажлын хэсгүүдэд орж ажиллав.<br>2. ҮХААЯ-ны дэргэд байгуулагдсан “Монгол төмөр” хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн хуралд холбогдох мэргэжилтнийг оролцуулж, Хөгжлийн банк, улсын төсвийн болон гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хийгдсэн дэд бүтцийн холбогдолтой мэдээллийг ажлын хэсэгт хүргүүлэв. Мөн ойрын ирээдүйд ашиглалтанд орох төслүүдийн төмөр замаар тээвэрлэх боломжтой бүтээгдэхүүн, шинээр баригдах төмөр замын трассын дагуу ойролцоо орших уурхайнуудын талаарх мэдээллийг гаргаж УУЯ-нд 5-313 тоотоор хүргүүлэв.<br>3. “Монгол зэс” хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан УУЯ-ны захиалгаар тус хөтөлбөрийн төслийн зөвлөх |
| 2.6.2. Эрчим хүчний болон коксжих нүүрс, зэс, төмрийн хүдэр, газрын ховор элемент зэргийг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ангилалд хамруулах талаар судалгаа, мэдээллээр холбогдох байгууллага, ажлын хэсгийг хангаж ажиллах | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа - Тухайн үед<br>Чанар - Шуурхай, хэрэгцээтэй мэдээллээр хангасан байна | |

| | | |
|---|---|---|
| | | үйлчилгээ үзүүлэх Японы JICA агентлагийн хамтаар "Монголын зэсийн аж үйлдвэрийн салбарын мэдээллийн шинжилгээ" сэдэвт судалгаа хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллав. Уг ажлын хэсэг дэлхийн болон монголын зэсийн нөөц, потенциаль, хэрэгцээ, хангамж, уурхайнууд, зэс хайлуулах арга, үйлдвэр барих төлөвлөгөө, үйлдвэр барих боломжийн талаар урьдчилсан судалгааны ажлыг эхлүүлж 5-р сарын 23, 28, 30, 6-р сарын 3, 6-ны өдрүүдэд холбогдох судалгааны мэдээллүүдийн талаар ажлын хэсгийн уулзалтад танилцуулсны дагуу JICA агентлаг судалгааны ажлын тайлангаа эцэслэн боловсруулж УУЯ-нд ирүүлэхээр болов. |
| **2.7. Нэгдмэл тогтоцтой ордыг иж бүрэн ашиглах байгальд ээлтэй технологийг судалж нэвтрүүлэхийг дэмжинэ.** | | |
| 2.7.1 Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай технологийн судалгаа хийх, санал, дүгнэлт боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх. | Тоо хэмжээ – 1 санал<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Үнэн зөв, үндэслэл сайтай байна | - Батлагдсан уулын ажлын тайлан, төлөвлөөний дагуу 13 баяжуулах үйлдвэрүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангаас техник, технологийн холбогдох судалгааг шивж авч мэдээллийн санд оруулав.<br>Уулын ажлын тайлан, төлөвлөөнд тусгагдсан 83 аж ахуй нэгжүүдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангаас судалгаа авснаас Баруун бүсэд олборлолт, ашиглалт явуулж байгаа Төмөр-1 Барилгын материалын-3 Алт-6 Гянтболд-1 техник технологийн судалгаа, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх болон бууруулах арга хэмжээний судалгааг гаргав.<br>- 2014 оны 03 дугаар сарын 11-нд Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд бичил уурхайн талаар өгөх 6 саналыг нэгтгэн боловсруулж УУЯ-нд хүргүүлсэн<br>- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, "Химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах"-ын стандартын төслийн хэлэлцүүлэгт оролцож, санал, дүгнэлт өгсөн.<br>- Хүдэр, хүдрийн бус, шороон ордыг далд аргаар ашиглах аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм"-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн 7 удаагийн хуралдаанд оролцож санал хүргүүлсэн.<br>- Европын холбооны болон ХБНГУ-ын аргачлалыг нутагшуулах, судалгаа хийх "Байгаль орчинд учруулсан хохирол тооцох аргачлал" шинэчлэн боловсруулах, ажлын хэсэгт орж мэдээллээр ханган ажиллаж байна. 2 удаагийн хэлэлцүүлэгт санал өгсөн.<br>Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журамд өөрчлөлт оруулах санал боловсруулж Уул уурхайн сайдын 2013.01.03-ны өдрийн 01 тоот тушаалын дагуу |

| | | |
|---|---|---|
| | | “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн ордын нөхөн төлбөрт үнэлэлт, дүгнэлт өгөх тухай” ажлын хэсэгт хүргүүлэв. |
| **2.8. Уул уурхайн салбарын санхүү, татварын хууль эрх зүйн орчныг сайжруулах.** | | |
| 2.8.1. Уул уурхайн салбарын санхүү, татварын хууль эрх зүй, татварын ачааллын судалгааг шинэчлэн тооцоолж татварын оновчтой хувилбарыг судлах, санал боловсруулах. (жонш, төмөр) | Тоо хэмжээ – 1 судалгааны ажил<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Үнэн зөв, үндэслэл сайтай хэрэгжихүйц байна | Энэ ажлын хүрээнд дараах судалгааны ажлууд хийгдэж, санал боловсруулсан. Үүнд:<br>А. “Ашигт малтмалын тухай хууль”-д:<br>1. Шинэчилсэн найруулгад орох нэмэлт өөрчлөлтийн саналыг хэлтэс, агентлагийн хэмжээнд нэгтгэн УУЯ-нд АМГ-ын даргын албан тоотуудаар удаа дараа хүргүүлж ажиллав.<br>2. Шинэчилсэн найруулгад орох нэмэлт өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын хэсэгт 3-р сарын 3-7-ны өдрүүдэд орж ажиллан төслийг боловсруулж дуусган ажлын хэсэг холбогдох яамдуудаас санал авч нэгтгэн Уул уурхайн сайдын зөвлөлд танилцуулав.<br>3. Алтны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох талаар холбогдох судалгаа хийж, санал боловсруулан Уул уурхайн яамны н.Тамирт 1 дүгээр сарын 20-нд tamir@mm.gov.mn цахим хаягаар хүргүүлсэн<br>4. Шинэчилсэн найруулгад орох нэмэлт өөрчлөлт оруулахаар уулын ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах үүрэг, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх талаар санал өгөх ажлыг зохион байгууллаа.<br>УУЯ-наас төслийг Засгийн Газар, Байнгын хороогоор дэмжүүлж УИХ-д өргөн барьсан нь хэлэлцэгдэж батлагдан 7-р сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлээд байна.<br>Хууль батлагдсантай холбогдуулан хийгдсэн ажлууд:<br>1. Ашигт малтмалын газрын даргын 2014 оны 07 сарын 07-ны өдрийн а-46, а-47, а-49 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэгт холбогдох мэргэжилтнүүд орж ажиллан дараах журмын төслүүдийг боловсруулан, саналаа өгч Уул уурхайн яаманд хүргүүлсэн.<br>Үүнд:<br>“Стратегийн ач холбогдол бүхий ордын хил заагийг тогтоох” тухай Засгын газрын тогтоолын төсөл<br>“Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг хүлээн авах журам”-ын төсөл<br>“Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төсөл<br>“Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам” |

| | | |
|---|---|---|
| | | “Ашигт малтмалын баялаг, ордын нөөцийн ангилал, заавар”-ын төсөл<br>“Орд ашиглах гэрээний загвар”-ын төсөл<br>“Уулын ажлын төлөвлөгөө, тайлан хүлээн авах заавар”-ын төсөл<br>“Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай байгуулах гэрээний загвар”-ыг төсөл<br>“Монгол улсын нутаг дэвсгэрт хийгдсэн геологийн судалгааны тайлан, ашигт малтмалын ордыг ашиглах баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэшсэн мэргэжилтэнүүдээс бүрдсэн гишүүдтэй ЭБМЗ байгуулах, түүний дүрэм, шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлал”<br>“Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын төрийн бус байгууллагатай хамтран ашигт малтмалын баялаг, ордын нөөц, хайгуулын ажлын үр дүнг нийтэд нээлттэй тайлагнах журам”-ын төсөл<br>АӨҮАГэрээг шинэчлэн бүртгэх түр журамын төсөл<br>Нэгтгэсэн төслийг ажлын хэсгийн нарийн бичиг болон УУЯ-ны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын УУБХ-ийн дарга н.Нэргүйд цахимаар хүргүүлсэн.<br>2. “Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний жил, сар, долоо хоногийн биелэлтийн мэдээ, тайланг ирүүлэх, хүлээн авч дүгнэх гэрээ”-ний загварыг боловсруулав.<br>3. 2014.03.11-ний өдөр БОНХ-ийн яаман дээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, “Химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах”-ын стандартын төслийн хэлэлцүүлэгт оролцож, санал, дүгнэлт өгөв.<br>4. 2014.09.04-ны өдөр “Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төслийг Уул уурхайн яамны СБТГ, УУБХ-ээр журмын төслийг хэлэлцүүлэв.<br>5. Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын төслийг тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй 8-н баяжуулах үйлдвэрүүдийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэв. Мөн журмын талаар Ашигт малмал баяжуулагчдын холбоотой уулзалт зохион байгуулав.<br>6. 2014.09.10-ны өдөр 5-5108 тоотоор Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын төсөлд тусгай зөвшөөрөлгүй |

| | | |
|---|---|---|
| | | баяжуулах үйлдвэр болон Нүүрсний хэлтсийн саналыг тусган, Уул уурхайн яаманд хүргүүлэв.<br>7. “Уулын ажлын төлөвлөгөө, тайлан хүлээн авах заавар, гэрээг АМГ-ын даргын 2014 оны 9-р сарын 22-ны өдрийн а-80, а-81, уулын ажлын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан хүлээн авах маягтын загварын төслийг боловсруулж, 2014 оны 10-р сарын 2-ны өдрийн а-86, хэлтсийн дотоод заавeрыг 2014 оны 11-р сарын 5-ны өдрийн а-100 тоот тушаалуудаар тус тус батлуулан ажиллаж байна.<br>8. АМТХ-ийн 42.1-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах гэрээний төслийг сайжруулан боловсруулж 2014.11.03-нд цахимаар УУЯ-ны мэргэжилтэн н.Хуланд khulan@mm.gov.mn хаягаар хүргүүлсэн.<br>9. Хүдэр, хүдрийн бус, шороон ордыг далд аргаар ашиглах аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт ажилласан.<br>10. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй “Химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах”-ын стандартын төслийн хэлэлцүүлэгт оролцож 2014 оны 6 дугаар сарын 9 өдрийн 5-3722 тоот албан хүсэлтээр санал, дүгнэлт өгөв.<br>11. Уулын ажлын тайлан төлөвлөгөө хүлээн авах цахим системийн маягтыг өөрчилж сайжруулахтай холбоотой ажил хийгдсэн байна.<br>12. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны тухай гэрээ байгуулах журам болон гэрээний танилцах хуудасны загварыг шинэчлэн боловсруулан өөрчлөлт оруулах саналыг боловсруулан ажлын хэсэгт хүргүүлсэн.<br>Б. “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль”-д:<br>1. Шинэчилсэн найруулгад орох нэмэлт өөрчлөлтийн саналыг хэлтэс, агентлагийн хэмжээнд нэгтгэн УУЯ-нд АМГ-ын даргын албан тоотуудаар удаа дараа хүргүүлж ажиллав.<br>Хууль батлагдсантай холбогдуулан хийгдсэн ажлууд:<br>Уул уурхайн сайдын 2014.02.13-ны өдрийн 38 тоот тушаал, Ашигт малтмалын газрын даргын 2014.02.19-ний өдрийн а-11 тоот тушаалуудын дагуу “Нийслэл болон аймгуудын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох журам” боловсруулсан.<br>Түгээмэл тархацтай ашигт малтмалын Уулын ажлын тайлан, төлөвлөгөөний маягтуудыг боловсруулсан.<br>В. “Газрын хэвлийн тухай хууль”-д: |

| | | |
|---|---|---|
| | | Шинэчилсэн найруулгад орох нэмэлт өөрчлөлтийн саналыг хэлтэс, агентлагийн хэмжээнд нэгтгэн УУЯ-нд АМГ-ын даргын албан тоотуудаар удаа дараа хүргүүлж ажиллав.<br>шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан 5-р сарын 27-29-ний өдрүүдэд төслийг эцэслэн боловсруулж УУЯ-нд хүргүүлээд байна.<br>Г. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”:<br>1. 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан журамыг шинэчлэн боловсруулж төслийг Уул уурхай, эрчим хүчний яаманд 2014 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 1-6099 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Д. ОҮИТБС-ын тухай бие даасан хууль:<br>1. Санал боловсруулан УУЯ-ны мэргэжилтэн н.Зууннастад zuunnast@mm.gov.mn цахим хаягаар 2014.01.21-нд хүргүүллээ. |
| **2.9. Ашигт малтмалыг экспортод гаргахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, эрдэс баялгийн экспортыг нэгдсэн “Нэг цонх”-ны бодлогоор хэрэгжүүлэх арга хэмжээ авна.<br>/ЗГҮАХХАХТ - 41.1-р заалт/** | | |
| 2.9.1. Экспортод гарч буй ашигт малтмалын талаар судалгаа хийж, дүгнэлт гаргах | Тоо хэмжээ –<br>Судалгааны ажлын 1 дүгнэлт<br>Хугацаа – жилдээ<br>Чанар -Үнэн зөв, үндэслэл сайтай байна | - УУЯ-нд Дэлхийн банкны дэмжлэгээр хэрэгжиж байгаа Уурхай, хилийн боомт дахь ашигт малтмалын экспортыг хялбарчлах менежмент, мониторингийн системийг бий болгох зөвлөх үйлчилгээ үзүүлж буй “Crown Agents” компаний инженер, шинжээчидтэй 2014 оны 04 дүгээр сард уулзаж уул уурхайн бүтээгдэхүүн экспортлоход Гаалийн ерөнхий газартай хэрхэн мэдээлэл солилцож буй талаар мэдээлэл өгч, санал солилцов.<br>-Ашигт малтмал экспортлож байгаа аж ахуйн нэгжүүдтэй уулзалт хийж, уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоход мөрдөгдөж байгаа одоогийн эрх зүйн орчин, бодит байдалтай танилцаж тулгарч буй хүндрэлтэй асуудлууд, тэдгээрийг сайжруулах арга замын талаар санал авав. |
| 2.9.2. Улсын хилээр гадаргуун болон гүний усны шинжилгээ, баяжуулалт, хагас үйдвэрлэл, технологийн туршилт, шинжилгээний зориулалтаар ашигт малтмалын хүдэр, баяжмал, чулуулгийн дээж нэвтрүүлэх тухай тодорхойлолтыг журмын дагуу харъяа гаалийн хороо, газарт гаргаж өгөх. | Тоо хэмжээ – Ирүүлэх хүсэлтийн тоогоор<br>Хугацаа – Тухай бүр<br>Чанар – Хууль журмын дагуу үнэн бодитой, тавигдах шаардлагад нийцсэн байна | - ААН-ийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, орд газрын шинжилгээ судалгаа хийлгэх шаардлагыг судлаад Монгол улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэх **181** тодорхойлолт гаргаж журмын дагуу харъяа гаалийн хороо, газарт хүргүүллээ. |
| 2.9.3. Эрдэс баялгийн экспортыг нэгдсэн | Тоо хэмжээ – 1 ажил | Ашигт малтмалыг экспортод гаргахтай холбоотой эрх зүйн орчныг |

| | | |
|---|---|---|
| “Нэг цонх”-ны бодлогын талаа судалгаа, мэдээллээр холбогдох байгууллага, ажлын хэсгийг хангаж ажиллах | үйлчилгээ<br>Хугацаа – Тухай бүр<br>Чанар -Үндэслэл сайтай, үнэн зөв хэрэгжихүйц бодитой байна | бүрдүүлэх судалгаа хийж санал боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх ажлын хүрээнд:<br>- УУЯ-нд Дэлхийн банкны дэмжлэгээр хэрэгжиж байгаа Уурхай, хилийн боомт дахь ашигт малтмалын экспортыг хялбарчлах менежмент, мониторингийн системийг бий болгох зөвлөх үйлчилгээ үзүүлж буй “Crown Agents” компаний инженер, шинжээчидтэй 2014 оны 04 дүгээр сард уулзаж уул уурхайн бүтээгдэхүүн экспортлоход Гаалийн ерөнхий газартай хэрхэн мэдээлэл солилцож буй талаар мэдээлэл өгч, санал солилцов.<br>-Ашигт малтмал экспортлож байгаа аж ахуйн нэгжүүдтэй уулзалт хийж, уул уурхайн гаралтай бүтээгдэхүүнийг экспортлоходоход мөрдөгдөж байгаа одоогийн эрх зүйн орчин, бодит байдалтай танилцаж тулгарч буй хүндрэлтэй асуудлууд, тэдгээрийг сайжруулах арга замын талаар санал авав.<br>Улсын хилээр гадаргуун болон гүний усны шинжилгээ, баяжуулалт, хагас үйдвэрлэл, технологийн туршилт, шинжилгээний зориулалтаар ашигт малтмалын хүдэр, баяжмал, чулуулгийн дээж нэвтрүүлэх тухай тодорхойлолтыг холбогдох журмын дагуу харъяа гаалийн хороо, газарт гаргаж өгөх ажлын хүрээнд:<br>- Нэг цонхны бодлогын талаар НҮБ-аас гаргасан бичиг баримт, олон улсад хэрэглэгдэж буй байдлын талаар материал цуглуулан орчуулж байна.<br>- “Монголын төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбоо”-ноос боловсруулж буй Уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэг цонхны бодлогоор хэрэгжүүлэх журмын төсөлтэй танилцаж байна.<br>Эрдэс баялгийн экспортыг нэгдсэн “Нэг цонх”-ны бодлогыг боловсруулах талаар санал боловсруулж холбогдох байгууллага болон УУЯ-нд хүргүүлэх ажлын хүрээнд:<br>-Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга, Монгол улсын Гаалийн ерөнхий газрын даргын хамтран баталсан 2007 оны 471/816 дугаар тушаалын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн 2014 оны уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн 2014 онд улсын хилээр экспортлох бүтээгдэхүүний тодорхойлолтыг Гаалийн ерөнхий газарт хүргүүлэв. |
| 2.9.4. Ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэрлэл эрхлэгчдийн экспортод гаргах бүтээгдэхүүний тодорхойлолтыг уулын | Тоо хэмжээ – 2 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ | - Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга, Монгол улсын Гаалийн ерөнхий газрын даргын хамтран баталсан 2007 оны 471/816 дугаар тушаалын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл |

| | | |
|---|---|---|
| ажлын төлөвлөгөө, сар, улирлын мэдээнд түшиглэн Гаалийн ерөнхий газарт гаргаж хүргүүлж байх, судалгаа хийж оны эцэст мэдээлэл бэлтгэн УУЯ-д хүргүүлэх. | Чанар -Үнэн бодитой, тавигдах шаардлагад нийцсэн байна | эзэмшигчдээс ирүүлсэн 2014 оны уулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн 2014 онд улсын хилээр бүтээгдэхүүн экспортлох 56 ААН-ийн тодорхойлолтыг тухай бүрд нь Гаалийн ерөнхий газарт хүргүүлж байна. |
| **2.10. Стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийг нэгтгэн, корпорацийн зохион байгуулалтад оруулна. /ЗГҮАХХАХТ – 43.2-р заалт/ 2013-2014 /0 ₮/** | | |
| 2.10.1. Стратегийн ач холбогдол бүхий ордын төрийн эзэмшлийг нэгтгэн, корпорацийн зохион байгуулалтад оруулах талаар санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх. | Тоо хэмжээ – 1 санал<br>Хугацаа - жилдээ<br>Чанар –Хэрэгжихүйц, үнэн бодитой, тавигдах шаардлагад нийцсэн байна | Стратегийн ордод хамруулахаар уламжлагдсан алтны үндсэн 1 орд, газрын ховор элементийн 4 орд, нүүрсний 2 ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар хийгдсэн ажлууд:<br>- саналыг аж ахуйн нэгжүүдээс албан бичгээр авах бэлтгэл ажлыг хангаан хаяг бүртгэлийн шинэчилсэн мэдээллийг боловсруулж УУЯ-ны УУБГ-ын ахлах мэргэжилтэн, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Дамбад цахимаар хүргүүлж ажилласан.<br>- аж ахуйн нэгжүүдийн удирдлагуудтай холбогдон, УУЯ-ны БХЗГ-ын дарга, ажлын хэсгийн ахлагч Батхүүгийн өрөөнд уулзалт зохион байгуулж, төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар тодорхой саналаа албан бичгээр ирүүлэхээр тохиролцсон.<br>- аж ахуйн нэгжүүдийн холбогдох хүмүүстэй цахим шуудангаар холбогдон саналуудыг цахимаар авч мөн УУЯ-нд ирүүлсэн албан бичгүүдийг цахимаар авч, нэгтгэн УУЯ-ны БХЗГ-ын дарга, ажлын хэсгийн ахлагч Батхүү, нарийн бичгийн дарга Дамба, Ган-Очир нарт цахимаар хүргүүлж ажилласан.<br>2. Бүрэнхааны ордын ба тусгай зөвшөөрлийн хил хязгаарт хамааргдах нөөцийг тооцсон тооцоо, талбайн хэмжээний харьцуулалт, байгаа болон цуцлагдсан тусгай зөвшөөрлүүдийн түүхийн мэдээлэл, ордын танилцуулга, фосфорын хүдэр олборлох, боловсруулах үйлдвэрийн судалгаа, байршлийн зураг, нөөцийн хил хязгаар, тусгай зөвшөөрлийн талбайг буулгасан зураг, төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар санал, аж ахуйн нэгжийн ирүүлсэн албан бичгийн хуулбар зэрэг мэдээлэл бэлтгэн УУЯ-нд 2014-01-10-ны өдрийн 4-106 тоот албан бичгээр хүргүүлэв. Мөн 01.29-нд цахимаар ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Дамбад явуулав.<br>3. Уул уурхайн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 01 тоот тушаалаар байгуулагдсан "Стратегийн ач холбогдол бүхий Цагаансуваргын орд болон стратегийн ордод хамааруулах боломжтой Гацуурт, Цайдамнуур, Хөшөөтийн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар яриа хэлэлцээ хийх |

| | | |
|---|---|---|
| | | үүрэг бүхий Ажлын хэсэг”-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.<br>4. Бороо гоулд ХХК-ний Бороогийн алтны уурхайн ТЭЗҮ, 2003-2013 онуудын үйл ажиллагааны гүйцэтгэл, Сентерра гоулд ХХК-ний Гацууртын алтны уурхайн 2008 оны ТЭЗҮ, 2012 оны ТЭЗҮҮ-ийг архив, НЭЗТ, аж ахуйн нэгжээс авч, нөөц, эдийн засгийн үзүүлэлтүүдийг түүвэрлэн, тэдгээрийг харьцуулсан судалгаа хийж ажлын хэсэгт 2014.01.10-нд хүргүүлэв.<br>5. Цагаансуваргын зэс-молибдений орд, Гацууртын алтны үндсэн орд, Хөшөөтийн нүүрсний орд, Цайдам нуурын нүүрсний ордуудын танилцуулга мэдээлэл, тусгай зөвшөөрлийн жагсаалт, тусгай зөвшөөрлийн хуулбар, нөөц хүлээн авсан хурлын протоколын хуулбар, ордын ба тусгай зөвшөөрлийн хил хязгаарт хамаарагдах нөөц, талбайн хэмжээ, байршлийн зураг, нөөцийн хил хязгаар, хил хязгаарыг шинэчлэх санал, аж ахуйн нэгжүүдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаарх санал, ирүүлсэн албан бичгийн хуулбар, тусгай зөвшөөрлийн талбай, нөөц, нөөцийн хил хязгаарыг буулгасан зураг зэрэг шинэчлэн боловсруулсан мэдээллийг УУЯ-ны ажлын хэсгийн нарийн бичгийн дарга С.Ган-Очирт цаасаар хүргүүлэв.<br>6. 2014.01.13, 16-ны өдрүүдэд 2 удаа Гацууртын алтны ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч Сентерра гоулд ХХК-ний удирдлагуудтай төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар уулзалт зохион байгуулж, хурлын тэмдэглэл хөтөлсөн.<br>7. 2014.01.21-ны өдөр Цагаан суваргын ордын тусгай зөвшөөрлийн эзэмшигч “МАК” ХХК-ний удирдлагуудтай төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар уулзалт зохион байгуулж, хурлын тэмдэглэл хөтөлсөн.<br>8. Дээрх 3 уулзалтын хурлын протокол бичиж дуусган 2014.01.22-ны өдөр УУЯ-ны БХЗГ-ын дарга, ажлын хэсгийн ахлагч Батхүү, нарийн бичгийн дарга Ган-Очир нарт цаасаар хүргүүлж ажилласан.<br>9. 2014.01.23-нд Төрийн эзэмшлийн хувь хэмжээ хэд байх талаар ажлын хэсэг хуралдаж, төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар төрийн байр суурийг тогтон, саналыг бичин ажлын хэсгийн ахлагч Батхүү, нарийн бичгийн дарга Ган-Очир нарт сайдад танилцуулахаар цаас, цахимаар хүргүүлж ажилласан.<br>10. Бүрэнхааны ордын нөөцийг тооцсон тооцоог ахин хянаж цахимаар ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Дамбад явуулав.<br>11. Уул уурхайн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 01 тоот |

| | | |
|---|---|---|
| | | тушаалаар байгуулагдсан “Стратегийн ач холбогдол бүхий Цагаансуваргын орд болон стратегийн ордод хамааруулах боломжтой Гацуурт, Цайдамнуур, Хөшөөтийн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар яриа хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг”-ийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.<br>Хийгдэж байгаа ажлууд:<br>Ажлын хэсэг Төрийн эзэмшлийн хувь хэмжээ Цагаансуварга, Гацууртын ордод хэд байх талаар хуралдаж, төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар төрийн байр суурийг тогтон, санал солилцон, Сангийн яамны мэргэжилтэнгийн хийсэн эдийн засгийн тооцоотой танилцсан.<br>12. Стратегийн ач холбогдол бүхий Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг судлах ажлын хэсгийн гишүүн Б.Магванжавт хэрэгтэй мэдээллийг гаргаж өгөв.<br>13. Стратегийн ордод хамруулахаар уламжлагдсан Лугийн голын газрын ховор элементийн орд, Мушгиа худагийн газрын ховор элементийн орд, Хотгорын газрын ховор элементийн орд, Халзан бүргэдэйн газрын ховор элементийн ордуудын төрийн эзэмшлийн хувь хэмжээ тогтоох аж ахуйн нэгжүүдээс ирсэн саналыг бэлгэсэн мэдээлэлд хавсаргав.<br>14. Стратегийн ач холбогдол бүхий Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг судлах ажлын хэсгийн гишүүн Магванжавт ордтой холбоотой геологи, нөөц, ТЗ, эдийн засгийн судалгааны танилцуулга материалыг бэлтгэж өгөв.<br>15. Дээрх материалыг Сайд Баян-өлгий аймагт ажиллахад зориулж хэлтсийн дарга С.Баттулгад бэлтгэж өгөв.<br>16. Уул уурхайн сайдын 2014 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 01 тоот тушаалаар байгуулагдсан “Стратегийн ач холбогдол бүхий Цагаансуваргын орд болон стратегийн ордод хамааруулах боломжтой Гацуурт, Цайдамнуур, Хөшөөтийн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар яриа хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг”-ийн ээлжит хуралдаанаар Сентарра гоулд, МАК ХХК-ний удирдлагуудтай уулзалт хийв.<br>17. 2014.03.28-нд МАК ХХК-ний удирдлагуудтай хийсэн уулзалтын протоколыг бичиж дуусган УУЯ-ны БХЗГ-ын ахлах мэргэжилтэн, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга С.Ган-Очирт цахимаар хүргүүлэв.<br>18. 04.07-нд Сентарра гоулд ХХК-ний удирдлагуудтай уулзалт хийв, төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар тохиролцоонд хүрсэнгүй өөр өөрийн байр сууриа хэвээр нь хадгалав, |

| | | |
|---|---|---|
| | | 19. 04.08-нд МАК ХХК-ний удирдлагуудтай уулзалт хийв, төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар тохиролцоонд хүрсэнгүй өөр өөрийн байр сууриа хэвээр нь хадгалав, Засгийн газарт оруулахаар шийдвэрлэв.<br>20. Төрд үнэгүй эзэмшүүлэх хувь эзэмшлийн эдийн засгийн тооцоон дээр судалгаа хийж байна<br>21. 04.9-нд Хувь эзэмшлийн эдийн засгийн тооцоон дээр 2 талын эдийн засагчдыг ахин хамтран ажиллуулахаар тохиролцсоны дагуу уулзалт зохиов. 2 компаний тооцооны талаар ярилцан, тооцоог цахимаар аван ажлын хэсгийн гишүүд СЯ, ЭЗЯ-ны эдийн засагчдад цахимаар хүргүүлэн ажиллаж байна.<br>22. Ажлын хэсэг хуралдаж, төрийн эзэмшлийн хувь хэмжээний талаар төрийн байр суурийг тогтон, саналыг бичин ажлын хэсгийн ахлагч Батхүү, нарийн бичгийн дарга Ган-Очир нарт Сайдад танилцуулахаар цаас, цахимаар хүргүүлж ажилласан.<br>23. 05.01-05.09 Ажлын хэсэг хуралдаж, Цагаан суваргын ордод төрийн эзэмшлийн хувь хэмжээ хэд байх талаар төрийн байр суурийг тогтон, санал танилцуулга бэлтгэн ажлын хэсгийн ахлагч Батхүү, нарийн бичгийн дарга Дашбал нарт цаасаар хүргүүлж ажилласан.<br>24. Энэ танилцуулгатай сайд танилцаад, нэмж оруулах шаардлагатай гэж үзсэн хөрөнгө оруулалтын хэмжээ, дэд бүтэц болон бусад хөрөнгө оруулалтын хэмжээг задалж саналд нэмж оруулан, нарийн бичгийн даргад сайдад танилцуулахаар цаас, цахимаар хүргүүлж ажилласан.<br>25.05.12-15 Гацуурт, Цайдам нуурын ордын танилцуулгыг шинэчлэн боловсруулж, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Дашбалд цахимаар хүргүүлж ажилласан.<br>26.05.19-нд Бүрэнхааны ордын танилцуулга, хил хязгаар болон нөөцийн дэвсгэр зурган дээр тусгай зөвшөөрлүүдийн талбайг буулгасан зургийг хэвлэн ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Дашбалд цаасаар хүргүүлэв.<br>27. 05.28-нд Эдийн засгийн байнгын хороо “Цагаан суваргын төрийн эзэмшлийн хувь тогтоох тухай” УИХ-ын тогтоолын төслийг /05.23-нд ЗГ-аас өргөн мэдүүлсэн/ УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх зүйтэй гэж үзэв. /34%/<br>28. 5.29-нд Цагаансуваргын ордын ТЭЗҮ-ийн улсын төсөвт оруулах татвар, төлбөр, шимтгэлийн нийлбэр, NPV, IRR болон борлуулах үнийн мэдээллийг гаргаж ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Дашбалд |

| | | |
|---|---|---|
| | | утсаар холбогдон өгч ажилласан.<br>29. 05.28-29-нд Бүрэнхаан, Асгатын ордын танилцуулгыг УУЯ-ны БХЗГ-ын ахлах мэргэжилтэн, ажлын хэсгийн нарийн бичгийн даргад цахимаар хүргүүлэв. |
| **2.11. Алтны олборлолт, хадгалалт, борлуулалтыг ил тод болгох механизмыг бүрдүүлэх асуудлыг алт олборлогч аж ахуйн нэгж, байгууллага, Монголбанктай хамтран зохион байгуулж хэрэгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ-44.1 заалт/** | | |
| 2.11.1. Үнэт металл олборлох, тээвэрлэх, тушаах журмын талаар судалгаа, мэдээллээр холбогдох байгууллага, ажлын хэсгийг хангаж ажиллах | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа – Тухай бүр<br>Чанар - Үндэслэл сайтай, хэрэгжихүйц бодитой мэдээлэл байна | -Үнэт металл олборлох, тээвэрлэх, тушаах журмын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн 2014 оны 1-р сард УУЯ-н дахь ажлын хэсэгт хүргүүллээ.<br>- Тухайн ажлын хэсэг Монгол банктай хамтран Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулж алтны АМНАТ-ийг 2.5% болгон бууруулсан.<br>-Үнэт металл олборлох, тээвэрлэх, тушаах журмын төслийг боловсруулан холбогдох байгууллагуудаас ирүүлсэн саналыг нэгтгэн Уул уурхай, эрчим хүчний яаманд хүргүүлсэн Үүнд<br>Монгол банк<br>Мэргэжлийн хяналтын ерөнхий газар<br>Алт үйлдвэрлэгчдын холбоо<br>Стандарчилал хэмжил зүйн газар<br>Уул уурхайн үндэсний ассоциацид |
| **2.12. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах журмын хэрэгжилтийг хангах, дүрэм, заавар, зааварчилгааг сурталчлах ажлыг зохион байгуулах. /ҮХЦБ – 2.1.1; ЗГҮАХХАХТ -45-р заалт/** | | |
| 2.12.1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах журмын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан байгаль орчны нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, баяжуулах цехийн техникийн нөхцөл, нөхөрлөлийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх холбогдох байгууллагыг мэдээллээр хангах. | Тоо хэмжээ –1 дүгнэлт<br>Хугацаа – тогтмол<br>Чанар -Бодитой, үнэн зөв мэдээлэл байна | - Дундговь аймгийн Хулд, Өлзийт сум, Хэнтий аймгийн Бор-Өндөр, Цэнхэрмандал, Бэрх, Батноров, Баян-Адарга, Норовлин сум, Дорнод аймгийн Баян-Уул,Баяндун, Дашбалбар сум, Дорноговь аймгийн Айраг, Иххэт сумдын бичил уурхай эрхлэгчдэд Налайх дахь Уул уурхайн аврах албатай хамтран ХАБЭА-н сургалт зохион байгуулсан.<br>-2014 оны 6 сарын 17-ны өдөр “Бичил уурхай ба алтны худалдаа” сэдэвт хэлэлцүүлэгийг УУЯ, ШХА-н ТБУТ хатран зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Монгол банк, Бичил уурхайчдын нэгдсэн дээвэр холбоо, Алт үйлдвэрлэгчдийн холбоо, Стандартчилал хэмжил зүйн газрын Сорьцын хяналтын хэлтэс, зарим сумдын ИТХ, Засаг дарга, олон улсын байгууллага, олон улсын зөвлөхүүд болон бичил уурхайчидын төлөөлөл оролцов. Бичил уурхайгаар олборлосон алтын борлуулалтын нөхцөл байдал, ил тод болгох, албажуулах, алтыг хууль тогтоомжийн дагуу худалдах болон Монгол банкны Эрдэнэсийн санд худалдах оновчтой тогтолцоог бүрдүүлэх талаар илтгэл тавьж оролцон, санал дүгнэлтийг нэгтгэж УУЯ-нд 5-4317 дугаартай албан тоотоор хүргүүлсэн. |
| 2.12.2. Бичил уурхайн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтыг ил тод болгох механизмыг бүрдүүлэхэд шаардагдах Бичил уурхайн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын судалгааг хийж ажлын хэсэгт орж ажиллах, мэдээллээр хангах. | Тоо хэмжээ – 1 судалгаа, 1 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Бодитой, үнэн зөв мэдээллээр хангаж ажиллана | |
| 2.12.3. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулах | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ | |

| | | |
|---|---|---|
| журмын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан хууль эрх зүй болон байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал цехийн техникийн нөхцөл, эрүүл ахуйн хууль дүрэм, зааврыг мөрдөж ажиллах талаарх сургалт явуулах, дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах | Хугацаа - жилдээ<br>Чанар -Шуурхай, хуулийн хүрээнд | -ШХА-ын ТБУТ-тэй хамтран бичил уурхайчдын алтны худалдаанд оролцож буй нөхцөл байдал, орон нутагт алтны худалдааг хууль ёсны болгох, алт худалдах тогтолцоог бий болгох санал боловсруулах зорилгоор 4 аймгийн 10 суманд нийт 14 ТББайгууллагын 490 гишүүнийг хамруулан санал асуулгын хуудсаар мэдээлэл авсан.<br>Мэдээллийг статистик шинжилгээний программ SPSS 17 ашиглан бодит үр дүн болон харьцуулсан, түүвэр олонлогийн арга ашиглан мэргэжлийн байгууллагаар боловсруулуулсан. Судалгааний тайланг нэгтгэн УУЯ-нд хүргүүлсэн.<br>-ШХА-ийн ТБУТ-тэй хамтран Бичил уурхайн гаралтай алтны Шудрага худалдаа шудрага олборлолт системийг нэвтрүүлэх боломжийг судлах зорилгоор туршилтын ажил хийхээр Франц улсын “Gold by Gold S&P Trading” компанитай гэрээ байгуулан ажиллаж байна. Уг компани Төв аймгийн Борнуур сумын ХАМО ХХК-с худалдан авсан 288,870 грамм алтаар хийгдэх туршилтын ажлын тайлан хүлээгдэж байна.<br>- Азийн сангийн Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь II төсөлийн хүрээнд гар аргаар олборлолт явуулснаас үүдэлтэй эвдрэсэн газрыг жишиг нөхөн сэргээлт хийх, талбай сонгох талаар дүгнэлт гарган ажилласан.<br>Жишиг нөхөн сэргээлтийг нийт 50 суманд хийх талбайн сонголт хийх талаар төслийн багтай хамтран ажиллаж байна. Одоогийн байдлаар Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Рашаантын хөндийд 32га талбайд, Хэнтий аймгийн Нороовлин сумдад нөхөн сэргээлт хийгэгдэж эхэлсэн байна.<br>- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайд дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 24 хүсэлтийг хуулийн дагуу шийдэн, 7 хүсэлтэд бичил уурхайгаар ашигт малтмал олборлох боломжтой тухай дүгнэлт гаргасан.<br>- Эрчим хүчний яамны дэд сайдад Төв аймгийн Заамар сумын талбайн дүгнэлтийн талаар мэдээлэл бэлтгэж өгсөн.<br>- УИХ-ийн Байнгын өргөдлийн хорооны дарга Р.Бурмаа –д бичил уурхайн талбайн дүгнэлтийн мэдээлэл гарган өгсөн.<br>- Уул уурхайн яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүүд 2014 оны 6 дугаар сарын 26-нд бичил уурхайн дүгнэлт гаргуулахаар ирсэн хүсэлт болон талбайн давхацалын судалгаа” гаргаж мэдээ бэлтгэж өгсөн.<br>- Бичил уурхайн үйл ажиллагаа явагддаг сумдын Засаг дарга нартай |
| 2.12.4. Бичил уурхайгаар ашиглах талбайд дүгнэлт гаргах, нэгдсэн бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулах, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Шуурхай, хуулийн хүрээнд | |
| 2.12.5. Бичил уурхайгаар олборлосон ашигт малтмалыг боловсруулах, баяжуулахад “Баяжуулах цехэд тавигдах техникийн нөхцөл”-ийг боловсруулж батлуулах | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар –Техникийн нөхцөл батлагдан мөрдөгдөнө | |

| | | |
|---|---|---|
| | | холбогдож, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай журмын дагуу бичил уурхайн болон хувиараа ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны талаарх мэдээллээ ирүүлэх маягтуудыг сумдын Засаг дарга нарт е-мэйлээр хүргүүлэв. |
| **2.13. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журамд орон нутгийн удирдлагын хүлээх хариуцлагыг тодорхой тусгаж, хэрэгжилтэд нь тавих хяналтыг сайжруулах чиглэлээр холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулна. /ЗГҮАХХАХТ-45.1 заалт/** | | |
| 2.13.1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагааг зохицуулахтай холбогдох хууль, дүрэм, журмын төсөлд санал боловсруулж өгөх. | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Үндэслэл сайтай, хэрэгжихүйц бодитой байна | ЗГ-ын 2010 оны 308 дугаар тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулж төслийг Уул уурхай, эрчим хүчний яаманд 2014 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 1-6099 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>Засгийн газрын 308-р тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд:<br>ШХА-ын Тогтвортой бичил уурхай төслийн багтай хамтран томилолтоор ажиллах ажлын удирдамжийн төсөл боловсруулсан.<br>Томилолтоор ажиллах явцдаа орон нутгийн удирдлага болон бичил уурхай эрхлэгчдийн журманд өгөх саналыг авах саналын хуудас боловсруулсан. |
| **2.14. “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын зарчим болон шалгуурыг хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагууд-тай хамтран хэрэгжүүлж, ил тод байдлыг хангана. /ЗГҮАХХАХТ-46.1 заалт/** | | |
| 2.14.1. “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-ын зарчим болон шалгуурыг хувийн хэвшил, төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжилтийг хангаж ажиллана. | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - тогтмол<br>Чанар - Шуурхай, үр дүнтэй байна | 1. 2012 оны нэгтгэл тайланд гарсан мөнгөн бус хандивын зөрүүний тухай тайлбарыг 2014 оны 3 сарын 3-ны өдрийн 1-875 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>2. 2013 оны ОҮИТБС-ын тайлангийн явцын талаарх танилцуулга бэлтгэн 2014 оны 3-р сарын 11-нд ОҮИТБС-ын ажлын хэсгийн хуралд танилцуулсан.<br>3. Олборлолт, борлуулалт хийсэн ААН-үүдийн жагсаалтыг ОҮИТБС-ын ажлын албанд 2014.03.01-нд eiti.secretariat.mn@gmail.com цахим хаягаар хүргүүлсэн.<br>4. Аудитын нэгтгэл тайланд хамрагдах компанийг сонгох шалгуур үзүүлэлтийн талаарх саналыг ОҮИТБС-ын ажлын албанд 2014.05.20-нд eiti.secretariat.mn@gmail.com цахим хаягаар хүргүүлсэн.<br>5. Дорноговь аймгийн Даланзадгад, Дундговь аймгийн Баянжаргалан сумдад 2014.10.27-нд зохион байгуулагдсан ОҮИТБС-ын өдөрлөгт зориулан тухайн аймаг, сумдад хамаарагдах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тухай танилцуулга хийсэн. |

| | | |
|---|---|---|
| | | 6. Дархан-уул аймгийн Шарын гол, Сэлэнгэ аймгийн Баянгол, Орхон аймгийн Баян-Өндөр сумдад 2014.11.10-нд зохион байгуулагдсан ОҮИТБС-ын өдөрлөгт зориулан тухайн аймаг сумдад хамрагдах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн танилцуулга хийсэн. |
| 2.14.2. ОҮИТБС-ын тайлангийн 1, 2 дугаар маягтаар тайлан гаргасан аж ахуйн нэгжүүдийн тухайн жилд үйлдвэрлэсэн, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ болон эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг ОҮИТБС-ын маягт 7-д нэгтгэж танилцуулга бичин Ил тод байдлын санаачлагын бие даасан алба болон АМГ-ын вэб сайтад байрлуулах | Тоо хэмжээ – 1 танилцуулга, 1 арга хэмжээ<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар - Мэдээлэл ил тод, хүртээмжтэй байна | 1. 2013 онд ААН-үүдээс ирүүлсэн уулын ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн талаар судалгааг “Улаанбаатар аудит” ХХК-д 2014.10.15-нд delgermaa@ulaanbaatar-audit.mn цахим хаягаар хүргүүлсэн.<br>2. 2013 онд уулын ажлын тайлан ирүүлээгүй, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний гүйцэтгэл гаргаж өгөөгүй ААН-үүдийн нэрс гаргаж Улаанбаатар аудитад 2014.10.15-нд delgermaa@ulaanbaatar-audit.mn цахим хаягаар хүргүүлсэн.<br>3. 2013 оны нэгтгэл тайланд хамрагдаж байгаа компаниудын уулын ажлын төлөвлөгөө, тайлан өгсөн эсэх талаарх судалгааг “Улаанбаатар аудит” ХХК-д 2014.10.15-нд delgermaa@ulaanbaatar-audit.mn цахим хаягаар хүргүүлсэн.<br>4. 2013 онд хийгдсэн томоохон хэмжээний хайгуулын үйл ажиллагааны талаарх мэдээллийг “Улаанбаатар аудит” ХХК-д 2014.10.15-нд цахимаар хүргүүлсэн.<br>5. Олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаа төвлөрөн явагдаж буй гол бүс нутгийн тухай мэдээллийг “Улаанбаатар аудит” ХХК-д 2014.10.20-нд delgermaa@ulaanbaatar-audit.mn цахим хаягаар хүргүүлсэн.<br>6. Үйлдвэрлэлийн нийт хэмжээ, үнийн дүнг ашигт малтмалын төрөл бүрээр бэлтгэн “Улаанбаатар аудит” ХХК-д 2014.10.20-нд delgermaa@ulaanbaatar-audit.mn цахим хаягаар хүргүүлсэн.<br>7. Тусгай зөвшөөрлийн бүртгэл, олголтын талаарх мэдээллийг “Улаанбаатар аудит” ХХК-д 2014.10.20-нд delgermaa@ulaanbaatar-audit.mn цахим хаягаар хүргүүлсэн. |
| **2.15. “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга”-ын зарчим, стандартыг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ – 46.2/** | | |
| 2.15.1. “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх санаачилга”-ын зарчим, стандартыг төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжилтийг хангаж ажиллана. | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - тогтмол<br>Чанар - Шуурхай, үр дүнтэй байна | 30 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дунд “Хариуцлагатай уул уурхайн индексийг хэрхэн тооцох тухай” сургалтыг “Тогтвортой хөгжлийн төлөөх хариуцлагатай уул уурхай” ТББ-тай хамтран 2014 оны 2-р сарын 26-нд зохион байгуулав.<br>- Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хариуцлагын индексийг тооцох аргачлалыг байгууллагын вэб сайтад байршуулсан. |
| **2.16. Засгийн газраас баталсан хил хязгаарын дагуу “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллана.** | | |

| /ЗГҮАХХАХТ-47.1 заалт/ | | |
|---|---|---|
| 2.16.1. Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн талаар судалгаа, мэдээллээр холбогдох байгууллага, ажлын хэсгийг хангаж ажиллах | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа – Тухай бүр<br>Чанар -Шуурхай зохион байгуулан ажиллана | 1. "Гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын төслийг судлан, дүгнэлт гаргах ажлын хүрээнд УИХ-ын даргын өгсөн үүргийн дагуу урт нэртэй хуульд хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд олгох нөхөх олговрын хэмжээг урьдчилсан байдлаар гаргаж УИХ-ын ажлын хэсэгт 2 удаа, Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралд 2 удаа танилцуулсан.<br>2. Засгийн газрын 194-р тогтоолын хэрэгжүүлэх хүрээнд шийдвэрлэсэн тусгай зөвшөөрлийн талаар түүхчилсэн танилцуулга бэлтгэж 2014 оны 1-р сард Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүүд хүргүүлсэн.<br>3. Засгийн газрын 194-р тогтоолд хамрагдсан 488 тусгай зөвшөөрлийг аймаг бус бүрээр нь гаргаж Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүүд болон УИХ-ын байнгын хороонд хүргүүлсэн.<br>- Усны хамгаалалтын бүстэй 50%-ын давхцалтай 151 тусгай зөвшөөрөл болон усны хамгаалалтын бүстэй 200м-т давхцалтай 99 тусгай зөвшөөрлийн судалгааг Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүүд УИХ-ын байнгын хороонд цахим шуудангаар хүргүүлсэн.<br>- Засгийн газрын 194 дүгээр тогтоолд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг УИХ-ын байнгын хороонд хүргүүлсэн.<br>- Засгийн газрын 194 дүгээр тогтоолд хамрагдсан алтны тусгай зөвшөөрлүүдийн олгосон болон дууссан огноо, Монгол банкинд тушаасан алтны хэмжээг уулын ажлын тайлантай тулгалт хийн алтаа тушаагаагүй ААН жагсаалтыг тус тус гаргаж УИХ-ын байнгын хороонд 2014 оны 3 сард хүргүүлсэн.<br>- Хуульд хамрагдсан 488 тусгай зөвшөөрлийг БОНХЯ-тай хамтарч эвдэрэлд орсон талбайн хэмжээг гаргаж УИХ-ын гишүүн Д.Арвин болон БОХХААБайнгын хороо, УУЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүүд хүргүүлсэн.<br>- БОНХЯ-аас ирүүлсэн хилийн заагийг 200м тогтоосон ашиглалтын 488 тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй судалгааг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж УИХ-ын БОХХААБайнгын хороо болон УИХ-ын гишүүн Д.Арвинд хүргүүлсэн. |

| | | |
|---|---|---|
| | | - “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Байгаль орчин, хүнс хөдөө аж ауйн байнгын хорооны ажлын хэсгийн дэд ажлын хэсгийн өгсөн үүргийн дагуу хуульд хамрагдсан хайгуулын 845 тусгай зөвшөөрлийн судалгааг гаргаж УИХ-ын гишүүн Д.Арвин болон БОХХААБХ, УУЯ-ны БХЗГ-ын дарга Б.Батхүүд хүргүүлсэн.<br>- Засгийн газрын хуралдаанд оруулах материалын эхийг УУЯ-нд бэлтгэж (Их тохойрол ХХК 4121А, 7712А, 7713А, Монголросцветмет ХХК-ийн Түйнголын ордын талаар) өгсөн.<br>- “Их тохойрол” ХХК-ийн 3 тусгай зөвшөөрлийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх ажлын хэсгийн хүрээнд тусгай зөвшөөрлийн талаар мэдээлэл бэлтгэж УУЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүүд хүргүүлсэн.<br>- “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох” тухай хуулийн хэрэгжилтийн тухай болон Засгийн газрын 194-р тогтоолд хамрагдан нөхөх олговор авах хүсэлт гаргасан 488 тусгай зөвшөөрлийн нөхөх олговорын хэмжээг урьчилан тооцох ажлын хэсгийн хүрээнд Татварын ерөнхий газар болон БОНХЯ-тай хамтран мэдээллийн бааз үүсгэж тусгай зөвшөөрөл тус бүрээр судалгаа гаргасан.<br>- Хуулийн дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ажиллаж буй холбогдох мэргэжилтэнг мэдээлэл болон судалгааны материалаар тухай бүрд нь ханган ажилласан.<br>- “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай” хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын хэсгийн дэд ажлын хэсэгт орж ажиллаж буй холбогдох мэргэжилтэнг БОХХААБайнгын хорооны гишүүдийг судалгааны материалаар хангаж ажилласан.<br>- “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах, дүгнэлт гаргах ажлын хэсгийн дарга, |

| | | |
|---|---|---|
| | | УИХ-ын гишүүн Д.Арвины өгсөн үүрэг даалгаврын дагуу урт нэртэй хуульд хамрагдсан 215 тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүдийн олборлосон алтны хэмжээг 2000-2013 оны байдлаар он тус бүрээр гаргаж хүргүүлсэн.<br>- УИХ-ын хуралдаанд Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын хэсгээс танилцуулах дүгнэлт бичихэд оролцон, мэдээлэл судалгаагаар хангаж ажилласан.<br>- Нөхөн олговрын хэмжээг тооцох ажлын хүрээнд нөхөх олговор авах хүсэлт, түүнд хавсаргасан эх материалыг тусгай зөвшөөрөл бүрээр тулгалт хийж Сангийн яаманд хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон.<br>- Засгийн газрын 194-р тогтоолд хамрагдсан 488 ашиглалтын тусгай зөвшөөрөл, 845 хайгуулын тусгай зөвшөөрлийн талаарх 7 төрлийн мэдээлэл судалгааг гаргаж Уул уурхайн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Батхүүд болон УИХ-ын байнгын хороонд хүргүүлсэн. |
| 2.16.2. “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-иар хоргилосон газартай давхацсан алтны шороон ордуудын нөөцийн хөдөлгөөн хийх | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Шуурхай, хуулийн хүрээнд үнэн зөв | Шороон ордуудын тоон мэдээллүүдийг нэгтгэн гаргасан. |
| **2.17. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, олборлох үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг хийж, олон улсын стандартын дагуу нөхөн сэргээлт хийх зардлын тооцоог тусгай зөвшөөрөл бүрт тооцож хэрэгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ-47.2 заалт/** | | |
| 2.17.1. Энэ чиглэлээр ажиллаж буй байгууллага, ажлын хэсгийг шаардлагатай судалгаа, мэдээллээр хангаж ажиллана. | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Шуурхай, хуулийн хүрээнд | -“Гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах тогтоолын төслийг судлан, дүгнэлт гаргах ажлын хүрээнд УИХ-ын даргын өгсөн үүргийн дагуу урт нэртэй хуульд хамрагдсан аж ахуйн нэгжүүдэд олгох нөхөх олговрын хэмжээг урьдчилсан байдлаар гаргаж УИХ-ын ажлын хэсэгт 2 удаа, Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралд 1 удаа танилцуулсан.<br>-“Гол, мөрний урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах, дүгнэлт гаргах ажлын хэсгийн дарга, УИХ-ын гишүүн Д.Арвины өгсөн үүрэг даалгаврын дагуу урт нэртэй хуульд хамрагдсан 215 тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүдийн |

| | | |
|---|---|---|
| | | олборлосон алтны хэмжээг 2000-2013 оны байдлаар он тус бүрээр гаргаж хүргүүлсэн.<br>- Нөхөх олговрын хэмжээг тооцох ажлын хүрээнд нөхөх олговор авах хүсэлт, түүнд хавсаргасан эх материалыг тусгай зөвшөөрөл бүрээр тулгалт хийж Сангийн яаманд хүлээлгэн өгөхөд бэлэн болгосон.<br>-Засгийн газрын 194 дүгээр тогтоолд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн жагсаалтыг УИХ-ын байнгын хороонд 2014 оны 3 сард хүргүүлсэн.<br>- БОНХЯ-тай хамтарч хуульд хамрагдсан 488 тусгай зөвшөөрлийн эвдрэлд орсон талбайн хэмжээг гаргаж УИХ-ын гишүүн Д. Арвин болон Байгаль орчин, хүнс хөдөө аж ахуйн байнгын хороо, УУЯ-нд хүргэж өгсөн.<br>-“Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх , ашиглалхыг хориглох” тухай хуулийн хэрэгжилтийн тухай болон Засгийн газрын 194-р тогтоолд хамрагдан нөхөх олговор авах хүсэлт гаргасан 488 тусгай зөвшөөрлийн нөхөх олговорын хэмжээг урьчилан тооцох ажлын хэсгийн хүрээнд Татварын ерөнхий газар болон БОНХЯ-тай хамтран мэдээллийн бааз үүсгэж тусгай зөвшөөрөл тус бүрээр судалгаа гаргасан. |
| **2.18. Экспортод гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүний стандартыг олон улсын жишигт нийцүүлэх талаар судалгаа хийж хэрэгжүүлнэ. /ЗГҮАХХАХТ-49.1 заалт** | | |
| 2.18.2. Экспортод гаргаж байгаа уул уурхайн бүтээгдэхүүн, болон тэдгээрийн стандартыг судалж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах. | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Тавигдах шаардлагад нийцсэн | 1. Монгол улсад мөрдөгдөж байгаа молибдений стандартыг судлан, молибден олборлодог аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн техник, эдийн засгийн үндэслэлээс холбогдох мэдээллийг авч нэгтгэн санал боловсруулах бэлтгэл ажлыг хангасан.<br>2. Стандарчилал хэмжил зүйн газарт молибден болон жоншны стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай 2014.08.14-нд 5-4669 тоот албан бичиг хүргүүлсэн.<br>3. Хайлуур жоншны ОХУ болон БНХАУ-ын стандартыг орчуулан Монголын стандарттай харьцуулан санал боловсруулсан.<br>4. ОХУ, БНХАУ, Монгол улсад мөрдөгдөж буй стандартуудтай харьцуулалт хийж байна. |
| **2.19. Уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. /ЗГҮАХХАХТ-49.2 заалт/** | | |
| 2.19.1. Уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн судалгаа хийх | Тоо хэмжээ – 1 судалгааны ажил<br>Хугацаа - жилдээ<br>Чанар –Өргөн хүрээг | 2013 онд үйл ажиллагаа явуулаагүй Металл ашигт малтмалын ордын 123, Металл бус ашигт малтмалын ордын 96 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс албан тоотоор тайлбар хүлээн авч мэдээллийн санд нэгтгэсэн. |

| | | |
|---|---|---|
| | хамарсан, бодитой байна | Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжүүдийн уулын ажлын төлөвлөгөө, тайлангаас үндсэн тоног төхөөрөмжийн судалгааны ажлыг хийгээд байна.<br>- Ойрын ирээдүйд ашиглалтанд орох үйлдвэрүүдийн ТЭЗҮ-ээс шаардагдах тоног төхөөрөмжийн судалгаа, олон улсад өргөн хэрэглэгдэж буй тоног төхөөрмжүүдийн судалгаа зэргийг хийж байна. |
| 2.19.2. Тоног төхөөрөмжийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх эрх зүйн орчны талаар санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх. | Тоо хэмжээ – 1 санал<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Үндэслэл сайтай, хэрэгжихүйц бодитой байна | Судалгааны ажлууд хийгдэж байна. |
| **2.20. Дархан-Сэлэнгийн бүс нутгийн төмрийн хүдрийн ордуудыг түшиглэн төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт барьж байгуулах төслийн ТЭЗҮ, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, байгуулж эхэлнэ. /ҮХЦБ-5.2.1; ЗГҮАХХАХТ-50.1 заалт/** | | |
| 2.20.1. Дарханы Төмөрлөгийн үйлдвэрийн хөгжлийн концепцийг шинэчлэх ажлыг төрийн бодлого, холбогдох баримт бичигтэй уялдуулан техник, технологийн болон эдийн засгийн тооцоонд зөвлөмж өгч, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа – Тухай бүр<br>Чанар -Үндэслэл сайтай, хэрэгжихүйц бодитой мэдээллээр хангаж ажилласан байна | - Холбогдох мэргэжилтнүүд Дархан-Сэлэнгийн бүс нутагт албан томилолтоор ажиллаж тус бүс нутгийн ордуудын ашиглалтанд бэлтгэгдсэн байдал, үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн өнөөгийн байдал, дэд бүтцийн хөгжлийн судалгааг явуулав.<br>Мөн тус бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй “Хүннү стийл”, “Харанга ресурс” ХХК-иудын ТЭЗҮ, “Баянголын бүлэг ордыг ашиглах концепци” зэрэгтэй танилцаж холбогдох мэргэжил арга зүйн зөвлөгөө, шүүмж, саналуудыг өгөв.<br>- “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг 2010-2015 онуудад Уул уурхайн хар төмөрлөгийн цогцолбор болгон хөгжүүлэх концепц төлөвлөгөө боловсруулагдан, батлагдсан.<br>- “Уул уурхайн хар төмөрлөгийн цогцолбор” байгуулах төслийн 1-р үе шатны хийгдсэн ажлууд:<br>- Төмөртолгойн уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд ДТҮ хүртэл 28 км сайжруулсан шороон зам, Хонгор сумаас 17,4 км цахилгаан дамжуулах агаарын шугам, бууруулах станц, Дархан-Шарын голын төмөр замын 20-р цэг дээр төмөр замын гарам, уурхайн оффис, хүнд даацын машин механизмын засварын газар, паркийг өргөтгөсөн, зөөврийн ШТС, хуурай соронзон аргаар баяжуулах 2 шугам, цэвэр усны 3 шугам барьж ашиглалтад оруулсан.<br>- Төмөртэй уурхайд хийгдэж буй ажлын хүрээнд Ерөө сумын ойролцоох өртөө рүү 34 км төмөр зам барих зөвшөөрлийн ажлууд хийгдэж дууссан, 50 км 110кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 16 МВА-ийн дэд станц, хүнд даацын машин механизмын засварын төв, |

| | | |
|---|---|---|
| | | уурхайн кемп баригдаад ашиглалтад орсон, олборлолт эхэлсэн, 1 сая тн хүдэр хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэр барих ажил 80%-тай, цэвэр усны 3 худаг барьж ашиглалтад оруулсан.<br>- Хуст уулын ордод нарийвчилсан хайгуул хийн, 12.6 сая тн нөөцийг улсын нөөцийн бүртгэлд бүртгүүлэн ТЭЗҮ, БОНҮ батлуулсан.<br>- УУЯ-ны ТНБД-ын 14/20 тоот удирдамжийн дагуу Дархны төмөрлөгийн үйлдвэрийн Төмөртэйн уурхайг түшиглэн байгуулагдсан хуурай соронзон аргаар төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийг 9 дүгээр сарын 12-ны өдөр улсын комиссоор хүлээн авах бүрэлдэхүүнд холбогдох мэргэжилтнийг оролцуулав. Улсын комисс хүлээн авснаар тус үйлдвэрийг байнгын ашиглалтанд оруулав.<br>- Нойтон баяжуулах үйлдвэрийн технологийн танилцуулах арга хэмжээнд хэлтсийн мэргэжилтнүүд оролцож цаашид авах арга хэмжээ, шаардлагатай төрийн дэмжлэг туслалцааны талаар санал солилцов. Энэ ондоо багтаж ашиглалтанд орно. |
| **2.21. Эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газрыг нөхөн сэргээх санхүүжилтийн асуудлын эрх зүйн орчныг бий болгож, нөхөн сэргээлт хийсэн газрын мэдээллийн нэгдсэн санг бий болгоно. /ҮХЦБ-5.2.1.1; ЗГҮАХХАХТ-54.2 заалт/** | | |
| 2.21.1. Нөхөн сэргээлт хийгдсэн газрын мэдээллийн нэгдсэн санг хөтлөх, баяжуулах. | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа – тогтмол<br>Чанар –Үнэн зөв, бодитой байна | БОНХЯам, Цаг уур орчны шинжилгээний газартай хамтран 21 аймгийн эвдрэлд орсон газрын үр дүнгийн тайлан, Уул уурхайн бохирдлыг тогтоох төслийн нэгжийн 2014 он хүртэл хийж гүйцэтгэсэн ажлын тайлан болон холбогдох мэдээлэл, талбайн зураглалыг БОНХЯ-ны дэргэдэх байгаль орчны төвийн нэгдсэн мэдээллийн санд оруулан, санг баяжуулан ажилласан.<br>/ хэмжээ: 25 GB, цаас хэлбэрээр 1 хавтас/ |
| **2.22. Байгаль орчны бохирдол, доройтол, байгалийн нөөцийн ашиглалтад тавих хяналтыг эрчимжүүлж, уул уурхайн нөхөн сэргээлтийн хэмжээг 70-аас доошгүй хувьд хүргэнэ. /ҮХЦБ – 5.2.1.1; ЗГҮАХХАХТ – 54.3-р заалт/** | | |
| 2.22.1. Тухайн жилийн нөхөн сэргээх төлөвлөгөөний биелэлтийг 70%-аас доошгүй хувьд хүргэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар –Төлөвлөсөн хэмжээнд үр дүн гарсан байна | - Эвдэрсэн болон нөхөн сэргээсэн талбайн мэдээллийг нэгтгэж уул уурхайн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлын дагуу монгол талын туслан гүйцэтгэгч “Supreme solution” ХХК-ний гүйцэтгэсэн цахим хуудсанд мэдээлэл оруулсан бөгөөд зарим програм хагамжийг засварлав.<br>АМГ, БОНХЯ, УУЯ, УЦУОШГ-ын БО-ны мэдээллийн төвийн хамтарсан **mris.mram.gov.mn/flex/-mnggis.html-**д мэдээлэл оруулах, хэрэглэгчдэд ашиглуулах сургалтыг 6 дугаар сард багтаан зохион байгуулав.<br>***- 120*** аж ахуйн нэгжийн ТЭЗҮ болон БОНБНҮ ирүүлсэн 120 ААН-ийн үнэлгээг ТЭЗҮ-тэй тулгалт хийж, шаардлагатай тохиолдолд БОНБНҮ болон ТЭЗҮ-д нэмэлт тодотгол хийх талаар зөвлөмжүүдийг цахим |

| | | |
|---|---|---|
| | | хуудсаар хүргүүлэн ажилласан.<br>- “Уул уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнөх эдийн засаг, нийгмийн үр нөлөөг тогтоох аргачлал”-ыг боловсруулах. /БОНХЯ2013065/, Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээх ажлын зардлын үнэлгээ тооцох аргачлал”-ыг шинэчлэн боловсруулах /БОНХЯ2013066/, тоот гэрээт ажлыг хүлээн авах ажлын хэсгийн хуралдаанд ирүүлсэн төсөлтэй танилцаж, шаардлагатай судалгааны ажлын мэдээллийг хүргүүлэн санал дүгнэлт өгч ажиллав. |
| **2.23. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж батална. /ҮХЦБ-5.2.1.; ЗГҮАХХАХТ-56.3/** | | |
| 2.23.1. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай судалгаа, мэдээллээр холбогдох байгууллага, ажлын хэсгийг хангаж ажиллах | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа – Тухай бүр<br>Чанар -Үндэслэл сайтай, хэрэгжихүйц бодитой мэдээллээр хангасан байна | 1. “Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор” ХК-ийн удирдлагуудтай 3-р сарын 5, 4-р сарын 18-ны өдрүүдэд уулзалт зохион байгуулж төслийн үйл явцтай танилцав.<br>Мөн цаашдын үйл ажиллагаанд шаардлагатай байгаа мэдээллүүдийг хүсэж ирүүлсэн тоотод нь 5-1122 тоотоор Монгол улсын төмрийн ордууд, үйл ажиллагаа явуулж буй болон явуулхаар төлөвлөж буй аж ахуйн нэгжүүд, баяжуулах үйлдвэрүүдийн талаархи мэдээллүүдийг хүргүүлэв.<br>**2. “**Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг авах талаар ҮХААЯ-ны Хүнд үйлдвэрийн газарт 5-5471 тоот албан бичиг хүргүүлж, Флуор компаний боловсруулсан **“**Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын хөгжлийн мастер төлөвлөгөөний төсөл болох 367 хуудас материалтай танилцаж санал өгөв.<br>3. “Сайншанд” АҮЦ-т байгуулах зэс хайлуулах үйлдвэрт шаардлагатай түүхий эдийн нөөцийн /фосфорит/ талаар Геологийн фондоос мэдээлэл авч судлав. Бүрэн хааны фосфоритийн ордыг ашиглуулахгүй тохиолдолд алтернатив фосфоритийн орд илэрцүүд байгаа эсэх тухайд нөөцийн анхан шатны судалгааны ажил хийлээ. Үүнд 1:2500000-ны зөвхөн фосфоритийн орд илэрц тэмдэглэсэн зураг, тэдгээрийн судлагдсан байдлын талаар товч мэдээлэл бэлтгэж УУЯ-нд хүргүүлсэн. |
| **2.24. Дарханы төмөрлөгийн үйлдвэрт технологийн шинэчлэл хийж, хүдэр баяжуулна. /ЗГҮАХХАХТ-57.1 заалт/** | | |
| 2.24.1. Дарханы Төмөрлөгийн үйлдвэрт технологийн шинэчлэл хийж буй төслийн үйл ажиллагаатай танилцаж, холбогдох мэдээллийг нэгтгэн санал, дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний | Тоо хэмжээ – 2 арга хэмжээ<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар -Хамтын ажиллагаа үр дүнтэй, | 1. “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-ийг 2010-2015 онуудад Уул уурхайн хар төмөрлөгийн цогцолбор болгон хөгжүүлэх батлагдсан концепц төлөвлөгөөний II үе шатны ажлын хүрээнд Дарханы төмөрлөгийн үйлдвэрт дараах технологийн шинэчлэл хийгдэж байна. Үүнд: |

| | | |
|---|---|---|
| болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих саналыг УУЯ-аар дамжуулан холбогдох байгууллагуудад уламжлах | санал үндэслэл сайтай хэрэгжихүйц байна | - Орчин үеийн технологид суурилагдсан хийн зуухны /2 шатлалтайгаар хүйтэн хий гаргах/ тоног төхөөрөмжийн сонголтыг хийж, БНХАУ-аас захиалан авсан, суурь тавих ажил хийгдэж байна.<br>- ЭБЦ машиныг /цувих/ шинэчлэх тоног төхөөрөмжийн сонголт хийж, БНХАУ-аас захиалан авсан мөн суурь тавих ажил хийгдэж байна.<br>- Хайлах цехэд суурьлуулах шанаган зуухны сонголт хийх санамж бичигт ДТҮ, Японы үйлдвэрлэгчтэй гарын үсэг зурсан.<br>- Хүчилтөрөгчийн хийн станцын тоног төхөөрөмжийн сэлбэг, хэрэгслийг шинэчлэн сольж байна.<br>- Өргөн тээвэрлэх механизмын өргөтгөл, шинэчлэл мөн шинээр шинжилгээний тоног төхөөрөмж худалдан авч, лабораторийг өргөтгөн судалгаа, шинжилгээний төв байгуулаад байна.<br>Технологийн шинэчлэлийн ажлууд 2014 онд дуусна.<br>2. УУЯ-ны ТНБД-ын 14/20 тоот удирдамжийн дагуу Дархны төмөрлөгийн үйлдвэрийн Төмөртэйн уурхайг түшиглэн байгуулагдсан хуурай соронзон аргаар төмрийн хүдэр баяжуулах үйлдвэрийг 9 дүгээр сарын 12-ны өдөр улсын комиссоор хүлээн авах бүрэлдэхүүнд холбогдох мэргэжилтнийг оролцуулав. Улсын комисс хүлээн авснаар тус үйлдвэрийг байнгын ашиглалтанд оруулав.<br>3. Нойтон баяжуулах үйлдвэрийн технологийн танилцуулах арга хэмжээнд хэлтсийн мэргэжилтнүүд оролцож цаашид авах арга хэмжээ, шаардлагатай төрийн дэмжлэг туслалцааны талаар санал солилцов. Энэ ондоо багтаж ашиглалтанд орно. |
| **2.26. Уул уурхайн салбарын статистик мэдээ, мэдээлэл, судалгаа хийх** | | |
| 2.26.1. Уул уурхайн салбарын аж ахуйн нэгж байгууллагуудын хөрөнгө оруулалтын мэдээллийн санг хөтлөх, Хөрөнгө оруулалтын судалгааны материал цуглуулах, төсөл хөтөлбөрүүдийн судалгаа хийх | Тоо хэмжээ – 1 мэдээллийн сан, 1 судалгааны ажил<br>Хугацаа - жилдээ<br>Чанар - Мэдээлэл бодитой байна | - Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт шаардлагатай төслүүдийн материалыг онлайн, файл, цаасан хэлбэрээр авч мэдээллийн сантай боллоо.<br>2. Хөрөнгө оруулалт шаардлагатай компаниудын төсөл, хөтөлбөрийг Уул уурхайн төсөлд хөрөнгө оруулах сонирхолтой гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нартай холбож танилцуулах, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор Ашигт малтмалын газрын www.mram.gov.mn цахим хаягт “INVEST MM” булан ажиллуулсан.<br>3. Тус мэдээллийг Монголын хөрөнгө оруулалтын газрын цахим хаяг, mining.mn болон ord.mn цахим хаягуудад байршуулсан.<br>4. “Frontier Securities” компаниийн зохион байгуулж буй 2014 оны 12-р сарын 11-нд Японы нийслэл Токио хотод “Монгол улсад хөрөнгө оруулагчид” нэртэй бүх салбарын уулзалт, зөвлөлгөөнд хөрөнгө |

| | | |
|---|---|---|
| | | оруулалт шаардлагатай төслүүдийг оролцуулах боллоо.<br>Австрали, Казахстан, Offshor бүс, БНХАУ-ын хөрөнгө оруулалтын орчны талаар судалж байна.<br>- Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар санал боловсруулан УУЯ-нд тухай бүр хүргүүлсэн. |
| 2.26.2. Гадаадын болон дотоодын хөрөнгийн зах зээлээс Монголын уул уурхайн салбарт орж ирж буй хөрөнгө, түүнийг оруулж ирж буй компаниудын хувьцааны үнэ ханшийн судалгаа хийх | Тоо хэмжээ – 1 судалгааны ажил<br>Хугацаа - жилдээ<br>Чанар - Мэдээлэл бодитой байна | - Гадаадын зах зээлд үнэт цаас арилжаалж байгаа, Монголд хөрөнгө оруулалтай компаниудын үнэт цаасны мэдээлэлд тулгуурлан судалгаа хийж Монголын эдийн засагт нөлөө үзүүлэхүйц зарим компаниудад дүгнэлт хийж, Уул уурхайн яамны төрийн нарийийн бичгийн дарга болон бусад шаардлагатай албан тушаалтнуудад цаг хугацаанд нь мэдээлж мэдээлж байна. |
| 2.26.3. Уул уурхайн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ ханшийн тухай сүүлийн үеийн мэдээллийг АМГ-ын веб хуудсанд сар бүр байршуулж холбогдох байгууллагыг мэдээллээр хангах | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар -Мэдээлэл бодитой, шуурхай | - Уул уурхайн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний үнэ ханш, цаашдын хандлагын тухай мэдээллийг 2013 он, 2014 оны сар болгоноор бэлтгэж Уул уурхайн яаманд хүргүүлж, АМГ-ын цахим хуудсанд байршуулсан.<br>- Лондонгийн Металлын Биржийн түүхий эдийн үнийн мэдээллийг голлох ашигт малтмал тус бүрээр авч өдөр бүрийн үнийн мэдээллийн санд нэгтгэсэн.<br>- Ашигт малтмалын газрын даргын тушаалын дагуу “Геологи, уул уурхайн салбарын өнөөгийн байдлын танилцуулга боловсруулах” ажлын хэсгийн хүрээнд “ашигт малтмалын олон улсын болон хөрш орнууд, хилийн боомтуудын үнийн мэдээлэл” мөн “ашигт малтмалын олон улсын зах зээлийн үнэ болон манай орны аж ахуйн нэгж байгууллагуудын экспортолж, борлуулсан бүтээгдэхүүний үнийн харьцуулсан мэдээлэл” зэргийг 2014 оны 7-р сарын байдлаар бэлтгэсэн.<br>- Уул уурхайн экспортын бүтээгдэхүүний жишиг үнийг зарлах ажлын хэсгийн 8 удаагийн хуралд холбогдох мэргэжилтэн оролцож, саналаа өгч ажиллан, батлагдсан үнийг АМГ-ын цахим хуудсанд байршуулсан.<br>- ЗГ-ын тогтоолд гянтболдын жишиг үнэ тогтоох эх сурвалжийг өөрчлөх саналыг ажлын хэсэгт хүргүүлэн өөрчлүүлж, өөрчлөгдсөн эх үүсвэрийн талаарх мэдээллийг гянтболд олборлогч аж ахуйн нэгжүүдэд 8-р сард хүргүүлсэн.<br>- Судалгааны ажилд зориулан хэрэглэх цахим хуудасны төлбөрийг шийдүүлэх, ашиглах эрхийг нээлгэх ажлын хүрээнд Сангийн яамны мэргэжилтэн Мөнхзултай хамтран, төмрийн хүдрийн олон улсын зах зээлийн үнэ, мэдээ мэдээлэл гаргадаг www.umetal.com цахим хуудасны ажилтан Susan Chen-тэй холбогдон, тухайн цахим хуудасны ашиглах эрхийг сунгахаар ярилцаж, бүтэн жилийн төлбөр болох 2000 |
| 2.26.4. Уул уурхайн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн өнөөгийн байдал, эрэлт хэрэгцээ, үнэ ханш, хэтийн төлвийн талаар судалгаа хийж дэлхийн зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй Монгол улсад олборлолт нь явагддаг ашиг малтмалын гарын авлага 1-ийг гаргаж холбогдох байгууллагыг мэдээллээр хангах | Тоо хэмжээ – 1 товхимол<br>Хугацаа – улирал бүр<br>Чанар -Мэдээлэл бодитой, хэрэгцээ хангасан байна | |
| 2.26.5. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын жишиг үнийн санал боловсруулах, батлагдсан үнийг сурталчлах, УУЯ-ний веб хуудсанд байршуулж байх | Тоо хэмжээ – 2 арга хэмжээ<br>Хугацаа - Сар бүр<br>Чанар -Үр дүнтэй, бодитой шуурхай байна | |

| | | |
|---|---|---|
| | | ам.долларыг Сангийн яамнаас санхүүжүүлэхээр тохиролцоонд хүрч, төлбөрийн асуудлыг шийдүүлж эрхийг нь нээлгэсэн.<br>- Судалгааны ажил болон жишиг үнэ боловсруулахад шаардлагатай төлбөртэй цахим хуудсуудын үнэ ханшийн мэдээллүүдэд судалгаа хийх ажлын хүрээнд www.indmin.com, www.metalprices.com, www.asianmetal.com, цахим хуудасны холбогдох асуудал хариуцсан мэргэжилтэнүүдтэй холбогдож, мэдээлэл солилцсон. |
| **2.27. Уулын үйлдвэрийн үзүүлэлтүүдийг мэдээллийн санд нэгтгэх, нөөцийн бүртгэл хөтлөх** | | |
| 2.27.1. Уулын үйлдвэрийн 2014 оны Уулын ажлын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн төлөвлөгөөг аж ахуйн нэгжүүдээс хүлээн авч хянан үндсэн үзүүлэлтүүдийг мэдээллийн санд нэгтгэх | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар -Үр дүнтэй, шуурхай зохион байгуулсан байна | - Аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн металл ашигт малтмалын ордын 2014 оны уулын ажлын 143 төлөвлөгөө, металл бус ашигт малтмалын ордын уулын ажлын 135 төлөвлөгөө хүлээн авч хянан, үндсэн үзүүлэлтүүдийг мэдээллийн санд нэгтгэсэн.<br>- Аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн металл ашигт малтмалын ордын 2015 оны уулын ажлын 21 төлөвлөгөө, металл бус ашигт малтмалын ордын уулын ажлын 14 төлөвлөгөө хүлээн авч хянан холбогдох засваруудыг хийлгэсэн. |
| 2.27.2. Уулын үйлдвэрийн 2013 оны Уулын ажлын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн тайланг аж ахуйн нэгжүүдээс хүлээн авч хянан үндсэн үзүүлэлтүүдийг мэдээллийн санд нэгтгэх. | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар -Үр дүнтэй, шуурхай зохион байгуулсан байна | Уулын үйлдвэрийн 2013 оны 81 металл ашигт малтмалын, 81 металл бус ашигт малтмалын ордын уулын ажлын тайланг аж ахуйн нэгжүүдээс хүлээн авч хянан үндсэн үзүүлэлтүүдийг мэдээллийн санд нэгтгэсэн. |
| 2.27.3. 2013 онд олборлолт явуулсан металл болон металл бус ордуудын ашигт малтмалын нөөцийн хөдөлгөөний тоо бүртгэлийг хөтлөн Улсын бүртгэлд бүртгэх | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Үр дүнтэй, шуурхай | Металл ашигт малтмалын 80 орд, металл бус ашигт малтмалын 80 ордын 2013 оны нөөцийн хөдөлгөөний тоо бүртгэлийн хөтлөлт, тэдгээрийг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр нэгтгэж байна. |
| 2.27.5. Бүх олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2013 онд явуулсан үйл ажиллагаанд судалгаа хийж ангилан тэдгээрийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээний санал боловсруулан УУЯ-д хүргүүлэх | Тоо хэмжээ – 1 санал<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Санал үндэслэл сайтай, бодитой байна | - 2013 онд үйл ажиллагаа явуулаагүй металл ашигт малтмалын ордын 155, металл бус ашигт малтмалын ордын 126 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс албан тоотоор тайлбар хүлээн авч мэдээллийн санд нэгтгэсэн.<br>- Бүх олборлох үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дунд хийсэн судалгаанд тулгуурлан санал боловсруулан УУЯ-ны БХЗГазарт 2014 оны 8 дугаар сарын 27-ны өдөр хүргүүлсэн. |
| 2.27.6. Геологийн хувьд нэгдмэл тогтоцтой ордуудын тусгай зөвшөөрлийг хэсэгчилж | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ | Геологийн хувьд нэгдмэл тогтоцтой ордуудын тусгай зөвшөөрлийг хэсэгчилж олгохгүй байх асуудлыг Төмөртэйн ордын нөөцийн талбай |

| | | |
|---|---|---|
| олгохгүй байх асуудлыг шийдвэрлүүлнэ | Хугацаа - жилдээ<br>Чанар – Асуудлыг шийдвэрлэж чадсан байна | болон олгогдсон тусгай зөвшөөрлийн хэмжээнд судалж санал боловсруулсан. |
| **2.29. Ил, далд уурхай болон боловсруулах үйлдвэрийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг шинэчлэх төсөл боловсруулах** | | |
| 2.29.1. Ил болон далд уурхай, Баяжуулах, боловсруулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн төслийг боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулах | Тоо хэмжээ – 1 төсөл<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Төсөлд тавигдах шаардлагад нийцсэн, батлагдсан байна | 1.“Хүдэр, хүдрийн бус, шороон ордыг далд аргаар ашиглах аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулах дэд ажлын хэсгийн 11 удаагийн хуралдааныг зохион байгуулж 731 заалт бүхий 9 хавсралт, 2 хүснэгттэй дүрмийг уул уурхайн салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль эрх зүй, дүрэм, журам болон өнөөгийн техник, технологийн хөгжилтэй уялдуулан шинэчилсэн төсөлийг боловсруулав.<br>2. “Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм” шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн анхдугаар хуралдааныг 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдөр зохион байгуулсан бөгөөд тус хуралдаанаар ажлын хэсгийн хийгдэх ажлын төлөвлөгөөг гаргасан боловч уг ажлыг зохион байгуулах санхүүгийн асуудал шийдэгдээгүйн улмаас зогссон.<br>3. УУСайдын 2014.06.19-ний өдрийг 124 дүгээр тушаалын дагуу байгуулагдсан Дэд ажлын хэсгийн I хурлыг 2014.07.08-ны өдөр зохион байгуулж дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.<br>Үүнд:<br>- Хууль, эрх зүйн орчныг судлах<br>- Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг өөрчлөх санал боловсруулах<br>Баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийг боловсруулах ажлын хэсгийн 2-3-р хурлыг 2014.09.18 болон 09.23-ны өдөр зохион байгуулж дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.<br>Үүнд:<br>- Дэд ажлын хэсгийн төлөвлөгөө боловсруулж, хурлуудыг зохион байгуулах аж ахуйн нэгжүүдийг тохиров.<br>- Дүрмийн агуулгыг боловсруулж, холбогдох гишүүдэд хуваарилж өгөв.<br>Баяжуулах үйлдвэрийн аюулгүй ажиллагааны дүрмийг боловсруулах ажлын хэсгийн 4-6-р хурлыг зохион байгуулж дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.<br>Үүнд:<br>- Дэд бүлгүүдтэй холбоотой гадаад, дотоодын дүрэм, журам, |

| | | |
|---|---|---|
| | | стандартын судалгааг гүйцэтгэв. |
| **2.30. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилттэй танилцах, санал дүгнэлт өгөх.** | | |
| 2.30.1. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах, гэрээний биелэлтийг хангах, гэрээг дүгнэх. | Тоо хэмжээ –2 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Тавигдах шаардлагад нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна | 1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс ирүүлсэн 26 ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах хүсэлттэй танилцаж, 15 тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулав.<br>2. 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр баталсан “Ашигт малтмалын тухай хууль”-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан заалтыг хэрэгжүүлэн хүчин төгөлдөр байгаа 60 ашиглалтын өмнөх гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан, гэрээг шинэчлэн бүртгэх ажлыг хийж дуусгав.<br>3. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулах хүсэлт ирүүлээд шийдэгдээгүй 11 тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт болон тайлбарыг гарган, шийдвэрлэсэн.<br>4. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны тухай гэрээний биелэлтийг хангах зорилгоор 2010-2012 онд байгуулсан хугацаа дууссан 2 гэрээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд албан тоот хүргүүлж, 2 тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд утсаар мэдэгдсэн. |
| **2.31. Техник эдийн засгийн үндэслэл** | | |
| 2.31.1. Уулын үйлдвэр, уурхайн техник эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах, бүртгэх, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдааныг зохион байгуулах, **төслүүдийн дэлгэрэнгүй судалгаа хийх.** | Тоо хэмжээ – 2 арга хэмжээ<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар - Тавигдах шаардлагад нийцсэн байна | 1. ЭБЭХ-ны Сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дугаар 074 тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник эдийн засгийн үндсэлэл хүлээн авах журам"-ын дагуу боловсруулан 2014 онд ирсэн 153 техник эдийн засгийн үндэслэлд шинжээч томилуулж, 99 төсөлд шинээр, 111 төсөлд дахин танилцах хуудас олгосон байна.<br>2. 2014 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 19 удаагийн хуралдаан зохион байгуулж 149 (давхардсан тоогоор) техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцүүлсэнээс хүлээн авсан **33**, ажлын шугамаар засвар хийлгэн хүлээн авсан **102**, ЭБМЗ-өөр хэлэлцүүлж дахин хэлэлцэхээр буцаасан **14** техник эдийн засгийн үндэслэл байна.<br>3. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 119 дүгнэлт, тушаалын төсөл гаргажээ. Төслийн шатандаа яваа 13 дүгнэлт байна.<br>4. Хүлээн авсан техник, эдийн засгийн үндэслэлийн 119 товч танилцуулгыг файл аар авсан байна. Эдийн засгийн хувьд үр ашигтай ашигт малтмалын ордын болон уулын үйлдвэрүүдийн дэлгэрэнгүй судалгааг 2014 онд хэлэлцэн хүлээн авсан төслүүдэд 51 хийсэн байна. |

| | | |
|---|---|---|
| | | 5. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан 5 зохион байгуулав. |
| 2.31.2. Техник эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлагын дагуу төслүүдийг үнэлж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах | Тоо хэмжээ –1 санал<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар - Үндэслэл сайтай, бодитой | 1. Металл ашигт малтмалын орд болон баяжуулах үйлдвэрийн 42, металл бус ашигт малтмалын орд болон баяжуулах үйлдвэрийн 39 техник, эдийн засгийн үндэслэлийн эдийн засгийн хэсэг, нөөцийн бүлэгтэй танилцлаа.<br>2. АМГ-ын даргын 2014оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 00-49 дугаар тушаалаар "Ашигт малтмалын ордыг ашиглах баяжуулах үйлдвэрийн техник-эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэшсэн мэргэжилтэнүүдээс бүрдсэн гишүүдтэй ЭБМЗ байгуулах, түүний дүрэм, шинжээчийн ажлын хөлс тооцох аргачлал"-ыг боловсруулах ажлыг хэсэгт орж ажиллав.<br>3. Техник эдийн засгийн үндэслэлд тавигдах шаардлагыг өндөржүүлэх ажлын хүрээнд "зураг-стандарт" –ын жил болгон зарлав. Үүний үр дүнд ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан ТЭЗҮ-ийн хавсралт зурагтай тухайн хуралдаанаас томилогдсон гишүүн төсөл бүртэй танилцаж байна.<br>4. Төсөл боловсруулагч аж ахуйн нэгжүүдийн дунд сургалт, семинар, хэлэлцүүлэг зохион байгуулах талаар Уул уурхайн зураг, төсөв боловсруулагчдын холбоотой хамтран 2014 оны 12 дугаар сарын 19-нд зохион байгуулахаар төлөвлөгөө гарган бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. Тус семинараас гарсан санал хүсэлтийг Эрдэс баялгийн мэргэжлэлийн зөвлөлийн даргад хүргүүлнэ. |
| **2.32. Уул уурхайн салбарт хэрэглэгдэж байгаа техник, технологийн түвшинг үнэлэх, санал дүгнэлт боловсруулах.** | | |
| 2.32.1. Алт, хайлуур жонш, холимог металлын уурхайнуудын олборлолтод ашиглагдаж байгаа техник, технологийн судалгаа хийх;<br>- Алт, хайлуур жонш, холимог металлын уурхайнуудын баяжуулах үйлдвэрлэлийн техник, технологийн судалгаа хийх;<br>- Алт, хайлуур жонш, холимог металлын уурхайнуудын хүдрийн ордын өрөмдлөгө, тэсэлгээ, тэсрэх бодисын хэрэглээний судалгаа хийх;<br>- Уурхай болон уулын үйлдвэрийг ашиглалтад хүлээн авах комисст орж | Тоо хэмжээ – 7 судалгааны ажил<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар - Судалгаа үнэн бодитой байна | - Ашигт малтмалын тухай хууль"-ийн 48.6, Үйлдвэр худалдааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн Сайдын хамтарсан 2007 оны 296/25 дугаар тушаалаар батлагдсан "Уулын ажлын төлөвлөгөө, тайлан хянан зөвшөөрөх журам"-ын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2013 оны уулын ажлын тайлан, 2014 оны уулын ажлын төлөвлөгөөнөөс алт, жонш болон холимог металлын ордын ашиглалтын техник, технологийн судалгааг хийж гүйцэтгэлээ. Үүнд:<br>Холимог металлын судалгаа: - 9.<br>Алтны үндсэн ордын мэдээлэл – 4:<br>Хайлуур жоншны ордын мэдээлэл – 3.<br>- 2014 оны үйл ажиллагаа явуулж байгаа баяжуулах үйлдвэрийн жагсаалтыг гаргаж ArcGis программд зориулан датаг бэлтгэв. ArcGis программд байр зүйн зургийг оруулах ажлыг хийж байна. |

| | | |
|---|---|---|
| ажиллан техник технологийн талаар санал, дүгнэлт өгөх;<br>- Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлт, тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн сан бэлтгэх судалгаа хийх;<br>- Тэсрэх бодисын агуулах, үйлдвэрийн аюулгүй бүс тогтоох, үйлдвэр, тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээж авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллан санал өгөх;<br>- Жоншны болон Төмрийн хүдрийг баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлийн техник, технологийн судалгаа хийх. | | Холимог металлын мэдээлэл: - 14:<br>Вантаже (Cu, Au), Би эйч эм (Авдартолгой Cu-Mo; Номинт Cu-Mo), Голден хейлс (Zn, Pb, Ag), Би вай эйч (Fe, Mo, Zn), Оюутолгой (Cu, Mo, Au, Ag), Шанжин орд (Fe, Zn), Юүшэнгминг (Pb, Zn), Монголын алт (Cu, Mo, Au), Хар мөрөн Монгол (Fe, Cu, Zn, Au, Ag, Cu-Pb), Шинь шинь (Pb, Zn), Нью саймин рисорес (Cu, Au, Mo), Шианганюнтун (Pb, Zn), Шанлун (Pb, Zn, Cu, Ag) компаниудын ТЭЗҮ-ээс баяжуулалтын процессын мэдээллийг авав.<br>Алтны үндсэн ордын мэдээлэл: – 9:<br>Тэн хун (Au, Ag), Баян-Айраг (Au, Ag), Спейшлмайнз (Au), Бороогоулд (Au), Сентерра гоулд (Au), Шинэ эрдэс (Au, Ag), Хатанцацал (Au), Сонор трейд ХХК (Au), Хурай (Au) компаниудын ТЭЗҮ-ээс баяжуулалтын процессын мэдээллийг авав.<br>Хайлуур жоншны ордын мэдээлэл: – 8:<br>Ресурс минком ($CaF_2$), Монголчехметалл ($CaF_2$), Кевин инвест ($CaF_2$), Хэрлэн импекс ($CaF_2$), Тэмтэл ($CaF_2$), Олон овоот гоулд ($CaF_2$), Си эм кэй ай ($CaF_2$), Таймон флуортек ($CaF_2$) компаниудын ТЭЗҮ-ээс баяжуулалтын процессын мэдээллийг авав.<br>- “Бороо гоулд” ХХК/Алт/, “Цайрт минерал” ХХК /Цайр/, “Шан лун” ХХК, “Тэн хун” ХХК /Алт/, “Оюу толгой” ХХК, “Шинь шинь” ХХК /Жонш/, “Монголросцветмет-Бор Өндөр” ХК /Жонш/, “Юүшэнминг” ХХК /Холимог металл/ уурхайнуудын тайлан, төлөвлөгөө болон ТЭЗҮ-ээс өрөмдлөгийн тоног төхөөрөмж болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн зарцуулалт, мөн тэсэлгээчдийн судалгаа зэрэг холбогдох судалгааг авч мэдээллийн санд нэгтгэн техник технологийн түвшний үнэлгээ хийсэн.<br>- Архангай, Өвөрхангай, Төв, Баянхонгор, Сэлэнгэ аймгуудын нутаг дахь алтны уурхайнууд болон Дундговь, Дорноговь, Хэнтий аймгуудын жоншны уурхайнууд, Өмнөговь, Дорнод, Баян-Өлгий аймгуудын нутагт үйл ажиллагаа явуулж буй 76 алтны, 32 жоншны 8 холимог металлын уурхайн ТЭЗҮ болон БОНБНҮ-ний үзүүлэлтүүдийг нэгтгэн орчны болон нөхөн сэргээлтийн судалгаа хийж гүйцэтгэв. |
| 2.32.2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн хэрэгжилтийг хангах | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар - Хууль журмын дагуу | - “Бороо гоулд” ХХК/Алт/, “Цайрт минерал” ХХК /Цайр/, “Шан лун” ХХК, “Тэн хун” ХХК /Алт/, “Оюу толгой” ХХК, “Шинь шинь” ХХК /Жонш/, “Монголросцветмет-Бор Өндөр” ХК /Жонш/, “Юүшэнминг” ХХК /Холимог металл/ уурхайнуудын тайлан, төлөвлөгөө болон ТЭЗҮ-ээс өрөмдлөгийн тоног төхөөрөмж болон тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн зарцуулалт, мөн тэсэлгээчдийн судалгаа зэрэг холбогдох судалгааг авч |

| | | |
|---|---|---|
| | | мэдээллийн санд нэгтгэн техник технологийн түвшний үнэлгээ хийсэн.<br>20 аж ахуйн нэгжийн ТЭЗҮ-ээс болон УУЯ-нд ирүүлсэн тэсэлгээний холбогдох материалаас өрөмдлөгийн тоног төхөөрөмж болон тэсрэх бодисын зарцуулалтын мэдээ, бичиг баримтын бүрдэлт, тэсэлгээчдийн боловсон хүчний судалгааг боловсруулан мэдээллийн санд нэгтгэв.<br>Тэсэлгээний мэргэжлийн зөвлөлийн 2014 оны хурлаар 3 техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэв.<br>Үүнд:<br>• “Шивээ-Овоо” ХХК-ийн энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэрийн ТЭЗҮ<br>• “Нитро сибирь Монголиа” ХХК-ийн эмульсийн тэсрэх бодис болон энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэрийн ТЭЗҮ<br>“МН Жойн” ХХК-ийн эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн ТЭЗҮ<br>2014 оны 4-р сарын 21-нээс 5-р сарын 08-ны хооронд Баруун бүсийн аймгуудад үйл ажиллагаа эрхэлж буй 20 аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил, үйлчилгээ эрхэлж буй, тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл үйлдвэрлэдэг, хадгалдаг компаниудад хяналт тавьж, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн хэрэгжилтийг шалган бичиг баримтын бүрдэлт болон холбогдох мэдээ мэдээллийг авч нэгтгэв.<br>- 2014 оны 5-р сарын 1-нд Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт орших “Хар тарвагатай” ХК-ийн Нүүрсний уурхайн тэсрэх бодисын агуулахын аюулгүйн бүсийг тогтоох ажлын хэсэгт ажиллан санал, дүгнэлт өгч ажиллав.<br>- 2014 оны 8-р сарын 1-ний өдөр “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн 5, 11-р зүйлийн 11.1.4 дэхь заалт, Уул уурхайн сайдын 2013 оны 4-р сарын 22-ны өдрийн тушаалыг үндэслэн Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутагт орших “Илч түлш” ХХК-ийн эмульсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээгдэхүүний хяналтын туршилтыг хийж, дүгнэлт өгч ажиллав.<br>- 2014 оны 10-р сарын 6-наас 10-р сарын 9-ний хооронд говийн бүсийн аймгуудад үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын аюулгүйн бүс тогтоох улсын комисст орж ажиллав.<br>Үүнд:<br>**1.** “Фоор бласт” ХХК |

| | | |
|---|---|---|
| | | **2.** “Эрхэт түнш” ХХК<br>**3.** “Шивээ овоо” ХК<br>**4.** “Баянтэгш импекс” ХХК<br>**5.** “Да Сайн Уул” ХХК<br>**6.** “Улаанбаатар төмөр замын Чулуун завод” ХК<br>**7.** “Тэнүүн байгаль” ХХК<br>**8.** “Чинхаш” ХХК<br>**9.** “Доншен газрын тос Монгол” ХХК<br>**10.** “Монголросцветмет” ХК<br>- 2014 оны 6-р сарын 6-нд Тэсэлгээний мэргэжлийн зөвлөлийн хурлаар УУЯ, ЗХЖШ, МХЕГ, ОБЕГ, ЦЕГ, ТЕГ гэсэн 6 байгууллагын хамтарсан 4 бүсийн шалгалтанд ажлын хэсэгт оролцож санал өгч ажиллав. |
| **2.33. Уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар судалгаа хийх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулах.** | | |
| 2.33.1. ТЭЗҮ, УАТөлөвлөгөө, УАТайлан, албан томилолт, холбогдох байгууллагуудаас мэдээлэл авч нэгтгэх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж УУЯ-нд хүргүүлэх | Тоо хэмжээ –1 судалгаа<br>Хугацаа – жилдээ<br>Чанар -Хууль журмын дагуу | Улын үйлдвэрийн Уулын ажлын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн 2014 оны төлөвлөгөөг хянаж танилцаж, “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль”-ын 26.2 дахь заалтийн дагуу холбогдох зардлыг төлөвлөгөөнд тусгуулах арга хэмжээг авч ажиллаа.<br>- Уулын үйлдвэрийн уулын ажлын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрүүдийн 2013 оны 167 уулын ажлын тайланг мэдээллийн санд нэгтгэхэд “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль”-ын 26.2 дахь заалтийн дагуу зарцуулах зардлын биелэлт 60-65/*62,9*/%-тай байгаа бөгөөд биелэлттэй холбоотой холбогдох тайлбарыг авсан.<br>- Уул уурхайн салбарт 2014 оны байдлаар хүний амь нас эрсэдсэн 4 ослын мэдээллийг албан болон албан бус мэдээллээр авч бүртгэлээ.<br>- Адил-Оч ХХК /мэдээллийг албан бичиг хүргүүлэн ослын талаарх мэдээллийг авсан.<br>- Уулс ноён ХХК /Утсаар холбогдож ослын мэдээ ирүүлэхийг шаардсан боловч цагдаагийн газарт шалгагдаж байгаа гэсэн шалтгаанаар ирүүлээгүй/<br>- Налайх хувиараа ХХК /УУАА-аас/<br>- МАК ХХК-Адуунчулуу /мэдээллийг НСХэлтсээс/ |
| **2.34. Геологи, уул уурхайн салбарын хөгжлийн стратегийг боловсруулах богино, дунд хугацааны олборлох, боловсруулах үйлдвэрлэл, экспортын бүтээгдэхүүний хэмжээ, шаардагдах дэд бүтцийн төсөөллийг хийх.** | | |
| 2.34.1. Уул уурхайн сайдын 195 тушаалаар байгуулагдсан “Экспортын орлогыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх болон геологи, уул уурхайн салбарын хөгжлийн | Тоо хэмжээ –1 ажлын хэсэг<br>Хугацаа - Тухайн үед<br>Чанар - Үндэслэл бүхий | 1. Ажлын хэсэг 2 удаа хуралдсан бөгөөд ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн даргын шаардсан мэдээллүүдийг тухай бүр гаргаж өгч ажилласан ба тухайн ажлын хэсэг зорилтот ажлаа биелүүлсэн, дараагийн шатны ажлын хэсгийг байгуулах нь зүйтэй гэж ажлын хэсгийн |

| | | |
|---|---|---|
| стратегийг боловсруулах байнгын ажиллагаатай ажлын хэсэгт орж ажиллах, холбогдох судалгаа, мэдээллээр хангах | хэрэгжихүйц тайлбар, судалгаа өгч ажиллана | дарга шийдвэрлэсэн тул Уул уурхайн сайдын 51 тоот тушаалаар Дэд сайдаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулан ажиллав.<br>2. Уул уурхайн сайдын 51 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллан, тушаалын хавсралтаар батлагдсан удирдамжийн дагуу 2014 онд хийх ажлын төлөвлөгөө гаргаж УУ-н Сайдаар батлуулан, төлөвлөгөөний дагуу Ашигт малтмалын газрын хэмжээнд хийгдсэн ажлын биелэлтийг сар бүрийн 20-ны дотор гаргаж цахим шуудан болон албан тоотоор УУ-н дэд сайд болон мэргэжилтэн Ш.Эрдэнэцэцэг-т хүргүүлж ажиллав.<br>3. ҮАБЗ-өөс ирүүлсэн албан тоотын дагуу манай улсын стратегийн ач холбогдол бүхий ордуудтай өрсөлдөх хэмжээний ямар ордууд ОХУ, БНХАУ (мужууд орсон), азийн бусад орнуудын томоохон ордын судалгааг Интернэтээс авч орчуулан ордын байршилыг харуулсан зураг, санал, дүгнэлт гаргав. Түүнчлэн энэ материалыг ТЕГ-ын хэрэгцээнд зориулан авсан. |
| **2.35. Томоохон тодорхой ордуудад техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажлын төлөвлөлт хийгдэж байгаа эсэх талаар газар дээр нь очиж танилцах, дүгнэлт гаргах** | | |
| 2.35.1. Орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу уулын ажлын төлөвлөлт хийгдэж байгаа эсэхэд хяналт тавих. | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Хууль журамд нийцсэн, шуурхай, үр дүнтэй байна | 2014 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутагт орших “Баян айраг эксплорэшн” ХХК-ийн ТЭЗҮ –ийн дагуу уулын ажлын төлөвлөлт хийгдэж байгаа эсэхэд УУЯ, Завхан аймгийн байгаль орчны газар, АМГ-ын холбогдох мэргэжилтнүүд хамтран хяналт тавьж ажиллав. |
| **2.36. Геологийн хувьд нэгдмэл тогтоцтой, ордуудын тусгай зөвшөөрлийг хэсэгчилж олгохгүй байх асуудлыг шийдвэрлэнэ. /ЗГҮАХХАХТ – 40.16-р заалт/** | | |
| 2.36.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийн талбайн хэмжээ болон геологи хайгуулын ажлаар тогтоогдсон нөөцийн талбайн хэмжээнд судалгаа хийж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, санал, дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Хууль журамд нийцсэн, шуурхай, үр дүнтэй байна | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд геологийн хувьд нэгдмэл тогтоцтой ордуудын тусгай зөвшөөрлийг хэсэгчилж олгохгүй байх асуудлыг тусгуулахаар санал боловсруулж хүргүүлсэн. |
| **2.37. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хийгдэх бусад ажлууд** | | |
| 2.37.1. Холбогдох байгууллагуудтай хамтран албан томилолтоор ажиллаж, уулын ажлын явц, технологи, байгаль орчны хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй | Тоо хэмжээ –Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - жилдээ | 1. БОНХЯ-наас томилогдсон химийн хортой болон хязгаарлагдсан бодисын дүгнэлт гаргах шинжээчдийн ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж 5-р сарын 6-8-ны өдрүүдэд Баян-Айрагийн уурхайн ажиллав.<br>2. Дарханы төмөрлөгийн үйлдвэрт технологийн шинэчлэл хийх |

| | | |
|---|---|---|
| ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл, байдалтай газар дээр нь танилцах | Чанар -Хууль журамд нийцсэн, шуурхай, үр дүнтэй байна | зорилтын хүрээнд хуурай, нойтон баяжуулах үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцах томилолтоор Хэрлэн, Оюунцэцэг, Дэлгэржаргал, Зоригтсайхан ажиллаж, томилолтын дагуу УУЯ, ЭХЯ, МХЕГ-т 5-4348, 5-4339, 5-4338 дугаар албан бичиг хүргүүлэв.<br>3. ОҮИТБС-ын ажлын алба болон Алт олборлогчдын холбоотой хамтран Төв аймгийн Заамар суманд 2014 оны 5 дугаар сарын 7-ноос 9-ний хооронд ОҮИТБС-ын дэд зөвлөлийн нээлттэй өдөрлөг, сургалт сурталчилгааг зохион байгуулахаар албан томилолтоор 1 мэргэжилтэн ажиллуулсан.<br>4. Алт олборлогчид болон аймаг, орон нутгийн удирдлагуудад алт хөтөлбөрийг дэмжих ажлын хүрээнд Уул уурхайн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Алтны холбоо зэрэг байгууллагуудтай хамтарсан албан томилолтоор Төв, Булган, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад 1 мэргэжилтэн ажиллуулсан.<br>5. “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, хадгалах байр, агуулахын аюулгүйн бүс тогтоох” комиссын бүрэлдэхүүний хүрээнд Уул уурхайн яам, Тагнуулын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, ОБЕГазар зэрэг байгууллагуудтай хамтарсан албан томилолтоор зүүн бүсийн Багануур, Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймагт 3 мэргэжилтэн ажиллуулсан.<br>6. “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчны тухай” хууль, “Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай” хууль, “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”, “Газрын хэвлийн тухай” хууль, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хууль тогтоомж, дүрэм, журмуудын заалтуудын биелэлтийн байдалтай газар дээр нь танилцаж, санал, дүгнэлт өгөх төлөвлөгөөт томилолтын дагуу Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад 2014.07.28-08.18-ны өдрүүдэд мэргэжилтэн 3 мэргэжилтэн ажиллуулсан<br>7. 2014.08.25-09.14-ний өдрүүдэд Төв аймгийн Заамар сум, Булган аймгийн Бүрэгхангай сум, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад 3 мэргэжилтэн ажиллуулсан.<br>8. 2014.06.18-07.09-ний өдрүүдэд Төв, Говьсүмбэр, Дорноговь аймгуудад 3 мэргэжилтэн ажиллуулсан.<br>9. 2014 оны 8-р сарын 28-наас 9-р сарын 1-нийг хүртэл Монголросцветмет ХХК-ийн Түйн голын хайгуулын талбайтай газар дээр нь танилцахаар УУЯ, БОНХЯ, Монголросцветмет компанийн |

| | | |
|---|---|---|
| | | удирдлагуудын хамтран Баянхонгор аймгийн Эрдэнэцогт суманд 1 мэргэжилтэн ажиллуулсан<br>10. АНУ-ын Азийн сантай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу Сэлэнгэ аймгийн Мандал суманд томилолтоор ажиллав.<br>11. ХБНГУ-ын Геологийн шинжлэх ухаанууд ба эрдэс баялгийн хүрээлэнгийн “Эрдэс баялгийн эдийн засаг ба хүний нөөцийн чадавхижуулалт” төслийн удирдагч ноён Рольф Муфф болон ХШҮСМХ-ийн 1 мэргэжилтэнтэй хамт “БОЛД ТӨМӨР ЕРӨӨ ГОЛ” ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Ерөө сум дахь төмрийн хүдрийн уурхай ба баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа, төмөр замын байгууламжтай танилцах, мэдээлэл авах, орчуулга хийх зорилгоор томилолтоор ажиллав.<br>12. АНУ-ын Азийн сантай хамтран ажиллах төлөвлөгөөний дагуу бичил уурхайн хямд төсөр нөхөн сэргээлтийн загвар бий болгох газруудыг сонгох ажлын хэсэгт орж, Хэнтий аймгийн төв Чингис хот, Бэрх, Норовлин сумдуудад томилолтоор ажиллав.<br>13. Швейцарын хөгжлийн агентлагийн Тогтвортой бичил уурхай төслийн 4 дэх үе шат эхлэх гэж байгаатай холбогдуулан олон улсын зөвлөхүүд ирсэн тул агентлаг дээр зохион байгуулагдсан уулзалтанд оролцов.<br>14. ХБНГУ-ын Геологийн шинжлэх ухаанууд ба эрдэс баялгийн хүрээлэнгийн “Эрдэс баялгийн эдийн засаг ба хүний нөөцийн чадавхижуулалт” төслийн удирдагч ноён Рольф Муфф болон ХШҮСМХ-ийн 1 мэргэжилтэний хамт Эрдэнэт үйлдвэр, “Эрдмин” ХХК-ийн Эрдэнэт хот дахь уурхай ба баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж, мэдээлэл авах, орчуулга хийх зорилготой томилолтоор явж ажиллав.<br>15. АНУ-ын Азийн сангийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Байгаль орчныг нэмэгдүүлэхэд талуудын оролцоог нэмэгдүүлэх нь-II” төсөл болон Швейцарийн хөгжлийн агентлагийн “Тогтвортой бичил уурхай төсөл” –тэй хамтран “Зардал багатай нөхөн сэргээлтийн аргачлалыг нэвтрүүлж, талуудын оролцоотой байгаль орчны төлөвлөгөөг хэрэгжүүлэх замаар бичил уурхай дахь байгаль орчны асуудлыг шийдвэрлэх нь” сэдэвт бүсийн семинарт оролцох зорилгоор Баянхонгор аймагт албан томилолтоор ажиллав.<br>16. Дундговь аймгийн Өлзийт, Хулд сумдуудад МХЕГ-тай хамтарсан томилолтоор ажиллаж уулын ажлын явц, технологи, байгаль орчны хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл, байдалтай газар дээр нь танилцсан. Хулд суманд бичил уурхайн журмыг зөрчсөн үйл ажиллагаа явуулж байсан учир олборлолтоо нь зогсоох |

| | | |
|---|---|---|
| | | тухай МХЕГ-с акт хийсэн. Өлзийт суманд очиход бичил уурхайн дүгнэлтгүй олборлолт явуулж байсан тул олборлолтоо зогсоох тухай МХЕГ-с акт гаргуулсан. |
| 2.37.2. Дотоодын болон Олон улсын салбарын чуулга уулзалтад оролцох бэлтгэлийг хангах ажлыг зохион байгуулах, оролцох (PDAC, Discover Mongolia, уул уурхайн салбарын ойн баяр гэх мэт) | Тоо хэмжээ – Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Шуурхай, үр дүнтэй зохион байгуулсан байна | 2014 онд дараах хурал зөвлөгөөнд холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулсан байна. Үүнд:<br>1. Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрийн Удирдах хорооны хуралдаан,<br>2. 2-р сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Coal Mongolia 2014 чуулга уулзалт,<br>3. Mining Mongolia 2014 чуулга уулзалт,<br>4. Discover Mongolia 2014 олон улсын үзэсгэлэн яармаг,<br>5. УУЯ, Эрдэнэс МГЛ ХХК-ийн хамтран зохион байгуулсан “Эрдэс баялаг 2025” нэгдсэн хэлэлцүүлэг,<br>6. “Discover Mongolia” олон улсын хөрөнгө оруулагчдын нэгдсэн чуулга уулзалт,<br>7. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага” хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан “G7 нд хурдан хүрэх түншлэл” сэдэвт хурал,<br>8. КРИРСКО олон улсын нөөцийн стандартын хорооны чуулга уулзалт,<br>9. “Хүрээлэн буй орчны менежмент болон Нөөцийн хөгжил” сэдэвт семинар,<br>10.“Өмнийн говийн уул уурхай ба усны менежмент” семинар,<br>11. 8-р сарын 28-30-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Уурхайн хаалт ба байгаль орчныг хамгаалал” IX сургалт семинар,<br>12. 2014 оны 9-р сарын 1-2-ны өдрүүдөд “Уул уурхайн нөхөн сэргээлт хаалтын журмын төсөл”-ыг хэлэлцүүлэх Австралийн Олон Улсын Хөгжлын Төвтэй хамтарсан уулзалт,<br>13.11-р сарын 13-14-ний өдрүүдэд “Байгаль орчны бохирдлыг цэвэршүүлэх ажилд ноу-хау нэтрүүлэх” төслийн семинарт,<br>14. 2014.01.15-нд “Эрдэс баялаг 2025” нээлттэй хэлэлцүүлэг,<br>15. 2014.02.13-ны өдөр АНУ-ын Блексмит хүрээлэнгээс санхүүжсэн “Монголын орон нутгийн бичил уурхайчдын тогтвортой амьжиргааг бий болгох, ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх төрийн бус оролцоо, чадавхийг бэхжүүлэх” төслийн эхлэлийн семинарт,<br>16. 2014.03.03-нд ШХА-ын Тогтвортой бичил уурхай төслөөс зохион байгуулсан бичил уурхай эрхлэгчдийн чадавхийг бэхжүүлэх үүднээс |

| | | |
|---|---|---|
| | | жижиг төсөл сонгон шалгаруулалтын талаарх сургалт, танилцуулгын семинар,<br>17. Уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудыг чадавхжуулах, тогтвортой үйл ажиллагаа явуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Монголын геологчидын V чуулган (2014.04.04-нд),<br>18. ШХА-ийн ТБУТ-ийн 4 дэх шатанд хийгдэх ажлуудын онцлог, үр дүн, хүндрэл бэрхшээлийн талаар хэлэлцэх хурал,<br>19. Алтны ил тод байдал болон бичил уурхайгаар олборлосон алтны талаар хурал,<br>20. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн 1 сарын аяны хүрээнд Монголын Үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордонд зохион байгуулагдсан үзэсгэлэн яармагт тус тус идэвхтэй оролцсон.<br>21. Мөн PDAC олон улсын хуралд зориулан уул уурхайн салбарын мэдээллийг бэлтгэж, Mongolia Mining олон улсын уул уурхайн үзэсгэлэнг зохион байгуулах ажилд оролцон, уул уурхайн салбарын сайдын илтгэлийн төслийг боловруулж, 2014.10.20-21-ны өдрүүдэд Монголын эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбооноос зохион байгуулсан "Дэлхийн өмнөд хэсэгт нийгмийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн хөдөлмөрийн зорилтыг хөгжүүлэх нь" сэдэвт олон улсын бага хурал, 2014.10.23-ны өдөр Ашигт малтмал баяжуулагчын холбооноос зохион байгуулсан "Эрдэс боловсруулалт-2014" эрдэм шинжилгээний бага хурал, Сэлэнгэ аймгийн Мандал суманд "Байгаль орчныг хамгаалахад талуудын оролцоог нэмэгдүүлэх нь- II" төслийн зөвлөгөөн семинарт тус тус илтгэл тавьж оролцсон байна. |
| 2.37.3. Уул уурхайн сайд 2012 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 67 тоот тушаалын дагуу жил бүрийн 12 дугаар сарын 2 дахь 10 хоногт багтааж Геологи, уул уурхай, газрын тосны салбарын шилдэг аж ахуйн нэгж, байгууллага шалгаруулах журмын дагуу Уул уурхайн салбарын шилдэг аж ахуйн нэгжүүдийг тодруулна | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - IV улиралд<br>Чанар - Зохих дүрэм, журмын дагуу шуурхай зохион байгуулна | Уул уурхайн салбарын шилдэг байгууллага шалгаруулах шалгаруулалтыг Уул уурхайн сайдын 2012 оны 11-р дүгээр сарын 29-ний өдрийн 67 тоот тушаалаар батлагдсан "Геологи, уул уурхайн салбарын шилдэг аж ахуйн нэгж, байгууллага шалгаруулах журам"-ын дагуу шалгаруулах зарыг Ашигт малтмалын цахим хуудсанд байршуулан аж ахуйн нэгжүүдээс материалыг хүлээн авч Уул уурхайн яаманд дээр байгаа ажлын хэсэгт хүргүүлсэн. 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдөр шалгаруулахаар төлөвлөөд байна. |
| **Гурав. "*Уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад нүүрсний салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах, бодлогын удирдамжийг нь хэрэгжүүлэх, энэ салбарт хөрөнгө оруулалтын орчинд үнэлэлт, дүгнэлт өгөх, түүнийг сайжруулах санал, судалгаа боловсруулах*" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:** | | |

| | | |
|---|---|---|
| **3.2. “Нүүрсний салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө” боловсруулах /ЗГҮАХХАХТ – 102.2/** | | |
| 3.2.1. Япон улсын “ЖАЙКА” байгууллагын гүйцэтгэж буй “Нүүрсний салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө” –ний гүйцэтгэлийг монгол хэл дээр боловсруулсан тайлантай нь танилцан, УУЯ-тай хамтран хүлээн авах. | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - I улирал<br>Чанар - Тавигдах шаардлагад нийцсэн байна | ЖАЙКА байгууллагын боловсруулсан “Нүүрсний салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-ний Англи хэл дээрх тайланг судалж 30 хуудас хураангуйлсан танилцуулга бэлтгэн үйл ажиллагаа, судалгаанд ашигласан. |
| **3.4. Стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордуудын талаар хийгдэх ажлууд / ЗГҮАХХАХТ-43 заалт/** | | |
| 3.4.1. Стратегийн ач холбогдолтой болон ач холбогдолтой байж болох нүүрсний ордуудын шаардлагатай мэдээлэл, танилцуулгыг бэлтгэж холбогдох байгууллагыг мэдээллээр ханган хамтран ажиллах. | Шаардлагатай тоо хэмжээгээр тухай бүр үнэн зөв, бодитой мэдээлэл байна | 1. Цайдамнуур, Хөшөөтийн ордыг Стратегийн ордод хамааруулахад шаардлагатай мэдээлэл, материалыг боловсруулж Ажлын хэсэгт тухай бүр хэвлэмэл болон цахим байдлаар хүргүүлсэн.<br>2. Пибоди Винсвэй Ресорсез ХХК-ийн Цайдамнуурын орд дахь хайгуулын ажлын нөөцийн тайлангийн мэдээллийг Стратегийн ордын судалгаанд нэмж боловсруулсан.<br>3. УУЯ, МУ-ын Засгийн газраас Ашигт малтмалын зарим ордыг эхний ээлжинд Стратегийн ач холбогдол бүхий ордод нэмж хамруулах тухай УИХ-д өргөн барих тогтоолын төслийн танилцуулгад Цайдамнуурын хүрэн нүүрсний ордын хураангуй мэдээллийг боловсруулж УУЯ-ны БХЗГ-т танилцуулсан.<br>4. Цайдамнуурын хүрэн нүүрсний ордыг Стратегийн ордод хамруулахад эсрэг саналтай байгаагаа илэрхийлсэн “Цэцэнс майнинг энд энержи” ХХК-ийн нэмэлт мэдээллийг шинэчлэн боловсруулж УУЯ-ны БХЗГ-т танилцуулан цахим байдлаар хүргүүлсэн. |
| 3.4.2. Нүүрсний чанарын судалгааг орд тус бүрээр нь ангилан гаргах, стратегийн ач холбогдол бүхий нүүрсний ордуудын чанарын судалгааг нарийвчилан судалж, холбогдох аж ахуйн нэгж болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллах | Тоо хэмжээ – Судалгаа хийгдэх ордын тоогоор<br>Хугацаа - жилдээ<br>Чанар - Журмын хүрээнд шуурхай зохион байгуулна | Хүрэн нүүрсний Багануур, Шивээ-Овоо, экспортын нүүрсний Таван толгой, Нарийн Сухайтын нүүрсний ордуудын хайгуулын ажлын нөөцийн тайлангуудаас техникийн болон коксжих чанар, үнсэнд агуулагдах микро элемент зэрэг чанарын үзүүлэлтүүдийн дэлгэрэнгүй судалгааг гаргасан. |
| **3.5. Нүүрсний ордуудын ТЭЗҮ, уулын ажлын төлөвлөгөө, тайлантай холбогдолтой хийгдэх ажлууд** | | |
| 3.5.1. Нүүрсний орд ашиглах ТЭЗҮ-ийг заавар шаардлагад нийцүүлэн хянаж ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх. Орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх ЭБМЗ-ийн хуралдаанд оролцох. | Тоо хэмжээ – 2 арга хэмжээ<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар -Шуурхай, хууль журмын хүрээнд | Нүүрсний орд ашиглах, нүүрс баяжуулах, шингэн түлш үйлдвэрлэх 23 техник-эдийн засгийн үндэслэлийг танилцах хуудсаар хянаж ЭБМЗ-д хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. ЭБМЗ-ийн хуралд тухай бүр оролцож ажилласан. |
| 3.5.2. ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэгдэж батлагдсан ТЭЗҮ-ийг холбогдох | Тоо хэмжээ – Батлагдсан ТЭЗҮ-ийн тоогоор | 1. НХ-ийн мэргэжилтнүүдээр хянагдаж ЭБМЗ-д шилжүүлсэн 23 ТЭЗҮ-ийн санал, зөвлөмж бүхий танилцах хуудсыг жагсаалтаар бүртгэсэн. |

| | | |
|---|---|---|
| мэдээллийн санд бүртгэх | Хугацаа - Тогтмол<br>Чанар -Тавигдах шаардлагад нийцсэн байна | 2. ЭБМЗ-өөр хэлэлцэж шийдвэрлэсэн 74 ТЭЗҮ-ийн дүгнэлт, тушаалыг жагсаалтаар нэгтгэн товьёог үйлдэж бүртгэлжүүлсэн. |
| 3.5.3. Нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүдийн уулын ажлын төлөвлөгөөг заавар шаардлагад нийцүүлэн хянаж хүлээн авах, шаардлагатай мэдээллүүдийг мэдээллийн санд нэгтгэх, үнэлэлт, дүгнэлт өгөх. | Тоо хэмжээ – 2 арга хэмжээ<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар -Тавигдах шаардлагад нийцсэн байна | 2014 оны онд нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүд 58 ширхэг уулын ажлын төлөвлөгөөг (нэмэлт болон тодотгол) АМГ-ын НХ-т ирүүлснийг хэлтсийн холбогдох мэргэжилтэн нараар танилцуулж, засваруудыг хийлгэн, 52 ширхэг төлөвлөгөөг заавар шаардлагад нийцүүлэн баталж, хүлээн авсан. Үүнээс 45 ширхэг нь МХЕГ-аар батлагдан ирсэн.<br>Мөн нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүдээс 2015 оны уулын ажлын 55 ширхэг төлөвлөгөөг хүлээн авч танилцан, хянаж байна. |
| 3.5.4. Нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүдийн уулын ажлын тайланг заавар шаардлагад нийцүүлэн хянаж хүлээн авах, шаардлагатай мэдээллүүдийг мэдээллийн санд нэгтгэх, үнэлэлт, дүгнэлт өгөх. | Тоо хэмжээ – 2 арга хэмжээ<br>Хугацаа – жилдээ<br>Чанар -Тавигдах шаардлагад нийцсэн байна | Нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүд 40 ширхэг 2013 оны уулын ажлын тайланг АМГ-ын НХ-т ирүүлснийг хэлтсийн холбогдох мэргэжилтэн нараар танилцуулж, засваруудыг хийлгэн 35 ширхэг тайланг заавар шаардлагад нийцүүлэн хүлээн авснаас 27 ширхэг нь МХЕГ-аар батлагдан ирсэн. |
| 3.5.5. Уулын ажлын тайлан, төлөвлөгөөг цахим хэлбэрээр хүлээн авах болсонтой холбогдуулан нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүдэд маягтуудыг хэрхэн бөглөх талаар зааварчилгаа өгөх, сургалт семинар зохион байгуулах, гарын авлага бэлтгэж харилцагчдад тараах. | Тоо хэмжээ – 2 арга хэмжээ<br>Хугацаа - I улирал<br>Чанар - Үр дүнтэй, шуурхай зохион байгуулна | 1. Нүүрсний уурхайн "Уулын ажлын төлөвлөгөө, тайлан хүлээн авах заавар"-ыг шинэчлэн боловсруулж Ашигт малтмалын газрын даргын 2013 оны 10-р сарын 22-ны өдрийн 408 тоот тушаалаар батлуулж АМГ-ын Веб сайтад байршуулсан.<br>2. Шинэчлэгдсэн зааврын агуулга, маягтыг хэрхэн бүрдүүлэх зааварчилгаа, сургалтыг 2014 оны 5-р сарын 22-ны өдөр нүүрс олборлогч 33 ААН-ийн 53 инженер техникийн ажилтнуудын дунд зохион байгуулж мэргэжилтнүүдээс зөвлөмж, зааварчилгаа өгсөн. Сургалтын илтгэл, материалыг хэвлэж ААН-үүдэд тараасан.<br>3. Уулын ажлын төлөвлөгөө тайлан хүлээн авах маягт загвар өөрчлөгдсөнтэй холбогдуулан нийт 49 компанид албан бичгээр мэдээлэл хүргүүлсэн. |
| 3.5.6. Нүүрсний уурхайнуудын техник эдийн засгийн үндэслэлийн үндсэн үзүүлэлтүүдийг нэгтгэсэн нэгдсэн санг бий болгох. | Тоо хэмжээ – 1 сан<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар - Мэдээллийн сантай болсон байна | 1. Техник эдийн засгийн үндэслэлийн үндсэн үзүүлэлтүүдийн нэгдсэн загварыг 39 үзүүлэлтээр нэгтгэн нийт 30 ТЭЗҮ-ийн үндсэн үзүүлэлтийг багтаасан нэгдсэн сан үүсгэсэн.<br>2.Нүүрсний ашиглалтын 245 тусгай зөвшөөрөлд ТЭЗҮ хийгдсэн болон хийгдээгүй судалгааг хийж хүчин чадлын үзүүлэлт, үйл ажиллагаа явуулж байгаа болон явуулаагүй тусгай зөвшөөрлөөр нэгтгэн гаргасан. |
| **3.6. Байгаль орчинд сөрөг нөлөө бүхий техник технологийн судалгааг гаргах, санал боловсруулах** | | |
| 3.6.1. Нүүрсний уурхайнуудын байгаль | Тоо хэмжээ – | 2014 оны уулын ажлын төлөвлөгөө ирүүлсэн 53 уурхай, тайлан |

| | | |
|---|---|---|
| орчныг хамгаалах үйл ажиллагааны судалгаа, мэдээллийг нэгтгэн боловсруулах | Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар -Мэдээллийн сантай болно | ирүүлсэн 38 уурхайн техник технологи, тоног төхөөрөмжүүдийн дэлгэрэнгүй судалгааг нэгтгэн нэгдсэн санг оруулсан.<br>Байгаль орчныг хамгаалахад гарч буй зардал ба нийт хийгдсэн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын гол үзүүлэлтүүдийг нэгтгэн өмнөх онуудад гаргасан мэдээллийн сангийн нэгдсэн үзүүлэлтүүдтэй харьцуулаж судалгаа хийн мэдээллийн санг баяжуулав. |
| **3.7. Байгаль орчны бохирдол, доройтол, байгалийн нөөцийн ашиглалтад тавих хяналтыг эрчимжүүлж, уул уурхайн нөхөн сэргээлтийн хэмжээг 70-аас доошгүй хувьд хүргэх /ЗГҮАХХАХТ-54.3 заалт/** | | |
| 3.7.1. Нүүрс олборлогч уурхайнуудын уулын ажилд өртсөн газрын хэмжээг тодорхойлж, мэдээллийг нэгтгэн сан үүсгэж судалгаа гаргах. | Тоо хэмжээ – 1 сан<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар -Мэдээллийн сантай болно | 2013 оны уулын ажлын тайлангаар нийт 41 уурхайн үзүүлэлтийг нэгтгэн харвал уулын ажилд өртсөн талбай 6355.82 га, үүнээс 422.83 га талбай нь шинээр эвдрэлд өртсөн байна. |
| 3.7.2. Нүүрсний уурхайнуудын нөхөн сэргээлтийн ажлын явц, үр дүнг нэгтгэн гаргаж танилцуулга бэлтгэх | Тоо хэмжээ – 1 танилцуулга<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар -Үнэн зөв, бодитой мэдээлэл байна | Нийт нүүрсний уурхайнуудын нөхөн сэргээлтийн хэмжээг 2013 он уулын ажлын тайлангийн үе шатанд тодорхойлов. Нөхөн сэргээлтийн гүйцэтгэл 70 орчим хувьтай байна. 2013 онд нөхөн сэргээлт хийсэн нийт талбай 86.36 га байна. |
| 3.7.3. Нөхөн сэргээлт хийгдсэн газрын нийт хэмжээг уулын ажилд өртсөн газрын хэмжээтэй харьцуулж үнэлэлт, дүгнэлт, санал боловсруулан холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангана. | Тоо хэмжээ – 1 санал<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар - Үнэн зөв, бодитой мэдээлэл байна | Уулын ажилд өртсөн нийт газрын хэмжээг нөхөн сэргээлт хийсэн талбайтай харьцуулалт хийн дүгнэлт гарган ажиллав. Дүгнэлтээр жил бүр уурхайлалтанд шиээр өртөж байгаа газруудын 20 орчим хувьтай тэнцэх хэмжээний газрыг нөхөн сэргээж байна. |
| **3.8. Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын Холбооны стандартыг нутагшуулж мөрдүүлэх үйл ажиллагаанд хамтран оролцох** | | |
| 3.8.1. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр 1 стандарт, нөхөн сэргээх 2 аргачлал, 1 журмын төслийг нүүрсний уурхайнуудын онцлогтой уялдуулан Байгаль орчин ногоон хөгжлийн яам, боловсруулах тендерт шалгарсан компанитай хамтран ажиллах | Тоо хэмжээ – 1 стандарт, 2 аргачлал, 1 журмын төсөл<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар -Үнэн зөв, бодитой мэдээлэл байна | Уул уурхайн сайдын 2013.10.02 -ны 203 тоот тушаалаар байгуулагдсан Нүүрсний шинж чанар, боловсруулалтын түвшингээр нарийвчилсан судлагаа хийж, олон улсын жишигт нийцсэн ангиллын стандарт боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, Нүүрсний чанарын ангилал, Нүүрс-нүүрсэн бүтээгдэхүүний ангиллыг эцэслэн боловсруулж, СХЗ-ын Стандартын үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн “Нүүрсний ангилал MNS 6456:2014”, “Нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний ангилал MNS 6457:2014” стандарт болгон батлуулсан. 2014 оны 06 дугаар сарын 12-ноос Улсын бүртгэлд бүртгэгдэж хүчин төгөлдөр болсон.<br>Энэ ажлын хүрээнд Стандартчилал хэмжилүйн газар болон Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны хамтран боловсруулсан Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийн шороон боомтын хийц, |

| | | |
|---|---|---|
| | | материалын нягтруулга, Эвдэрсэн газрын хөрсний нөхөн сэргээлтэд хаягдлын лагийг ашиглах, Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийн геонийлэг доторлогоо, Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийн ашиглалтын үйл ажиллагааны хяналт, шинжилгээ, Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийг хааж нөхөн сэргээх ба хаасны дараах хяналт, шинжилгээ, Уул уурхайн үйлдвэрлэлийн хаягдал агуулах байгууламжийн зэрэглэл зэрэг 8 стандартын төсөлд өгөх саналыг нэгтгэн хүргүүлэв. |
| **3.9. Ашигт малтмалыг экспортод гаргахтай холбоотой эрх зүйн орчныг бүрдүүлж, эрдэс баялгийн экспортыг нэгдсэн "Нэг цонх"-ны бодлогоор хэрэгжүүлэх ажлын хүрээнд /ЗГҮАХХАХТ-41.1 заалт/** | | |
| 3.9.1.Экспортонд гарч буй нүүрс болон нүүрсэн бүтээгдэхүүнийг "Нэг цонх"-ны бодлогоор хэрэгжүүлэх үйл ажиллагааны бодлогыг боловсруулах судалгааны ажлыг аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, эхлүүлэх. | Тоо хэмжээ –1 судалгааны ажил<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар - Судалгаа үнэн бодитой байна | Экспортонд гарч байгаа нүүрс болон нүүрсэн бүтээгдэхүүний үнийн судалгааг гарган 7 хоног бүр УУЯ-нд хүргүүлэн ажилласан.<br>2012-2014 онуудын олборлолт экспортын мэдээллийг графикийн хамт гарган ажлын хэсгийн ахлагч УУЯ-ны Уул уурхайн бодлогын хэлтэст цахим шуудангаар явуулав.<br>Нүүрс экспортлогч аж ахуй нэгжүүдтэй хамтран экспортод гарч байгаа нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн болон тулгамдаж байгаа асуудлуудын талаар 4 удаа мэдээлэл танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулан ажилласан. |
| **3.10. Эрчим хүчний системийн болон орон нутгийн хэрэглэгчдийн нүүрсний хангамжийг хянан зохицуулах** | | |
| 3.10.1. Дулааны цахилгаан станцуудын нүүрсний хангамжийн байдлыг хянах, эрчим хүчний болон орон нутгийн нүүрсний уурхайнуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж, танилцуулга бэлдэж, дүгнэлт гарган удирдлагад танилцуулна. . | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар - Үр дүнтэй, үнэн зөв, бодитой мэдээлэл байна | ДЦС-уудын гаднах нүүрс нөөцлөлтийн мэдээ болон бусад мэдээллийн хамт 7 хоног бүр 7 хуудас бүхий мэдээлэл бэлтгэн удирдлагыг мэдээллээр хангаж ажиллаж байна. Станцуудын гадна нийт 393,6 мян.тн нүүрсний нөөц байна.<br>Эрчим хүчний болон орон нутгийн нүүрсний уурхайнуудын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах зорилгоор 2014-2015 оны өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг нэгтгэв. Үүнээс: Багануурын уурхай 97 ажил, Шивээ-Овоогийн нүүрсний уурхай 54 ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд 12 дугээр сарын 10-ны байдлаар өвөлжилтийн бэлтгэл ажлын явц 80 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна. /Нийт 4 удаа танилцуулга бэлтгэсэн/<br>Төвийн бүсийн эрчим хүчний системийн нүүрсний хангамж, хэрэглээний судалгааг төвийн бүсийн нүүрсний уурхайнуудын товч танилцуулгуудыг хийсэн. /Нийт 22 хуудас/ |
| 3.10.2 Улаанбаатар хотын айл өрхийн нүүрсний хэрэглээ болон нүүрсний хангамжийн шинэ эх үүсвэрийг судлах. | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - Жилдээ | Улаанбаатар хотын хэмжээнд гэр хорооллын 183,0 мянга гаруй өрх өвлийн улиралд 800,0-1100,0 мянган тонн нүүрс хэрэглэдэг байна. Иймд утаа багатай хагас коксон шахмал түлш болон үнэ хямдтай нүүрсээр |

| | | |
|---|---|---|
| | Чанар - Судалгаа үр дүнтэй байна | айл өрхийг хангах судалгааны ажлыг эхлүүлсэн бөгөөд аж ахуй нэгжийн нүүрсний жилийн хэрэглээг судалж зорилгоор нийслэлийн 6 дүүргийн засаг дарга нарт “Мэдээлэл хүсэх тухай” албан тоот хүргүүлэв. (7/5229-7/5234 тоотуудаар)<br>Дүүргүүдээс ирүүлсэн мэдээллээр 5 хуудас бүхий товч танилцуулга бэлтгэв. |
| **3.11. Экспортод гаргаж байгаа нүүрсний чанарын ангиллын стандартыг олон улсын жишигт нийцүүлэх талаар судалгаа хийж хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэх** | | |
| 3.11.1. Шинээр үйл ажиллагаагаа эхэлж буй нүүрс экспортлогч аж ахуйн нэгжүүдийн бүртгэл судалгааг гаргаж удирдлага болон харъяа Яаманд танилцуулна. | Тоо хэмжээ –1 судалгаа<br>Хугацаа – 2-р улиралд<br>Чанар - үнэн зөв, бодитой мэдээлэл байна | “Жавхлант Орд” ХХК-ийн Өмнөговь аймгийн Гурван тэс сумын нутагт орших Зангант-Уулын нүүрсний ордын танилцуулгыг бэлтгэв.<br>Өмнөговь аймгийн Ноён сумын нутагт орших “Терра энержи” ХХК-ийн Баруун ноён уулын нүүрсний ил уурхайн товч танилцуулгыг бэлтгэсэн. |
| 3.11.2. Уулын ажлын тайлан төлөвлөгөөнөөс экспортын нүүрсний чанарын мэдээллийг судалж бүртгэж, санг баяжуулах. | Тоо хэмжээ –1 сан<br>Хугацаа – 3-р улиралд<br>Чанар -үнэн зөв, бодитой мэдээлэл байна | 2013 оны уулын ажлын тайлан, 2014 оны уулын ажлын төлөвлөгөө ирүүлсэн экспортын үйл ажиллагаа эрхлэгч Монголын Алт МАК-ийн Нарийн Сухайт, Чинхуа МАК–Нарийн сухайт, Энержи ресурс ХХК-ийн Ухаа худаг, Баруун Наран, Эрдэнэс Таван толгой ХК-ийн Таван толгой, Саус Гоби Сэндс ХХК-ийн Овоот толгойн уурхайн нүүрсний чанарын мэдээллийг бүртгэлд оруулж санг баяжуулав.<br>Уулын ажлын тайлан төлөвлөгөөг цахимаар авдаг болсонтой холбогдуулан програмын өнөөгийн болон ирээдүйн нөхцөл байдлын талаархи санал ХБНГУ-ын уул уурхай хүрээлэнд хүргүүлэх ажлын хэсгийн хуралд сууж санал боловсруулах ажилд оролцсон.<br>55 Уурхай болон баяжуулах үйлдвэрүүдийн Уулын ажлын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс чанарын мэдээлэлийг нэтгэн авч боловсруулж чанарын мэдээллийн санд бүртгэсэн.<br>30 ТЭЗҮ-ний чанарын үзүүлэлтүүдийг чанарын мэдээллийн санд нэгтгэсэн. |
| 3.11.3. Уул уурхайн сайдын тушаалаар ажиллаж буй нүүрсний чанарын ангилал, үнийн асуудлыг шийдвэрлэх ажлын хэсэгтэй хамтран ажиллаж үр дүнг удирдлагад тайлагнах | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар -Шуурхай, үр нөлөөтэй байна | Уул уурхайн сайдын 2013.10.02 -ны 203 тоот тушаалаар байгуулагдсан “Нүүрсний шинж чанар, боловсруулалтын түвшингээр нарийвчилсан судлагаа хийж, олон улсын жишигт нийцсэн ангиллын стандарт боловсруулах ажлын хэсэг”-т ажиллаж, Нүүрсний чанарын ангилал, Нүүрс-нүүрсэн бүтээгдэхүүний ангиллыг эцэслэн боловсруулж, СХЗГ-ийн Стандартчилал Техникийн зохицуулалтын хэлтэст хүргүүлсэн. Уг стандарт нь тус бүр 4 хуудас, нийт 8 хуудас материал болно. |
| 3.11.4. Сангийн яаман дээр байгуулагдсан Экспортод гаргаж байгаа нүүрсний бүтээгдэхүүний жишиг үнэ тогтоох ажлын | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - Тухай бүр | - Уул уурхайн бүтээгдэхүүний жишиг үнэ зарлах ажлын хэсэг сар бүрийн эхний 7 хоногт ажиллаж жишиг үнийн мэдээллийг Уул уурхайн яамны цахим хуудсанд байршуулдаг болсон.. |

| | | |
|---|---|---|
| хэсэгт ажиллаж санал дүгнэлт өгөх. | Чанар -Шуурхай, үр нөлөөтэй байна | - АМНАТ-ийг 2014 оны 4 дүгээр сарын 01-нээс аж ахуйн нэгжийн гэрээний үнээр тооцохоор шийдвэрлэсэнтэй холбогдуулан жишиг үнэ болон гэрээний үнийн хоорондын зөрүүг тооцон судалгаа хийгддэг болсон. |
| **3.12. Нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хянан зохицуулах** | | |
| 3.12.1. Нүүрсний салбарт дахь өрөмдлөг тэсэлгээний үйл ажиллагаа эрхэлж буй туслан гүйцэтгэгчдийн үйл ажиллагаа, зардал, ажиллах хүчний талаар дэлгэрэнгүй судалгаа гаргаж санг баяжуулан ажиллах. | Тоо хэмжээ –1 судалгаа<br>Хугацаа - Жилдээ<br>Чанар -Судалгаа бодитой байна | - Уулын ажлын тайлан, төлөвлөгөө ирүүлсэн аж ахуй нэгжүүдийн нийт ажиллагсад, эмэгтэй, ИТА, гадаад ажилтан, үйлдвэрийн болон бусад ажиллагсдын судалгааг нэгтгэж гаргасан.<br>- Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигын эсрэг үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөөний дагуу тайлан ирүүлсэн 37 нүүрсний уурхайнуудын нийт ажиллагсдын тоо, ИТА, эмэгтэй, үйлдвэрийн ажиллагсад болон гадаад иргэдийн мэдээллийг АМГ-ын сайтанд байршуулсан.<br>- Гадаадаас ажиллах хүч авахаар материал ирүүлсэн "Хур эрдэнэ баялаг" ХХК, “Ти Ти Жи Ви Си Өү” ХХК-ийн мэдээллийг ТЗУХ-т уламжилсан.<br>- УУЯ-ны Түлшний бодлогын хэлтэст Багануур ХК, Шивээ-Овоо ХК, Шарын гол ХК, Эрдэнэс тавантолгой ХК-иудын 2009-2013 оны ажиллагсдын тоо, олборлолтын хэмжээ, хөрс хуулалт, нөөцийн хэмжээ, нийт цалин болон дундаж цалингийн мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн.<br>- 2012, 2013 оны тайлан ирүүлсэн нүүрсний уурхайнуудын ажиллагсдын судалгааг гаргасан<br>- 2014 оны уулын ажлын төлөвлөгөөний хүрээнд нийт 29 уурхайн уулын үйлдвэрлэлийн ажлын бүртгэлийг хийсэн ба өрөмдлөг тэсэлгээний ажил гүйцэтгэх уурхайнуудын мэдээллийг бүртгэн авч санг баяжуулсан. |
| 3.12.2. Нүүрсний үнийн судалгааг цахим хуудсанд байршуулах, салбарын хөрөнгө оруулалтын судалгааг тогтмол гаргах, нүүрсний зах зээлийн судалгаа хийх, нүүрсний компаниудын биржийн мэдээллийг судалж удирдлага болон харъяа байгууллагуудыг мэдээллээр хангах. | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - 7 хоног бүр<br>Чанар -Судалгаа бодитой байна | - 2013 оны уулын ажлын тайлан ирүүлсэн 37 уурхай , 2014 оны уулын ажлын төлөвлөгөө ирүүлсэн 51 уурхайн нүүрсний үнийн судалгаа гаргаж АМГ-ын сайтад байршуулсан.<br>- Экспортонд гарч буй ашигт малтмалын бүтээгдэхүүнийг сар бүрийн зах зээлийн үнийг тогтмол АМГ-ын сайтад байршуулж ажилласан.<br>- 2012 он, 2013 онд тайлан ирүүлсэн нүүрсний уурхайнуудын хөрөнгө оруулалтын мэдээлэл бэлтгэж Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистик мэдээллийн хэлтэст хүргүүлсэн.<br>- Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөл Стратегийн судалгааны хүрээлэнд 2009-2013 оны БНХАУ-ын хөрөнгө оруулалт, Улс орон нутгийн төсөвт оруулсан орлого, 2001-2013 оны БНХАУ-ын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн танилцуулга бэлдэж өгсөн.<br>- Стратегийн ач холбогдолтой 10 нүүрсний уурхайн хөрөнгө оруулалтын |

| | | |
|---|---|---|
| | | мэдээлэл гаргасан.<br>- Хилийн дагуух 22 нүүрсний уурхайн хөрөнгө оруулалтын мэдээлэл бэлтгэсэн.<br>- Дэлхийн коксжих нүүрсний нөөц, эрэлт, нийлүүлэлт, хэрэглээний талаар танилцуулга бэлтгэж АМГ-ын вэб сайтад байршуулсан.<br>- 2014 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгасан жилийн хүчин чадал, хөрөнгө оруулалтын мэдээлэл гаргасан. |
| 3.12.3. Нүүрсний үнэ, хөрөнгө оруулалт, АМНАТ, УОНТООрлого, Борлуулалтын орлого, Нийт зардлуудыг нэгтгэсэн санг баяжуулах | Тоо хэмжээ –1 мэдээллийн сан<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар -Судалгаа бодитой, үнэн зөвбайна | - 2013 оны уулын ажлын тайлан ирүүлсэн 40 уурхай, 2014 оны төлөвлөгөө ирүүлсэн 54 нүүрсний уурхайнуудын үнэ, хөрөнгө оруулалт, АМНАТ, УОНТОО, Борлуулалтын орлого, Нийт зардал, ашгийн татвар, тусгай зөвшөөрлийн төлбөр, ус ашигласны төлбөр, газар ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, ажиллагсдын тоо гэх мэт эдийн засгийн мэдээллүүдийг нэгтгэж мэдээллийн сан үүсгэж ажилласан.<br>- Уул уурхайн яамны Түлшний бодлогын газарт Олон улсын коксжих нүүрсний үнийн өсөлт, бууралтыг сүүлийн 5 жилийн байдлаар мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн.<br>- Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн орлогын хэлтсээс 2014 оны Улс орон нутгийн төсөвт оруулсан орлогын мэдээлэл авч нэгтгэсэн.<br>- Нүүрсний салбарын нөөц, хэтийн төлөв, үнэ, хэрэглээ, экспорт болон олборлолт, боловсруулалт, гол импортлогч орон, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн талаарх танилцуулга бэлтгэсэн.<br>- 2009-2014 оны хөрөнгө оруулалтын байдал, цаашид хөрөнгө оруулалтыг хэрхэн нэмэгдүүлэх талаар төсөөлөлд санал өгсөн. |
| 3.12.4. Нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүдийн олборлолтын үйл ажиллагааг хянах, олборлолт, борлуулалт болон үнийн мэдээллийн санг баяжуулан, сар, улирал, жилээр мэдээлэл гаргаж, үнэлэлт, дүгнэлт өгөх | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа – 3-р улиралд<br>Чанар -Судалгаа бодитой, үнэн зөв байна | Нүүрсний уурхайнуудын сар бүрийн хөрс хуулалт, нүүрс олборлолт, борлуулалт болон экспортын борлуулалт болон үнийн мэдээ төрлөөр нэгтгэн боловсруулж УУЯ болон удирдлагад танилцуулж ажиллав. Нийт 11 удаа мэдээлэл гаргасан болно.<br>Эрчим хүчний нүүрсний уурхайнуудаас ДЦС-уудад нийлүүлсэн нүүрсний хуримтлагдсан авлагын мэдээг сар бүр гаргаж ажилласан. 2014 оны 11 сарын байдлаар 16.2 тэрбум төгрөг болсон бөгөөд оны эхнээс 10.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.<br>Нүүрс олборлогч аж ахуйн нэгжүүдийн олборлолтын үйл ажиллагааг хянах, олборлолт, борлуулалт болон үнийн мэдээллийг сар бүр гарган 5-8 хуудас бүхий танилцуулга бэлтгэн хэлтэс, тасгийн даргад танилцуулсан. /4 удаа / |

| | | |
|---|---|---|
| 3.12.5. Нүүрс экспортлогч аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй судалгааг үргэлжлүүлэх, экспортонд ачуулсан нүүрсний борлуулалтын судалгаа гарган мэдээллийн санг баяжуулах. | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа – 4-р улиралд<br>Чанар -Судалгаа бодитой, үнэн зөвбайна | Нүүрс экспортлогч уурхайнуудын экспорт болон үнийн мэдээг 7 хоног бүрээр боловсруулан графикийн хамт гаргаж УУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон холбогдох удирдлагуудад цахим шуудангаар явуулж ажилласан. Нийт 38 удаа мэдээ гаргаж удирдлагыг мэдээллээр хангав. Сүүлийн гурван жилээр нүүрсний үнийн мэдээллийг нүүрсний төрлөөр гаргав. |
| 3.12.6. Нүүрсний салбарт ашиглагдаж байгаа техник, технологи, тоног төхөөрөмжүүдийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж нэгдсэн санг баяжуулах, үнэлэлт дүгнэлт гаргаж харилцагчидад мэргэжил аргазүйн зөвлөмж өгөх. | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - 4-р улиралд<br>Чанар - Үнэн зөв, бодитой мэдээлэл байна | 2014 оны уулын ажлын төлөвлөгөө ирүүлсэн 55 уурхай, 2013 оны тайлан ирүүлсэн 39 уурхайн техник технологи, тоног төхөөрөмжүүдийн дэлгэрэнгүй судалгааг нэгтгэн нэгдсэн санг баяжуулсан. 2015 оны төлөвлөгөө ирүүлсэн 54 уурхайн мэдээллээр санг шинэчлэн баяжуулсан. |
| 3.12.7. Нүүрсний уурхайнуудын Хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагаанд хяналт тавьж шаардлага хангуулах | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар -Шуурхай | 2014 оны эхний хагас жилд нийт 46 уулын ажлын төлөвлөгөө, 32 уулын ажлын тайланд хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангуулж ажиллав. Мөн хоёрдугаар хагас жилийн байдлаар 2015 оны уулын ажлын төлөвлөгөө ирүүлсэн 23 уурхайн уулын ажлын төлөвлөгөөтэй танилцаж шаардлага тавьж ажиллав. |
| 3.12.8. Дотоодын нүүрсний хангамж, хэрэглээ, дэд бүтцийг харуулсан зураг боловсруулах | Тоо хэмжээ – 1 зураг<br>Хугацаа – 3-р улиралд<br>Чанар - Хэрэгцээ хангасан байна | - Зураг боловсруулахад шаардлагатай анхдагч мэдээлэл судалгааг нүүрсний 50 уурхайн 2013 оны уулын ажлын тайлангийн үзүүлэлтээр нэгтгэж судалгаа хийсэн.<br>- Монгол улсын нүүрсний уурхайнуудын байршлын тойм зургийг хамтран боловсруулж дуусган танилцуулгад бэлтгэсэн.<br>- “Монгол улсын нүүрсний орд, уурхайн байршил, дэд бүтэц, хэтийн төлвийн зураг”-ийн боловсруулалт, баяжуулалт, шаардлагатай мэдээллийг бэлтгэж зурагт тусгасан. |
| 3.12.9. Хилийн боомтуудын хүчин чадал, хилээр гарч буй нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний судалгааг гарган дүгнэлт гарган удирдлагад танилцуулах | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа – 4-р улиралд<br>Чанар -Шуурхай, үр дүнтэй зохион байгуулна | - Хилийн боомтуудын хүчин чадал, хилээр гарч буй нүүрс, нүүрсэн бүтээгдхүүний судалгаа болон боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлын талаар танилцуулга бэлтгэсэн.<br>/Нийт 19 слайд бэлтгэсэн/<br>- Экспортод хилийн боомтуудаар ачуулсан нүүрсний биет хэмжээг сар бүр гаргасан. Гашуун сухайтын боомтоор авто тээврээр 9.5 сая.тн, Шивээхүрэнгийн боомтоор 5.3 мян.тн, Хангийн боомтоор 0.03 сая.тн нүүрс тус тус гарсан байна. /нийт 10 удаа гаргав/ |
| **3.13. Монгол орны нүүрсний ордуудын нүүрсний бүтэц, найрлага, чанарыг нарийвчлан тогтоох ажлыг эхлүүлэх** | | |
| 3.13.1 Тодорхой нүүрсний ордыг сонгон авч, эрдэм шинжилгээ, лабораторийн | Тоо хэмжээ –1 арга хэмжээ | Таван толгойн нүүрсний ордоос 3 төрлийн нийт 45 кг дээжийг авч ШУТИС-ийн Материалын технологийн сургуулийн Материал судлалын |

| | | |
|---|---|---|
| байгууллагуудтай хамтран шинжилгээ, судалгаа, туршилтын ажлыг үргэлжүүлэн хийж, тайланг гаргаж удирдлагад танилцуулах. | Хугацаа - Жилдээ<br>Чанар -Шуурхай, үр дүнтэй зохион байгуулна | лабораторид шинжилгээ туршилтанд оруулсан.<br>1-р шатны үр дүн буюу нүүрсний элемент, химийн шинж чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлж бэлэн болсон.<br>2-р шатны шинжилгээ буюу Нано түвшний туршилт судалгаа, шинжилгээний ажил хийгдсэн. |
| **3.14. Нүүрсний ордын ашиглалтын өмнөх үйл ажиллагааг хянан зохицуулах, ААН-тэй хайгуулын нөхөн төлбөрийн гэрээг байгуулж, төлбөрт хяналт тавьж ажиллах** | | |
| 3.14.1. Нүүрсний ордуудад ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн талбайд улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн геологи хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоон хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн гэрээг байгуулах | Тоо хэмжээ-Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - 4-р улирал<br>Чанар – Хуулийн хүрээнд гэрээ байгуулна | “Эрдэнийн босго” ХХК, “Дүньли” ХХК болон “Модун ресорсез” ХХК-ийн улсын төсвийн хөрөнгийн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн гэрээ байгуулах хүсэлттэй холбоотой хийгдсэн ажлуудыг нэгтгэн, зардлыг тооцоолж, нөхөн төлбөрийн гэрээний төсөл бэлтгээд байна.<br>Эрдэнийн босго” ХХК нь төлбөрийг бүрэн төлж, акт үйлдээд байна. Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ХАЗНТ-ийн гэрээтэй 13-н аж ахуйн нэгжийн гэрээг дахин шалгаж, төлөлтийг хянаж, улсын төсөвт 208,975,755төгрөг төвлөрүүлээд байна. |
| 3.14.2. Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээтэй аж ахуйн нэгжүүдийн гэрээнд заасан ажлуудын хэрэгжилтийг хангуулж ажиллах, шинээр байгуулах хүсэлтээ ирүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй АӨҮА-ны гэрээг байгуулах | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа - 4-р улирал<br>Чанар -Холбогдох хууль журамд нийцсэн байна | “Хангад эксплорейшн” ХХК-ийн Баруунналангийн ордын 4326Х талбайд байгуулсан ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээг дүгнэж акт үйлдсэн.<br>“Биг могул коул энд энержи” ХХК-ийн Хөөтийн хонхор-2 ордын 9105Х, Хөөтийн хонхор ордын 9055Х талбайд ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулан, “Хүннү Говь Алтай” ХХК-ийн Хүрэнголын ордын 10401Х, 10429Х, 10398Х, 10308Х, 10135Х талбайнуудад АӨҮАГэрээ байгууллсан. 2014-7-1 нд гарсан ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэн Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээтэй 20-н аж ахуйн нэгжүүдийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан. |
| **Дөрөв. "*Ашигт малтмалын хуулийг хэрэгжүүлэх зорилгоор ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээ үзүүлэх*" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:** | | |
| **4.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүсэх, хугацааг нь сунгах, барьцаалах, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг буцааж хүлээлгэн өгөх өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх.** | | |
| 4.1.1. Аж ахуйн нэгж, байгууллагаас ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч бүртгэх, хянан шийдвэрлэх, гэрчилгээ хавсралт шинээр бичих, эзэмшигчдэд хүлээлгэн өгөх | Тоо хэмжээ-Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар –Холбогдох хууль, журмын хүрээнд шуурхай | - Тайлант хугацаанд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн-87 өргөдөл хүлээн авч, УУККС-д бүртгэн, холбогдох шүүлтүүдийг хийж, зохих шийдвэрийн төсөл боловсруулан хянуулж 67 өргөдлийг ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоор, өргөдлийг олгохоос татгалзаж шийдвэрлэв.<br>- Ашигт малтмалын ашиглалтын шинэ тусгай зөвшөөрөл-94-г бичиж эзэмшигчид нь хүлээлгэн өгч, холбогдох материалуудыг хувийн хэрэгт |

| | | |
|---|---|---|
| | | хавсаргав. |
| 4.1.2. Тусгай зөвшөөрөл барьцаалах, талбайг буцаан өгөх, хугацааг сунгах өргөдлийг бүртгэх, хянан шийдвэрлэх, гэрчилгээний хавсралтад тэмдэглэгээ хийх, эзэмшигчдэд хүлээлгэн өгөх | Тоо хэмжээ- Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар – Холбогдох хууль, журмын хүрээнд шуурхай | - Тайлант хугацаанд тусгай зөвшөөрлөө сунгуулахыг хүссэн-118, барьцаалахыг хүссэн-27, тусгай зөвшөөрлөө шилжүүлэхийг хүссэн-52, нөхөн авахыг хүссэн-10, талбайгаа буцаахыг хүссэн-118, барьцаа чөлөөлөх-27 өргөдлийн материалыг хянан, хүлээн авч УУККС-д бүртгэв.<br>- Тайлант хугацаанд доорхи өргөдлүүдийг хянан зохих шийдвэрийн төсөл боловсруулан хянуулж, шийдвэрлүүлэв. Үүнд :<br>- тусгай зөвшөөрлөө шилжүүлэхийг хүссэн-52 өргөдөл хүлээн авч 44 өргөдлийг эцэслэн шийдвэрлэв.<br>- тусгай зөвшөөрлөө сунгуулахыг хүссэн-118 өргөдөл хүлээн авч, 96 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 2 өргөдлийг сунгахаас татгалзаж шийдвэрлэв.<br>- барьцаалахыг хүссэн-27 өргөдөл хүлээн авч 15 өргөдлийн барьцаалсныг бүртгэн, 4 өргөдлийг барьцаалсныг бүртгэхээс татгалзаж шийдвэрлэсэн.<br>- нөхөн авахыг хүссэн-10 өргөдийг хүлээн авч шийдвэрлэв.<br>- талбайгаа буцаахыг хүссэн-118 өргөдөл хүлээн авч, 116 өргөдлийг эцэслэн шийдвэрлэв.<br>- барьцаа чөлөөлөх-27 өргөдийг хүлээн авч шийдвэрлэв.<br>- Ээлжит жилийн төлбөрөө төлж бүртгүүлсэн 2326, хөдөлгөөн хийсэн 257 тусгай зөвшөөрлийн хавсралтанд зохих бичилтийг хийж, эзэмшигчид нь хүлээлгэн өгч, холбогдох материалуудыг хувийн хэрэгт хавсаргав. |
| 4.1.3. Тусгай зөвшөөрлийг цуцлах, дуусгавар болгох болон бусад шийдвэрийг гаргах | Тоо хэмжээ- Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар –Хууль, журмын хүрээнд | - Тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрөө хугацаандаа хийгээгүй 120 тусгай зөвшөөрлийг цуцалж, хугацаа нь дуусгавар болсон 293 тусгай зөвшөөрлийг УУККС-д бүртгэв. Цуцлах нөхцөл бүрдсэн болон цуцалсан шийдвэрийн талаархи мэдэгдлийг тухай бүр шуудангаар хүргүүлж, өдөр тутмын хэвлэл, байгууллагын вэбсайтанд байршуулав.<br>- Хязгаарлалтаас хамааран дуусгавар болгоогүй 41 тусгай зөвшөөрлөөс 1 дүгээр сард 15, 2-р сард 5 тусгай зөвшөөрлийг дуусгавар болгож бүртгэсэн. |
| 4.1.4. Өргөдлөөр хүсэлт гаргасан талбайд зураг зүйн шүүлт хийх | Тоо хэмжээ- Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тогтмол | Зурагзүйн бүртгэлд тулгуурлан шинээр ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн болон тусгай зөвшөөрлийн эзэмших эрхээ бусдад шилжүүлэх, хугацаа сунгуулах, талбайг хэсэгчлэн болон бүхэлд нь буцаах, барьцаалах, солбицолдоо өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан нийт 484 |

| | | |
|---|---|---|
| | Чанар – Шуурхай | өргөдөлд зурагзүйн шүүлт хийсэн. |
| 4.1.5. Тусгай зөвшөөрөл шинээр олгох сонгон шалгаруулалтад оролцох аж ахуйн нэгжүүдийн өргөдлийг хүлээн авч бүртгэх, хянан шийдвэрлэх | Тоо хэмжээ- Ирүүлэх өргөдлийн тоогоор<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар –Хууль журмын хүрээнд | - Төрөөс тогтоосон газарт сонгон шалгаруулалтын журмаар ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицол боловсруулж 1 дүгээр сард УУЯ-нд хүргүүлсэн. Шаардлагатай мэдээллүүдийг тухай бүр гаргаж өгсөн. УУЯаман дээр журам боловсруулахаар ажиллаж байна.<br>- Шүүхийн шийдвэрээр цуцлагдсан нэр бүхий 106 тусгай зөвшөөрлийн зураг болон холбогдох мэдээллийг тухай бүрд нь гаргаж өгч байна. Одоогоор сонгон шалгаруулалт зарласан 35 талбайн мэдээллийг бүрэн гаргасан. |
| **4.2. АМТХ-ийн дагуу бүх төрлийн тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад үйлчилгээ үзүүлэх** | | |
| 4.2.1. Сонирхсон этгээдэд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүртгэл болон тэдгээрийн зураг зүйн бүртгэлийн талаархи мэдээлэл, лавлагаа гаргах | Тоо хэмжээ- Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар – Үнэн зөв, бодитой мэдээлэх | Кадастрын бүртгэлд тулгуурлан сонирхсон этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, системийг хэрэглэгчдэд танилцуулах, тусгай зөвшөөрлийн байршлын 3150 гаруй тойм зургийг хэвлэх зэрэг үйлчилгээ үзүүлэв. 1800 гаруй иргэдийн тухайлан сонгосон гаруй цэгийн солбицлыг оруулж, анхан шатны шүүлт хийн өгч үйлчлэв. 1100 орчим өргөдлийн зургийг батлагдсан загварын дагуу хэвлэж, солбицлыг системд хадгалах үйлчилгээ үзүүлэв. |
| 4.2.2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайн хилийн шав тэмдгийн тайланг хүлээн авах, хянах, баталгаажуулах, бүртгэх | Тоо хэмжээ- Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар – Шуурхай байх | Геодезийн итгэмжлэгдсэн мэргэжилтнүүдийн гүйцэтгэсэн тусгай зөвшөөрлийн шав тэмдэг тавьсан 69 тайланг хүлээн авч хянан баталгаажуулж, бүртгэн тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг баяжуулсан. |
| 4.2.3. Тусгай зөвшөөрлийн хувийн хэргийг шинээр бүрдүүлэн, хувийн хэрэгт баяжуулалт байнга хийх, сонирхсон этгээдэд танилцуулах | Тоо хэмжээ- Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар – Шуурхай байх | Эцэслэн шийдвэрлэгдсэн 354 өргөдлийн материал, ээлжит жилийн төлбөр төлснийг бүртгэсэн 975 гаруй баримт материалаар тусгай зөвшөөрлийн хувийн хэрэгт нь баяжилт хийн, түүхийг нь бүрдүүлж, шаардлагатай тохиолдолд холбогдох этгээдэд хувийн хэргийг танилцуулж ажиллав. Дутуу материалуудыг нөхөж хийж байна. Цуцлагдсан, дуусгавар болсон, буцааж өгсөн тусгай зөвшөөрлүүдийн хувийн хэргийг боть болгон цэгцэлж байна. |
| 4.2.4. Сонирхсон этгээдэд тусгай зөвшөөрлийн талбайн зураг болон мэдээллийг төлбөртэй боловсруулан хүргүүлэх | Тоо хэмжээ- Үйлчлүүлэгчийн тоогоор<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар – Шуурхай байх | Ажлын шаардлагаар холбогдох эрх бүхий хүмүүс болон албан бичгийн дагуу тусгай зөвшөөрлийн хувийн хэргээс 929 хуудас материал хувилж өгөв. |

| | | | |
|---|---|---|---|
| **4.4. Тусгай зөвшөөрлийн талбайн хилийн маргааныг шийдвэрлэх** | | | |
| 4.4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд гарсан талбайн хилийн маргааныг хуульд нийцүүлэн шийдвэрлэх | Тоо хэмжээ- гарах маргааны тоогоор<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар – үнэн зөв, шуурхай хуулийн хүрээнд | Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүхийн 2010/06/02-ны өдрийн 258 дугаар магадлал, МУДШ-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2010/09/16-ны 220 дугаар тогтоолыг биелүүлж маргаан бүхий талбайн солбицолд өөрчлөлт оруулсан. | |
| 4.4.2. "Талбайг нөөцөд авах тухай" Засгийн газрын тогтоолоос чөлөөлөгдсөн талбайг уул уурхайн кадастрын компьютержсэн системд бүртгэх; | Тоо хэмжээ- Батлагдсан тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар – Хуулийн дагуу шуурхай, алдаа давхцалгүй бүртгэнэ | - Засгийн газрын 2012 оны 194-р тогтоол, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хориглосон хэсэгт орсон тусгай зөвшөөрлүүдийн дэлгэрэнгүй судалгааг цаг тухай бүрт нь гаргаж холбогдох байгууллага, удирдлагуудад хүргүүлж ажилласан.<br>- Засгийн газрын 194 дүгээр тогтоолын шинэчилсэн солбицол, 2014 оны 239, 240 дүгээр тогтоолуудыг Кадастрын бүртгэлийн системд бүртгэв. | |
| **Тав. "*Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах*" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:** | | | |
| **5.1. Улсын төсөвт орлого төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах** | | | |
| 5.1.1. Улсын төсөвт тусгай зөвшөөрлийн төлбөрөөр 25 470,7 сая төгрөг, нөхөн төлбөрөөр 1 476,5 сая төгрөг, үйлчилгээний орлогоор 1 965,0 сая төгрөг буюу нийт 28 912,2 сая төгрөг төвлөрүүлэхэд хяналт тавих биелэлтийг улирал бүр тайлагнах ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангах | Тоо хэмжээ- 28,9 тэрбум төгрөг<br>Хугацаа – жилдээ<br>Чанар – 100% биелүүлсэн байна | 7 хоног бүр тогтмол тайлагнан ажиллаж байна.<br>2014 оны 12 сарын 01-ний байдлаар оны эхнээс өссөн дүнгээр 41`249.3 сая төгрөг төвлөрсөн байна.<br>2014 оны төсвийн орлогын төлөвлөгөө 28,9 тэрбум төгрөг бөгөөд жилийн орлогын гүйцэтгэл 140,6%-тай давсан байна. Тухай бүр СЯ, УУЯ-нд орлогын мэдээг хүргүүлэн ажилласан. | |
| **5.2. Агентлагийн үйл ажиллагааны болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Үндсэн чиглэлийн биелэлт, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн биелэлтийн тайлан зэргийг боловсруулан удирдах дээд байгууллагыг мэдээллээр хангах** | | | |
| 5.2.1. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээний биелэлтийн тайланг нэгтгэн боловсруулж | Тоо хэмжээ- 3 тайлан<br>Хугацаа - Хагас, бүтэн жил<br>Чанар –Үнэн зөв, хугацаандаа гарсан байна | - Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тус газраас хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан 79 арга хэмжээний биелэлтийг нэгтгэн гаргаж, үнэлгээ хийж УУЯ-ны ХШҮДАГ-т 2014.06.30-ны 1/4014 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн холбогдох 7 заалтын биелэлтийг нэгтгэн боловсруулж, нийт | |

| | | |
|---|---|---|
| ХШҮСМХ-т хүлээлгэн өгөх, дүгнүүлэх | | 15 хуудас тайланг байгууллагын нэгдсэн тайлангийн 3 дугаар хавсралтаар УУЯ-ны ХШҮДАГ-т 2014.06.30-ны 1/4014 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>- Төсвийн шууд захирагч - АМГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Үүрийнтуяагийн 2014 оны үр дүнгийн гэрээний эхний хагас жилийн биелэлтийн тайланг нэгтгэн боловсруулж, нийт 90 хуудас УУЯ-нд хүргүүлсэн.<br>- 2014 оны жилийн эцсийн тайлангуудыг нэгтгэн боловсруулан ажил хийгдэж байна. |
| 5.2.2. НББ-ийн тухай хуульд заасны дагуу байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны үр дүнг тайлагнах, тайлан балансыг сар, улирлаар гарган УУЯ, СЯ-нд хүргүүлэх | Тоо хэмжээ- 1 тайлан<br>Хугацаа – улирал бүр<br>Чанар –Үнэн зөв, хуулийн хугацаанд багтсан байна | Байгууллагын санхүү бүртгэлийг тогтмол эрхлэн хөтөлж, 2014 оны I, III улирал, хагас жилийн тайлан балансыг хуулийн хугацаанд нь гарган баталгаажуулж, УУЯ, СЯ-нд тушаав. Жилийн эцсийн тайлан балансыг 2015 оны эхний улиралд гаргана. |
| 5.2.3. Байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслүүдийн хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр боловсруулан тайлагнах | Тоо хэмжээ- 1 тайлан<br>Хугацаа - Хагас, бүтэн жил<br>Чанар –Үнэн зөв, хугацаандаа гарсан байна | Байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийн тайланг боловсруулан АМГ-ын 2014 оны эхний хагас жилийн нэгдсэн тайлангийн хавсралтаар УУЯ-нд хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар тайлагнах бэлтгэл ажлыг хангаж байна. |
| 5.2.4. УИХ, Засгийн газар, удирдах дээд байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг хагас бүтэн жилээр нэгтгэн гаргаж ХШҮСМХ-ээр үнэлгээ хийлгэх, УУЯ-нд хүргүүлэх | Тоо хэмжээ- 1 тайлан<br>Хугацаа - Хагас, бүтэн жил<br>Чанар –Үнэн зөв, хугацаандаа бэлтгэгдсэн байна | УИХ, Засгийн газар, удирдах дээд байгууллагын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтийг хагас жилээр нэгтгэн гаргаж ХШҮСМХ-ээр үнэлгээ хийлгэн, 2014.06.30-ны 1/4014 тоот албан бичгээр УУЯ-нд хүргүүлсэн. Жилийн эцсийн байдлаар тайлагнах бэлтгэл ажлыг хангаж байна. |
| 5.2.5. Ашигт малтмалын газрын 2013 оны төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг 2013 оны I улиралд багтаан Төрийн албаны зөвлөлийн хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийн програмд оруулах ажлыг хийж гүйцэтгэх | Тоо хэмжээ- 1 мэдээ тайлан<br>Хугацаа - I сард<br>Чанар –Загвар стандартын дагуу гүйцэтгэсэн байна | 2013 оны бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гарган ТАЗ-д 2014 оны I/10-нд ТАЗ-ийн нэгдсэн баазад бүрэн оруулж дуусгасан. |
| **5.4. Салбарын түвшинд гадаад харилцаа, хамтын ажиллагаа, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах** | | |
| 5.4.1. Салбарын чиглэлээр хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэх боломжтой төслүүдийг бүтцийн холбогдох нэгжүүдтэй хамтран | Тоо хэмжээ- Төслүүдийн тоогоор<br>Хугацаа - Тогтмол | Салбарын чиглэлээр хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэх боломжтой төслүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр нэгжүүдтэй тогтмол хамтран ажиллаж байна. |

| | | |
|---|---|---|
| судалж, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Чанар –Үр ашигтай байна | Энэ ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн:<br>- ХБНГУ-ын Гео-шинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэн /BGR/-тэй хамтран хэрэгжүүлэх төслийн техникийн хамтын ажиллагааны гэрээг байгуулаад ажиллаж байна.<br>- БНЧУ-ын Геологийн албатай хамтран хэрэгжүүлж буй Монгол Алтай-50 төслийн 2014 оны хээрийн судалгааны ажил хийгдэж дууссан. Суурин боловсруулалтыг БНЧУ-ын Прага хотноо хамтран гүйцэтгэж дууссан.<br>- БНСУ-ын Геологийн шинжлэх ухаан, эрдэс баялгийн хүрээлэн /КИГАМ/-тэй хамтран 2014 онд гүйцэтгэх хээрийн судалгааны ажлын гэрээг байгуулан, энэ жилийн хээрийн судалгааны болон өрөмдлөгийн ажлыг амжилттай гүйцэтгэн эцсийн тайланг КИГАМ-ын талд хүргүүлэв. |
| 5.4.2. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх, гадаадын зочид, төлөөлөгчидтэй хийх уулзалт, ярилцлагын бэлтгэлийг ханган зохион байгуулах, оролцож ажиллах | Тоо хэмжээ- Зохион байгуулагдах уулзалтын тоогоор<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар – Зохион байгуулалт сайтай үр дүнтэй | Гадаадын зочид, төлөөлөгчидтэй хийх уулзалт, ярилцлагын бэлтгэлийг тухай бүр ханган зохион байгуулж, тэмдэглэл хөтлөн оролцож ажилласан. Тухайлбал:<br>- Уул уурхайн яам, Канадын Гүйцэтгэх үйлчилгээний байгууллага /CESO/-ын хооронд байгуулсан Санамж бичгийн дагуу цаашид хамтран ажиллах боломжийн талаар  уг байгууллагын Дэд Ерөнхийлөгч Гэйл Ли болон бусад төлөөлөгчидтэй,<br>- Kennametal Mining компанийн Дэд ерөнхийлөгч Эрик Жентис, менежер Нинг Ма нартай,<br>- БНСУ-ын  Аж үйлдвэрийн технологийг дэмжих холбоо буюу KOITA-ийн 21 төлөөлөгчидтэй уулзах уулзалт,<br>- БНСУ-ын Геологийн шинжлэх ухаан, эрдэс баялгийн хүрээлэн /КИГАМ/-тэй хамтран хэрэгжүүлж буй  “Хангайн бүсийн зүүн урд хэсэгт геологийн судалгаа болон ашигт малтмалын хайгуул хийх” төслийн хоёр дахь хээрийн судалгааны ажил амжилттай дууссан талаар КИГАМ-ийн төлөөлөгчидтэй хийсэн уулзалт,<br>- Англо Американ компанийн төлөөлөгчидтэй ,<br>- Канад Улсын “Кинкора Коппер” компанийн ерөнхийлөгч Сэм Спрингийг хүлээн авч 106 тусгай зөвшөөрлийн асуудлаар ярилцсан уулзалт зэргийг зохион байгуулсан. |
| 5.4.3. Засгийн газрын 11-11.mn сайтын мэдээлэлтэй танилцаж, шаардлагатай хариуг өгөх, агентлагийн нээлттэй утсаар болон биечлэн хандсан иргэдэд холбогдох лавлагаа мэдээллээр үйлчлэх | Тоо хэмжээ- Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар – Иргэдийг мэдээлээр хангасан | Тайлант хугацаанд “11-11” төвөөс тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор 64 санал, 5 гомдол ирсэнд зохих хариуг өгсөн. Баасан гариг бүрийн 7 хоногийн мэдээнд тодорхой мэдээллийг оруулан, байгууллагын удирдлага болон УУЯ-нд тайлагнаж байна.<br>Нийт 485 иргэнд биечлэн, 620 иргэнд утсаар лавлагаа, зөвлөгөө өгсөн. |

| | | |
|---|---|---|
| | байна | |
| 5.4.4. Иргэдээс байгууллага, албан хаагчдад хандаж тавьсан хүсэлт, саналыг хүлээн авсан ажилтан өөрөө хариуцан бусад төрийн байгууллага, ажилтантай цахим шуудангаар хууль тогтоомжийн дагуу харилцаж хариу авч, хүсэлт гаргасан иргэнд үйлчилдэг тогтолцоонд шилжих ажлыг Үндэсний дата төвтэй хамтран хэрэгжүүлэх / ЗГҮАХХАХТ – 278.2 заалт/ | Тоо хэмжээ- 1 арга хэмжээ<br>Хугацаа - II-III улиралд<br>Чанар – Техникийн асуудлууд шийдэгдсэн байна | Үндэсний дата төвтэй тогтмол хамтран ажиллаж байна.<br>Энэ ажлын хүрээнд манай талаас хийгдэх шаардлагатай бүх бэлтгэл ажлууд 2013 онд хийгдсэн. Үндэсний дата төвөөс нэгдсэн холболт хийгдэхийг хүлээж байна. |
| **5.5 Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, таниулах ажлыг зохион байгуулах** | | |
| 5.5.1. УУЯ-ны олон нийт, PR чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, 1 цонхны бодлогоор хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгч ажиллах | Тоо хэмжээ- 1 арга хэмжээ<br>Хугацаа – III улиралд<br>Чанар –Нийгэмд үнэн бодитой, эерэг мэдээлэл өгнө | УУЯ-ны хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтнуудтай байнга холбоотой ажиллаж, 1 цонхны бодлогоор хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага, мэдээлэл өгч ажилласан. АМГ-ын хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны 2014 оны төлөвлөгөө гаргасан.<br>Уул уурхайн салбарын үйл ажиллагааг сурталчилах “Нээлттэй өдөрлөг”-ийн арга хэмжээний бэлтгэлийг ханган V/17-ны өдөр амжилттай оролцсон.<br>Тайлант хугацаанд салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан 502 мэдээллийг нэгтгэн удирдлагад танилцуулсан. |
| **5.8. Агентлагийн хариуцах асуудлын хүрээнд Монгол улсын Дайчилгааны тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон дайчилгаа ба гамшгаас хамгаалах асуудлаар гарсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоолуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах** | | |
| 5.8.1. Агентлагийн хариуцах асуудлын хүрээнд Монгол улсын Дайчилгааны тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон дайчилгаа ба гамшгаас хамгаалах асуудлаар гарсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоолуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахад оролцож ажиллана | Тоо хэмжээ- Тухай бүр<br>Хугацаа – тухай бүр<br>Чанар –Үндэслэл сайтай тайлбар гаргах, чанартай үйл ажиллагааг хэрэгжүүлнэ | Монгол улсын Дайчилгааны тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон дайчилгаа ба гамшгаас хамгаалах асуудлаар гарсан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоолуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдаж байгаа ажлуудад идэвхитэй оролцож байна. 2014.03.27-ны өдөр зарлагдсан газар хөдлөлтийн үеийн гамшгийн дуут дохиог турших сургалтад нийт албан хаагчдыг хамруулсан. Энэ ажлын хүрээнд ОБЕГ-ын 2 ажилтан ирж яриа хийж, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан.<br>Байгууллагын хэмжээнд мөрдөгдөх “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-ний төслийг боловсруулан батлуулан мөрдүүлсэн. |
| **5.9. Дотоод ажил үйлчилгээ** | | |
| 5.9.1. Байгууллагын өдөр тутмын хэвийн | Тоо хэмжээ- 1 арга | Байгууллагын конторын байрны засвар үйлчилгээ, харуул хамгаалалт, |

| | | |
|---|---|---|
| үйл ажиллагааг хангахтай холбоотойгоор өрөө тасалгаа, хэвийн дулаан, гэрэлтүүлэг, техник хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулах | хэмжээ<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар –Тавигдах стандартад нийцсэн байна | харилцаа холбооны техник хэрэгслийн ашиглалтад хяналт тавин, Төрийн өмчийн XII байрны захиргаатай хамтран ажиллаж байна. |
| 5.9.2. Албан ажлын шаардлагаар хот дотор болон хөдөө орон нутагт ажиллах автомашины ашиглалт, хадгалалт хамгаалалтыг хариуцан, тасралтгүй найдвартай, аюулгүй ажиллагааг хангах | Тоо хэмжээ- 1 арга хэмжээ<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар –Тасралтгүй, найдвартай ажиллагаа хангагдсан байна | Байгууллагын албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа 10 автомашин, автограшийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна.<br>5-р сард зохион байгуулагдсан автын Улсын үзлэг тооллогод хамруулах, татвар хураамжийг төлөх ажлыг зохион байгуулсан.<br>ТӨХ-ноос 5 дугаар сард ирүүлсэн тогтоолын дагуу Ниссан Пикаф автомашиныг ОБЕГазарт хүлээлгэн өгч, Ланд-105 автомашиныг нээлттэй дуудлага худалдаагаар оруулан актлуулах ажлыг зохион байгуулсан. |
| **Зургаа. "*Геологи, уул уурхайн салбарын хяналт шинжилгээ, үнэлгээний чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, статистик мэдээллийн чиг үүргийг хэрэгжүүлэх*" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд:** | | |
| **6.2. Байгууллага, түүний нэгж, албан хаагчдын үйл ажиллагаа, үйлчилгээг үзүүлж буй байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйлчилгээний хүртээмж, чанар, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, үйл ажилллагааны ахиц дэвшил, алдаа сургамжийг тодорхойлон цаашид болдлого, хөтөлбөр, үйл ажиллагааг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлагыг цаг үеэ олсон үнэн зөв мэдээллээр хангах** | | |
| 6.2.1. Байгууллагын нэгжийн үйл ажиллагаанд бүхэлд нь болон тодорхой асуудлын хүрээнд улирал бүр шаардлагатай тоо хэмжээгээр хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөн үйлчилгээний хүртээмж, чанар, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, үйл ажилллагааны ахиц дэвшил, зөрчил дутагдлыг тодорхойлон цаашид бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг сайжруулах талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, холбогдох байгууллагуудыг үнэн зөв мэдээллээр хангах | Тоо хэмжээ- Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар –Холбогдох дүрэм, журмын дагуу | • 2013 оны дотоод болон гадаад томилолтын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ хийн Даргын дэргэдэх зөвлөлийн хуралд ДДЗХ-д 2014 оны 2-р сарын 13-ны өдөр танилцуулсан.<br>• АМГ-ын ажилтнуудын ажлын ачааллын байдалд хяналт-шинжилгээ хийн ДДЗХ-д 2014 оны 2-р сарын 13-ны өдөр танилцуулсан.<br>• Уул уурхайн кадастрын компьютержсэн системийг байгууллагын вэб хуудсанд байрлуулах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн ажлын хүрээнд Дорноговьд 12 сум, Баян-Өлгий аймгийн болон Баян-Өлгий аймгийн 6 сумын иргэдийн хуралд тусгай хэрэгцээний газрын талаар албан тоот, судалгааны хамт явуулсан. 6-1154, 6-1155, 6-1775, 6-1776, 6-1777, 6-1778, 6-1779, 6-1780 6-2527, 6-2539 албан тоотууд.<br>• 2013 оны хээрийн шуурхай хяналтаар хайгуулын ажил хийгдээгүй тусгай зөвшөөрлүүдийг цуцлах үйл ажиллагаа тасалдсан талаар судлаж агентлагын дарга болон хэлтсийн дарга нарт танилцуулсан.<br>• 3-р сард ТТАМТЗ-ийг олгох журмыг боловсруулах ажлын хэсэгт |

| | | |
|---|---|---|
| 1.6.7. Геофизик, геоэкологи, эрлийн маршрут зэрэг газар дээр нь шалгах боломжгүй ажил хийсэн тайлан ирүүлсэн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ажлыг шалган баталгаажуулах, | Тоо хэмжээ –<br>Шаардлагатай too хэмжээгээр<br>Хугацаа - II-IV улиралд<br>Чанар -Хууль журмын дагуу | Уул, өрөмдлөгийн буюу газар дээр нь хянах боломжгүй ажил хийгдсэн 320 ТЗ-г түүвэрлэж, зайлшгүй үзэх шаардлагатай 12 ТЗ-д хийгдсэн ажлыг шалгах ажил хийгдсэн. | |
| 1.6.8. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн АМТХ-ийн дагуу ирүүлсэн жилийн тайланг газар дээр нь баталгаажуулах, | Тоо хэмжээ –1200 орчим<br>Хугацаа - II-IV улиралд<br>Чанар - Хууль журмын дагуу | 1.Сүхбаатар, Дорнод аймгийн чиглэлд, 2.Төв, Булган, Сэлэнгэ аймгийн чиглэлд 3.Баянхонгор, Өвөрхангайн чиглэлд 4.Архангай, Завхан, Хөвсгөл аймгийн чиглэлд хээрийн шуурхай хяналтын ажил хийгдсэн. Тайлангаа ирүүлсэн 54 талбай буюу нийт 10 аймаг хамрагдсан. | |
| 1.6.9. Ашигт малтмалын хайгуулын болон | Тоо хэмжээ – 1200-1400 | -Хайгуулын ажлын нөөц бүхий үр дүнгийн 141 тайлангийн | |

| | | | |
|---|---|---|---|
| ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн ГХА-ын зардлыг баталгаажуулах, | орчим тайлан<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар- Хууль журам, зааврын дагуу | зардал хянаж баталгаажуулсан. | |
| 1.6.10. Хувийн хөрөнгөөр хайгуул хийж ашигт малтмалын ордын нөөц тогтоосон үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, дүгнэлт, тэмдэглэлийг баталгаажуулж, тушаал гаргуулах, | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар -Хууль журмын дагуу шуурхай | ЭБМЗ-ийн хуралдаанаар ордын тайланг хэлэлцүүлэх 15 хуралдааныг зохион байгуулсан, 141 дүгнэлт, тушаал гаргуулж, 15 тэмдэглэлийг баталгаажуулсан. | |
| **2.25. Төмөртэй, Хуст уулын төмрийн хүдрийн ордыг түшиглэн нойтон баяжуулах үйлдвэр барьж эхэлнэ. /ЗГҮАХХАХТ-57.2 заалт/** | | | |
| 2.25.1. Хуурай болон нойтон баяжуулах үйлдвэрийн барилгын ажил дуусахтай зэрэгцэн технологийн туршилтыг хагас үйлдвэрлэлийн түвшинд явуулж бүтээгдэхүүний стандартыг боловсруулж, холбогдох байгууллагаар хэлэлцүүлэх талаар ДТҮ-тэй хамтран ажиллах | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар - Хамтын ажиллагаа үр дүнтэй байна | - 2013/02/20-22 өдрүүдэд Төмөртэй, Хуст уулын төмрийн хүдрийн ордыг түшиглэн нойтон баяжуулах үйлдвэр барих талаар салбарын холбогдох эрдэмтдээс санал авах албан бичгийн төсөл боловсруулж, хүргүүлсэн болович эрдэмтдийн санал урд нь төсөлд тусгагдчихсан байсан учир ахин эрдэмтдээс санал авах шаардлагагүй болсон.<br>- Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг түшиглэн барьж байгаа нойтон баяжуулах үйлдвэрийн ажлын танилцуулгыг, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хамт ирүүлэх тухай албан бичиг хүргүүлж, 2013/10/02-ны өдөр ирүүлсэн мэдээлэлд боловсруулалт хийн, мэдээллийн баазад оруулав.<br>Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт байрлах “Ган эрдэс” ХХК-ийн Нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-тэй танилцан, санал өгсөн ба ЭБМЗ-өөр хэлэлцэгдсэн. Нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, байр зүйн зураглал, инженер геологийн, геофизикийн судалгаа, цэвэр бохир усны техникийн нөхцөл, хаягдлын аж ахуйн зураг төсөл хийгдэн зөвшөөрлөө авсан. Үйлдвэрийн барилгын ажлыг 2012 оны 8-р сард эхлүүлэн 2013 онд дууссан. Одоо тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажил хийгдэж байна.<br>- Тайлант хугацаанд Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд жилд 1 сая тонн хүдэр баяжуулах хүчин чадалтай нойтон баяжуулах үйлдвэрийн барилгын ажлын явцтай 3 удаа танилцаж мэргэжил арга зүйн зөвлөмжүүд өгч | |
| 2.25.2. Гарсан санал, дүгнэлтийг УУЯ-нд тавьж шийдвэрлүүлэх | Тоо хэмжээ – 1 санал дүгнэлт<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Үндэслэл сайтай, хэрэгжихүйц бодитой байна | | |

| | | | |
|---|---|---|---|
| | | ажилласан. | |
| **2.28. Уул уурхайн нэгдсэн мэдээллийн систем үүсгэх, Цахим тайлангийн үйл ажиллагааг сайжруулах.** | | | |
| 2.28.1. Уулын ажлын төлөвлөгөө, тайланг цахимаар хүлээн авах програмыг сайжруулах. | Тоо хэмжээ – 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа – II-III улиралд<br>Чанар - Тавигдах шаардлагад нийцсэн байна | - “Уулын ажлын төлөвлөгөө, тайлан хянан зөвшөөрөх журам” хүчингүй болж хүлээн авах заавар шинэчлэгдсэнтэй холбогдуулан “Ашигт малтмал ашиглах, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан мэдээ хүлээн авах заавар”-ыг баталсаны дагуу ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан хүлээн авах программын шинэчлэлийн талаар Уул уурхайн нэгдсэн систем үүсгэх ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлж буй ХБНГУ-ын BGR төслийн мэргэжилтэн Dr.Markus Toloczyki болон УУХ, НХ-ийн мэргэжилтнүүдийн хамтарсан уулзалтад оролцож санал өгөх ажлыг зохион байгуулж, нэгтгэн 2014.09.15-нд цаасаар хүргүүлсэн.<br>- Уулын ажлын төлөвлөгөө, тайланг цахим хэлбэрээр хүлээн авах ажлын хүрээнд цахим тайланд нэвтрэх эрх шинээр авахыг хүссэн **84** ААН-ийн албан бичигт хариу өгч, системд нэвтрэх хэрэглэгчийн нэр, нууц үгийг хүргүүлэн мэдээллийг оруулсан. | |
| 2.28.2. ТЭЗҮ, техник, технологийн мэдээллийн нэгдсэн санг хөтлөх, баяжуулах | Тоо хэмжээ – 1 сан<br>Хугацаа - тогтмол<br>Чанар - Тавигдах шаардлагад нийцсэн байна | 1. ЭБЭХ-ны Сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн дугаар 074 тушаалаар баталсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник эдийн засгийн үндсэлэл хүлээн авах журам"-ын дагуу боловсруулан 2014 онд ирсэн 153 техник эдийн засгийн үндэслэлд шинжээч томилуулж, 99 төсөлд шинээр, 111 төсөлд дахин танилцах хуудас олгосон байна.<br>2. 2014 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 19 удаагийн хуралдаан зохион байгуулж 149 (давхардсан тоогоор) техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцүүлсэнээс хүлээн авсан **33**, ажлын шугамаар засвар хийлгэн хүлээн авсан **102**, ЭБМЗ-өөр хэлэлцүүлж дахин хэлэлцэхээр буцаасан **14** техник эдийн засгийн үндэслэл байна.<br>3. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 119 дүгнэлт, тушаалын төсөл гаргажээ. Төслийн шатандаа яваа 13 дүгнэлт байна.<br>4. Хүлээн авсан техник, эдийн засгийн үндэслэлийн 119 товч | |

| | | | |
|---|---|---|---|
| | | танилцуулгыг файл аар авсан байна. Эдийн засгийн хувьд үр ашигтай ашигт малтмалын ордын болон уулын үйлдвэрүүдийн дэлгэрэнгүй судалгааг 2014 онд хэлэлцэн хүлээн авсан төслүүдэд 51 хийсэн байна.<br>5. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан 5 зохион байгуулав. | |
| 2.28.3. Уулын ажлын төлөвлөгөө, тайлангийн зургийг зургийн програмын өргөтгөлтэйгөөр хүлээн авах ажлыг турших | Тоо хэмжээ – 1 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар – Алдаагүй, үйлчлүүлэгчдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ болж чадсан байна | - Уул уурхайн нэгдсэн мэдээллийн системийг боловсронгуй болгох ажлын хүрээнд мэдээллийн программ “Прожект майнинг” ХХК-тай хамтран зохиож байна. Эхний ээлжийн туршилтыг хийж сайжруулах тал дээр санал өгөв.<br>-Уулын ажлын төлөвлөгөө болон тайлангийн зургийг зургийн програмын өргөтгөлтэйгөөр хүлээн авах ажлын хүрээнд “Майкро майн” ХХК-нд уулын ажлын дэвсгэр зургаас авах мэдээллийн талаар санал боловсруулан хүргүүлсэн**.**<br>- “Уулын ажлын төлөвлөгөө, тайлан хянан зөвшөөрөх журам” хүчингүй болж хүлээн авах заавар шинэчлэгдсэнтэй холбогдуулан “Ашигт малтмал ашиглах, үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан мэдээ хүлээн авах заавар”-ыг баталсаны дагуу ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан хүлээн авах программын шинэчлэлийн талаар Уул уурхайн нэгдсэн систем үүсгэх ажилд зөвлөх үйлчилгээ үзүүлж буй ХБНГУ-ын BGR төслийн мэргэжилтэн Dr.Markus Toloczyki болон УУХ, НХ-ийн мэргэжилтнүүдийн хамтарсан уулзалтад оролцож санал өгөх ажлыг зохион байгуулж, нэгтгэн 2014.09.15-нд цаасаар хүргүүлсэн.<br>- Уулын ажлын төлөвлөгөө, тайланг цахим хэлбэрээр хүлээн авах ажлын хүрээнд цахим тайланд нэвтрэх эрх шинээр авахыг хүссэн **84** ААН-ийн албан бичигт хариу өгч, системд нэвтрэх хэрэглэгчийн нэр, нууц үгийг хүргүүлэн мэдээллийг оруулсан. | |
| 2.28.4. Уул уурхайн үйл ажиллагаанаас эвдрэлд орсон, орхигдсон газрын тооллого болон нөхөн сэргээлт хийсэн мэдээллийн санг хөтлөх, баяжуулах | Тоо хэмжээ – 2 арга хэмжээ<br>Хугацаа - жилдээ<br>Чанар - Тавигдах шаардлагад нийцсэн, үнэн зөв мэдээлэл байна | Мэдээллийн сан үүсгэх ажлын дагуу монгол талын туслан гүйцэтгэгч Supreme solution ХХК-ний гүйцэтгэсэн цахим хуудсанд мэдээлэл оруулсан бөгөөд зарим програм хангамжийг засварлав.<br>АМГ, БОНХЯ, УУЯ, УЦУОШГ-ын БО-ны мэдээллийн төвийн хамтарсан mris.mram.gov.mn/flex/-mnggis.html-д мэдээлэл оруулах, хэрэглэгчдэд ашиглуулах сургалтыг зохион | |

| | | | |
|---|---|---|---|
| | | байгуулсан. | |
| **3.1. Нүүрсний салбарын бодлогын баримт бичгүүдтэй холбоотой хийгдэх ажлууд /ЗГҮАХХАХТ-102.1/** | | | |
| 3.1.1. “Нүүрс” хөтөлбөрийн төслийг ажлын хэсгийн хүрээнд эцэслэн боловсруулж, УУЯ-д хүргүүлэн хэлэлцүүлэх. | Тоо хэмжээ –1 төсөл<br>Хугацаа - I улирал<br>Чанар - Үндэслэл сайтай, хэрэгжихүйц байна | “Нүүрс” хөтөлбөрийн төсөлд оруулах нэмэлт материалыг хавсралтаар боловсруулж, Ажлын хэсэгт нэгтгүүлэн, эцсийн хувилбараар хэлэлцүүлэгт бэлтгэсэн.<br>Үнд: нүүрсний 1990-2013 онд олборлолт, экспортын хэмжээ, үнэ, тээвэр, боомтууд, 2014-2035 оны таац, зах зээл, тайлан, тэнцэлийн талаар 8 хуудас, нүүрсний уурхайнуудын байршил, дэд бүтэц, 2014-2024 онд ДЦС-дад нийлүүлэх хэмжээ, стратегийн ордуудын жагсаалтанд орсон ордуудын тодорхойлолтууд /19 хуудас/ | |
| **3.3 Нүүрсний геологийн судалгаа нөөцийн асуудалтай холбоотой хийгдэх ажлууд** | | | |
| 3.3.1 1990, 2004 оны нөөцийн хөдөлгөөний баланс, уурхайнуудын уулын ажлын тайлан, нөөцийн хөдөлгөөн, олборлолтын мэдээ, тайлангуудыг үндэслэн 2009 оноос өмнө үйл ажиллагаа явуулж байсан нүүрсний уурхайнуудын нөөцийн хөдөлгөөний асуудлыг шийдвэрлэх, ашиглагдсан нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлээс хасуулан нөөцийн хөдөлгөөний тайланг Геологийн төв архивт хадгалуулах. | Тоо хэмжээ –1 арга хэмжээ<br>Хугацаа – 4-р улиралд<br>Чанар -Тооцоо судалгаа үндэслэл сайтай, бодитой | Хартарвагатайн уурхай, Зээгтийн уурхай, Шарынголын уурхай, Баянтээгийн уурхай, Жилчигбулагийн уурхай, Тэвшийн говийн уурхай, Шивээ-Овоогийн уурхайнуудын нөөцийн хөдөлгөөний тайланг хүлээн авч танилцаж, Шивээ-Овоогийн уурхай болон Жилчигбулагийн уурхайн нөөцийн хөдөлгөөний тайланг засвар оруулах шаардлагатай гэж үзэн буцааж, бусад 5 тайланг хүлээн авч, ГМТА-т тушаасан. | |
| 3.3.2. Нийт ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг нөөцтэй эсэх талаар нэгдсэн дүгнэлт гаргаж, нөөц тогтоогдоогүй болон нөөцийн тоо хэмжээ нь тодорхойгүй тусгай зөвшөөрлүүдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулан удирдлагад танилцуулах. | Тоо хэмжээ – 1 санал<br>Хугацаа – 2-р улиралд<br>Чанар -Хэрэгжих боломжтой, бодитой | Нийт 62 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг ЭБМЗ-өөр хүлээн авсан нөөцтэй эсэх үгүйг тогтоож, талбайд хамаарах нөөц нь ЭБМЗ-өөр тухайн талбайд хамааруулан хүлээн авсан эсэх талаар тодорхойлолт, танилцуулга бэлтгэсэн. | |
| 3.3.3.Улсын нөөцийн нэгдсэн тоо бүртгэлд бүртгэгдсэн болон нөөцийн хөдөлгөөн хийгдсэн ордуудын мэдээллийг мэдээллийн нэгдсэн санд нэмэн баяжуулж, холбогдох баримт материалыг цуглуулан нөөцийн нэгдсэн мэдээллийн сангийн ажлыг үргэлжүүлэн гүйцэтгэх. | Тоо хэмжээ – 1 санХугацаа - 4-р улиралд<br>Чанар - Мэдээллийн сан бүрдсэн байна | ЭБМЗ-ийн зөвлөлөөр хүлээн авсан 34 хайгуулыг ажлын тайлантай танилцаж, 41 ЭБМЗ-ийн дүгнэлт, АМГ-ын тушаалыг хуулбарлан авч, мэдээллийг файлжуулан нэгтгээд байна. | |
| 3.3.4. Нүүрсний ашиглалтын тусгай | Тоо хэмжээ – 1 арга | Ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн 20 өргөдөл, | |

| | | | |
|---|---|---|---|
| зөвшөөрөл хүссэн болон шилжүүлэхийг хүссэн өргөдөлд тухайн ордын геологийн судалгаа, нөөцийн тайлан түүнтэй холбогдон гарсан эрх бүхий байгууллагын дүгнэлт, тушаалд үндэслэн хяналт хийж хариуцсан нэгжид нь шилжүүлэх. | хэмжээ<br>Хугацаа - 4-р улиралд<br>Чанар - Хууль журмын дагуу | шилжүүлэхийг хүссэн 4 өргөдөлтэй танилцаж, нөөцийн тоо хэмжээ, ГМТАрхивт хүлээлгэн өгсөн хайгуулын ажлын үр дүнгийн тайлангийн зургуудтай тулган, зураг зүйн шүүлт хийж, танилцах хуудас үйлдэн КХ-т хүлээлгэн өгсөн. | |
| 3.3.5 “Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-д хамрагдаж байгаа нүүрсний ашиглалтын тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой мэдээллээр байгууллага, ажлын хэсгийг ханган ажиллах. | Тоо хэмжээ – Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа – 4-р улиралд<br>Чанар -Шуурхай, бодитой мэдээллээр хангана | Хуульд хамрагдсан ашиглалтын 488 тусгай зөвшөөрлөөс нүүрсний 54 тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй судалгааг бэлтгэж УУХ-т нэгтгүүлэн Ажлын хэсэгт хүргүүлж хэлэлцүүлэгт бэлтгэсэн. Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл хэлцэгдэх шатанд байна. | |
| 3.3.6 Монгол орны нүүрсний ордуудын геологи геодинамикийн нөхцлийг судлаж харьцуулан нүүрс хуримтлах палеогеодинамик, глобал геотектоникийн талаар дүгнэлт гаргах. | Тоо хэмжээ – Дүгнэлт<br>Хугацаа – 1-р улиралд<br>Чанар –Сангийн түвшинд | Монгол орны нүүрсний ордуудын геологи геодинамикийн нөхцлийг судлаж харьцуулан нүүрс хуримтлах палеогеодинамик, глобал геотектоникийн талаар дүгнэлт гаргах ажлын хүрээнд энэ чиглэлээр бичигдсэн эрдэмтэдийн бүтээл, геологи хайгуулын ажлын тайлан зураглалын ажлын тайлан бусад холбогдох материалуудыг судлаж Монгол орны нүүрс нь карбон, перм, юра, цэрдийн цаг үед үүссэн ба риптийн болон ороген гарал үүсэлтэй байх боломжтой гэсэн дүгнэлтийг өгч байгаа ба ордуудыг бассейнаар нь нэгтгэн нийт 115 орчим ордын хэмжээнд судалгаа хийж дүгнэлт гаргав. 1 сан, 2 хуудас дүгнэлт. | |
| 3.3.7 Нүүрсний ордуудын байршил, дэд бүтэц, геологийн тогтоц, судалгааны түүх, ГХА-ын судалгааны түвшин, ажлын хэмжээ, чанар, нөөц, ашиглагдаж байгаа байдал, ашиглалтын тусгай зөвшөөрлүүд зэрэг бусад шаардлагатай мэдээллийг агуулсан танилцуулгуудыг шинэчлэх, шинээр гарч байгаа мэдээлэлээр баяжуулах, мөн шинээр нээгдсэн ордуудын мэдээллийг нэмж бэлтгэх. | Тоо хэмжээ – Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа – 4-р улиралд<br>Чанар -Шуурхай, бодитой мэдээллээр хангана | 1. Хангайн бүсийн Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл аймгуудын нутагт орших 19 нүүрсний орд, илрэлүүдийн газарзүйн байршил, нөөцийн тоо хэмжээ, олборлолтын өнөөгийн байдал, тусгай зөвшөөрлийн асуудлын талаар танилцуулга бэлтгээд байна.<br>2. Зүүн бүсийн Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгуудад байгаа нүүрсний 20 уурхайн танилцуулгыг шинэчлэн боловсруулсан. Зүүн бүсийн нийт ордуудын жагсаалтыг гаргаж тусгай зөвшөөрлийн судалгаа хийж бусад шаардлагатай мэдээллийг агуулсан танилцуулгуудыг шинэчлэх, шинээр гарч байгаа мэдээллээр баяжуулах, мөн шинээр нээгдсэн | |

| | | | |
|---|---|---|---|
| | | ордуудын мэдээллийг нэмж бэлтгэв.<br>3. Говийн бүсийн нүүрсний 8 уурхайн танилцуулгын мэдээллийг нэмж баяжуулав.<br>4. Төвийн бүсийн Сайхан-Овоо, Улаан-Овоогийн нүүрсний уурхайн танилцуулгыг шинэчлэн баяжуулсан. Цайдамнуурын ордын танилцуулга бэлтгэсэн.<br>5. Монгол улсад антрацитын ордоор бүртгэгдсэн Дорноговь аймгийн Мандах нуурын хагас антрацит, Алаг-Өндөрийн антрацитын орд болон Булганы Сайхан Овоогийн чулуун нүүрсний ордын товч танилцуулгыг бэлтгэн Ажлын хэсгийг шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан.<br>6. Баруун бүсийн нүүрсний уурхайн танилцуулгын хүрээнд Хартарвагатайн уурхайн мэдээлэл, танилцуулгыг шинэчлэн баяжуулав. | |
| 3.3.8 “Монгол Улсын хилээр шинжилгээний дээж нэвтрүүлэхэд тодорхойлолт олгох” зааврын дагуу геологи-хайгуулын болон бусад холбогдох судалгаа шинжилгээний хүрээнд хилээр гарч буй нүүрсний дээжинд тодорхойлолт олгох | Тоо хэмжээ – Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - жилдээ<br>Чанар -Шуурхай, бодитой мэдээлэл | 2014 онд Хилээр нэвтрүүлэх дээжинд тодорхойлолт гаргуулахыг хүссэн нийт 74 хүсэлт аж ахуйн нэгжүүдээс албан бичгээр ирсэнийг хариуг хүргүүлэн ГЕГ-т тодорхойлолт гаргаж шийдвэрлэсэн. | |
| **4.3. Геологи, уул уурхайн кадастр хөтлөх** | | | |
| 4.3.1. Геологи, уул уурхайн компьютержсэн кадастрын системийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, олон нийтэд ил тод, нээлттэй болгох | Тоо хэмжээ- 1 арга хэмжээ<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар – Хэвийн тасралтгүй | - УУККС-ийг боловсронгуй болгох үүднээс нэмэлт өөрчлөлт оруулах талаар төслийг хэрэгжүүлэгч GAFAG компанид хандсаны дагуу тус компаниас ирүүлсэн хариуг удирдлагад танилцуулсан. Хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр УУЯ, BGR компанид хандаад байна.<br>- Уул уурхайн кадастрын компьютержсэн системийг интернэт орчинд байршуулах ажлын хүрээнд бэлтгэл ажлыг дуусгаж, ТЕГ-ын харъяа Кибер Аюулгүй байдлын газарт хандсаны дагуу вэб хуудсанд шалгалт хийгдэж дүгнэлт ирүүлсэн. Улмаар танилцуулгыг хийж, Ашигт малтмалын газрын даргын 2014 оны а-34 тоот тушаалын дагуу УУККС-ийг интернэт орчинд байршуулж, тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод болгон, шуурхай үйлчилгээ үзүүлж байна. Сонирхсон этгээдийг системийг ашиглах, танилцах боломжоор хангаж, зөвлөгөө өгөн ажиллаж байна. | |

| | | | |
|---|---|---|---|
| 4.3.2. Улсын тусгай хамгаалалттай, орон нутгийн тусгай хэрэгцээний газар болон тусгай зөвшөөрлөөр ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан, хориглосон талбайг бүртгэх | Тоо хэмжээ- Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар – Хуулийн дагуу шуурхай | УИХ-ын 2011 оны 18, 2012 оны 56, 57 дугаар тогтоолуудаар Улсын тусгай хамгаалалтанд авсан 12 газрыг Кадастрын бүртгэлд оруулсан. Уг талбайтай давхцалтай байгаа тусгай зөвшөөрлийн жагсаалт болон давхцлын хэмжээг гаргаж албан тоотоор БОНХЯаманд мэдэгдэв. Мөн энэ тухай 19 тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд мэдэгдэл хүргүүлсэн. УИХ-ын 2012 оны 38 дугаар тогтоолоор тусгай хамгаалалтаас чөлөөлөгдсөн талбайнуудыг бүртгэлд оруулсан. Орон нутгаас ирүүлсэн 270 тогтоолыг солбицлын дагуу CMCS програмд оруулан шүүж, 40 тогтоолыг бүртгэн, 78 тогтоолыг бүртгэх боломжгүй талаар хариу албан тоотыг явуулж мэдэгдсэн. | |
| 4.3.3. Хууль хяналтын байгууллагаас хийсэн хязгаарлалтыг бүртгэх, тусгай зөвшөөрлийг хязгаарлалтанд бүртгэгдсэн эсэхэд шүүлт хийн хяналтын хуудсанд тэмдэглэх | Тоо хэмжээ- Шийдвэрийн тоогоор<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар – Хуулийн дагуу шуурхай | Хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн 59 албан бичгийг үндэслэн 183 тусгай зөвшөөрлийг хязгаарлалтанд бүртгэж, 44 тусгай зөвшөөрлийг хязгаарлалтаас чөлөөлөв. Хязгаарлалтын бүртгэлд тулгуурлан 848 тусгай зөвшөөрөлд холбоотой өргөдөл болон цуцлах, дуусгавар болгох хяналтын хуудсанд хязгаарлалт бүртгэгдсэн эсэхийг шүүж, хяналтын хуудсанд тэмдэглэв. | |
| 4.3.4. Засгийн газрын 2011 оны 174, 2012 оны 194 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг гаргах ажлыг үргэлжлүүлэн хийх | Тоо хэмжээ- Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар – Батлагдсан хууль, тогтоомжийн дагуу | Засгийн газрын 2011 оны 174, 2012 оны 194 дүгээр тогтоолуудыг хэрэгжүүлж ажиллахын зэрэгцээ Засгийн газрын 2012 оны 194-р тогтоол, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хориглосон хэсэгт орсон тусгай зөвшөөрлүүдийн дэлгэрэнгүй судалгааг цаг тухай бүрт нь гаргаж холбогдох байгууллага, удирлагуудад хүргүүлж ажилласан. | |
| **5.3. Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах** | | | |
| 5.3.1. Ашигт малтмалын газрын дарга-Төсвийн шууд захирагчийн Уул уурхайн сайдтай байгуулах 2014 оны үр дүнгийн гэрээг батлуулах. Нэгжийн менежерүүд болон төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ байгуулах, ёсчлох ажлыг зохион байгуулах | Тоо хэмжээ- 1 төсөл, 1 арга хэмжээ<br>Хугацаа - I сард<br>Чанар – Шат шатны гэрээ хуулийн хүрээнд батлагдсан байна | Гэрээ 2014 оны 1-р сард батлагдан ирсэн. Хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Алба, хэлтсийн дарга нарын ҮДГ байгуулах ажлыг нэгтгэн зохион байгуулж, менежерүүдийн үр дүнгийн гэрээ батлагдсан.<br>Төрийн албан хаагчид Менежерүүдтэй үр дүнгийн гэрээ байгуулах, ёсчлох ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, арга зүйн туслалцаа үзүүлэн ажиллсан. | |
| 5.3.2. Байгууллагын хүний нөөцийн | Тоо хэмжээ- | Тайлант хугацаанд шинээр томилогдох 6 ажилтны | |

| | | | |
|---|---|---|---|
| бодлогыг хэрэгжүүлэх, боловсон хүчний шилжилт хөдөлгөөнийг шуурхай зохион байгуулан ажиллах | Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар – Шуурхай, хуулийн дагуу зохион байгуулах | материалыг бүрдүүлэн, АТГ-аас дүгнэлт гаргуулахаар албан тоот хүргүүлсэн. Ирүүлсэн дүгнэлтийн дагуу дээрх албан хаагчдийг томилсон тушаалыг гаргуулан хувийн хэрэг нээж, мэдээллийг хүний нөөцийн болон бүрэлдэхүүн хөдөлгөөний програмд бүртгэв. Мөн түр томилготой байсан 3 тасгийн даргыг жинхэлэн томилох асуудлыг шийдвэрлүүлсэн. 12 албан хаагчийг байгууллагын дотор шилжүүлэн томилох тушаал гаргасан.<br>3D төсөл дуусч байгаатай холбоотойгоор 3 ажилтанг чөлөөлсөн. Мөн 5 албан хаагчийг өөрийн хүсэлтээр чөлөөлсөн.<br>Нийт 28 ажилтны зэрэг дэвийн нэмэгдлийн асуудлыг шийдвэрлүүлж, тушаал гаргуулсан.<br>Хүний нөөцийн програмд ажилтнуудын зураг болон дэлгэрэнгүй мэдээллийг оруулах ажил хийгдэж дууссан.<br>Билгийн тооллын цагаан сарыг угтан байгууллагын харъяанд байдаг 84 ахмад настангуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг гардуулах, Эх үрсийн баярыг тохиолдуулан байгууллагын нийт ажилтнуудын 18 нас хүртэлх хүүхдүүдэд бэлэг өгөх ажлыг зохион байгуулан ажилласан. | |
| 5.3.3. Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийг тогтмол, шуурхай эрхлэн явуулах | Тоо хэмжээ- Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тогтмол<br>Чанар – Хууль журам, холбогдох стандартын дагуу | Тайлангийн хугацаанд 7157 бичиг хүлээн авч, 6752 албан бичиг илгээсэн байна. Иргэд, А.А.Н байгууллагаас нийт 39 өргөдөл хүлээн авч бүртгэлжүүлэн холбогдох албан тушаалтнуудад тараасан. Хариутай албан бичгийн шийдвэрлэлтэд тогтмол хяналт тавин ажиллаж байна.<br>2013 онд хөтлөгдөж дууссан баримт бичгийг хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хүлээн авах хуваарь гарган батлуулсан. Хуваарийн дагуу хүлээн авч, дууссан.<br>Архив, албан хэрэг хөтлөлтийн Улсын үзлэг 2015 онд зохион байгуулагдахтай холбоотойгоор урьдчилсан үзлэгт шалгалтын бэлтгэлийг ханган амжилттай оролцсон. | |
| **5.6. Үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг баримтлан байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулах** | | | |
| 5.6.1. Агентлагийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөлөлийг боловсруулж, шийдвэрлүүлэх | Тоо хэмжээ- 1 б.б<br>Хугацаа -II-III улиралд<br>Чанар – Тооцоо үндэслэл сайтай | Агентлагийн 2015 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2016-2017 оны төсвийн төсөөллийг бэлтгэж УУЯ-нд хуулийн хугацаанд буюу IV/20-ны дотор 1-2890 албан тоотоор хүргүүлэн Сайдын багцад нэгтгүүлсэн. | |

| | | | |
|---|---|---|---|
| 5.6.2. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг нийтэд ил тод харуулах “Шилэн данс”-ны тогтолцоог хэрэгжүүлнэ | Тоо хэмжээ- 1 ажил үйлчилгээ<br>Хугацаа -II улиралд<br>Чанар – Шуурхай, бодитой | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд “Шилэн данс”-ны тогтолцоог нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. Энэ ажлын хүрээнд байгууллагын веб хуудсанд санхүүгийн үйл ажиллагааны тайлан мэдээг тухай бүр байршуулж байна.<br>“Шилэн данс”-ны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлнэ. | |
| **5.7. Ашигт малтмалын газрын эрхлэх асуудлын хүрээнд салбарын түвшинд хууль, эрх зүйн асуудлыг нэгтгэн зохицуулан зохион байгуулах, хууль, эрх зүйн зөвлөлгөө өгөх, хяналт тавих** | | | |
| 5.7.1. Ашигт малтмалын тухай хууль шинэчлэн батлагдсан даруй дагалдах дүрэм журмуудын төслийг шинэчлэн боловсруулах, батлуулан мөрдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Тоо хэмжээ- 1 арга хэмжээ<br>Хугацаа - Хууль батлагдсаны дараа<br>Чанар –Бодитой, шуурхай ажиллах | Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга УИХ-аар батлагдан гарсан. Хууль батлагдсаны дагуу шаардлагатай дүрэм журам шинэчлэн боловсруулах ажлыг 4 ажлын хэсгийн хүрээнд хийж гүйцэтгэн батлуулахаар УУЯ-нд хүргүүлсэн.<br>Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль батлагдсантай холбогдуулан журам боловсруулах ажлын хэсгийг томилон ажиллуулж, журмын төсөлд УУЯ-наас санал аван ХЗЯ-нд нийтээр дагаж мөрдөх журмын жагсаалтад бүртгүүлэхээр хүргүүлсэн.<br>Мөн 2014 оны 11 дүгээр сард ТТАМТХ-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой нэг өдрийн сургалтыг аймаг, нийслэлийн ЗДТГ-ын мэргэжилтнүүдийг хамруулан хийж, сертификат гардуулсан. | |
| 5.7.2. Авлигатай тэмцэх төрийн бодлого, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, авлигатай тэмцэх газар болон хууль хяналтын байгууллагатай хамтарч ажиллах, авлигын эсрэг 2014 оны төлөвлөгөө боловсруулан батлуулж, түүний дагуу хийсэн ажлын тайлан гаргаж хүргүүлэх<br>/ЗГҮАХХАХТ-284.1 заалт/ | Тоо хэмжээ- 1 төлөвлөгөө<br>Хугацаа – I, IV улиралд<br>Чанар –Үр нөлөөтэй, хуулийн хүрээнд зохион байгуулсан байна | Авлигатай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор АТГ-аас сургагч багш урин, ОУ-ын Найрамдал төвд нэг өдрийн сургалт зохион байгуулсан.<br>Албан хаагчдын ХАСХОМ гаргахтай холбоотойгоор мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэн, байгууллагын ТЗ-ны бүх албан хаагчдад зөвлөгөө өгч ажилласан.<br>“Ашигт малтмалын газрын 2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулан газрын даргын тушаалаар батлуулсан бөгөөд АМГ-ын 2013 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг гарган АТГ, УУЯ-нд хүргүүлсэн. | |
| 5.7.3. Ашигт малтмалын газрын төрийн захиргааны албан хаагчдын 2013 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан | Тоо хэмжээ- 100 гаруй албан хаагч<br>Хугацаа - I улиралд | Байгууллагын хэмжээнд төрийн захиргааны 108 албан хаагчийн 2013 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг II/15-ны дотор багтаан хүлээн авч ХАСХОМ програмд оруулан | |

| | | | |
|---|---|---|---|
| нэгтгэж АТГ-т хүргүүлэх ажлыг зохион байгуулах /ЗГҮАХХАХТ-284.5 заалт/ | Чанар –Хуульд заасан шаардлагад нийцүүлэн хугацаанд нь хүргүүлсэн байна | баталгаажуулж АТГ-т бүртгүүлсэн. Гүйцэтгэл 100 хувь. | |
| 5.7.4. Агентлагийг төлөөлж хууль хяналтын байгуулагуудтай харилцах, итгэмжлэлээр шүүх хуралдаанд оролцох, хариу тайлбар хүргүүлэх | Тоо хэмжээ- Шаардлагатай тоо хэмжээгээр<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар – Үндэслэл сайтай тайлбар гаргах, чанартай үйл ажиллагааг хэрэгжүүлнэ | Тухай бүр нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд байгууллагын эрх ашгийг хамгаалан оролцож байна.<br>АМГ-т холбогдуулан гаргасан нэхэмжлэл, түүнтэй холбогдон гарсан шүүхийн шийдвэр, магадлал, тогтоолын бүртгэлийг хариуцсан ажилтан хөтлөн архивлаж байна. | |
| **6.1. Бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнах мөн Агентлагийн үйл ажиллагааны болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт, Үндсэн чиглэлийн биелэлт, арга хэмжээний биелэлтийн тайлан зэргийг боловсруулан удирдах дээд байгууллагыг мэдээллээр хангах** | | | |
| 6.1.1. Ашигт малтмалын газрын алба, хэлтэс, тасгуудын 2014 оны үйл ажиллагааны төлөвлөлтийн байдалд хяналт хийх | Тоо хэмжээ- 1 арга хэмжээ<br>Хугацаа -1 сард<br>Чанар –Холбогдох дүрэм, журмын дагуу | Алба, хэлтсүүдийн 2014 оны төлөвлөгөөг хянан зохих засваруудыг хийлгэв. АМГ-ын төлөвлөгөөг боловсруулахад хяналт тавьж ажиллав. Алба, хэлтсүүдийн сарын төлөвлөгөө, сарын тайланг тогтмол хянан үнэлгээ өгч ажилласан. | |
| 6.1.2. Ашигт малтмалын газрын дарга-Төсвийн шууд захирагчийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай /УУ-н сайд/ байгуулах үр дүнгийн гэрээний төсөлд агентлагийн алба, хэлтсүүдийн нийлүүлбэл зохих нийт бүтээгдэхүүн тусгагдсан эсэх талаар хяналт тавих, батлуулах. Нэгжийн менежерүүд болон төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээг хянах | Тоо хэмжээ- 2 арга хэмжээ<br>Хугацаа -1 сард<br>Чанар –Холбогдох дүрэм, журмын дагуу | Гэрээний төсөлд агентлагийн алба, хэлтсүүдийн нийлүүлбэл зохих нийт бүтээгдэхүүн тусгагдсан эсэх талаар хяналт тавих, батлуулах ажлыг зохион байгуулж ажиллав.<br>Төсвийн шууд захирагчийн гэрээ батлагсан. ТАХ-ын ҮДГ-нүүдийг хянаж баталгаажуулах ажлыг зохион байгуулав. | |
| 6.1.3. Ашигт малтмалын газрын 2014 оны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилт, алба, хэлтэс, тасгуудын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж, хагас, бүтэн жилээр үнэлгээ хийх, тайлагнах. | Тоо хэмжээ- 2 арга хэмжээ<br>Хугацаа - Хагас, бүтэн жилд<br>Чанар –Холбогдох дүрэм, журам, зааврын дагуу | Алба, хэлтсүүдийн 1, 2, 3, 4, 5, 6, 7, 9, 10, 11, 12 сарын төлөвлөгөө, тайланг хянах ажлыг сар бүр тогтмол гүйцэтгэлээ. | |

| | | | |
|---|---|---|---|
| Нэгжийн менежерүүд болон төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээ, төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийг хянах | | | |
| 6.1.4. Ашигт малтмалын газрын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн актын хэрэгжилтэд хагас бүтэн жилээр үнэлгээ хийн УУЯ-ны ХШҮДАГ –т 1 сарын 5 болон 7 сарын 1-ний дотор хүргүүлэх<br>- Ашигт малтмалын газрын эрхлэх асуудлын хүрээний Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого хэрэгжилтэд бүтэн жилээр үнэлгээ хийн УУЯ-ны ХШҮДАГ –т 12 сарын 20-ны дотор хүргүүлэх<br>- Ашигт малтмалын газрын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хагас бүтэн жилээр үнэлгээ хийн УУЯ-ны ХШҮДАГ –т 6 сарын 15 болон 12 сарын 20 -ны дотор хүргүүлэх<br>- Ашигт малтмалын газрын эрхлэх асуудлын хүрээний МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хагас бүтэн жилээр үнэлгээ хийн УУЯ-ны ХШҮДАГ –т 7 сарын 1 болон 1 сарын 5-ны дотор хүргүүлэх<br>- Ашигт малтмалын газрын эрхлэх асуудлын хүрээний Үндэсний хөтөлбөрийн биелэлтэд бүтэн жилээр үнэлгээ хийн УУЯ-ны ХШҮДАГ –т 1 сарын 20-ны дотор хүргүүлэх<br>- Удирдах дээд байгууллагын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, биелэлтийн тайланд хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ үнэлгээ хийн УУЯ-ны | Тоо хэмжээ- 6 арга хэмжээ<br>Хугацаа - Тухай бүр<br>Чанар –Үр нөлөөтэй, шуурхай, үнэн бодитой байна | Ашигт малтмалын газрын үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн актын хэрэгжилтэд 2013 оны эцсийн байдлаар үнэлгээ хийн УУЯ-ны ХШҮДАГ –т 1-р сард хүргүүлсэн. Мөн 2014 оны эхний хагас жилийн байдлаар биелэлтэд үнэлгээ хийн 6-р сард хүргүүлсэн. | |

| | | | |
|---|---|---|---|
| ХШҮДАГ-д хүргүүлэх | | | |
| **6.6. Уул уурхайн салбарын статистик мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх** | | | |
| 6.6.1. Байгууллагын хэмжээнд албан ёсны нэгдсэн статистикийн бүртгэл хөтөлж мэдээллийн нэгдсэн санг бий болгох ажлыг зохион байгуулах, эхлүүлэх | Тоо хэмжээ- 1 арга хэмжээ<br>Хугацаа – жилдээ<br>Чанар –Шуурхай, үр дүнтэй байна | Нэгдсэн мэдээллийн сан байгуулах оношилгоо хийх зөвлөхийн ажлын даалгавар боловсруулах ажлын хэсгийг 2014-02-21-ний өдрийн а-15 тоот тушаалаар батлуулан ажиллаж “Зөвлөхийн ажлын даалгавар”-ыг боловсруулж танилцуулсан. Нэгдсэн мэдээллийн сан байгуулах оношилгоо хийх “Зөвлөхийн ажлын даалгавар”-ыг англи хэл рүү хөрвүүлэн бэлэн болгосон. 5-р сард BGR төслийн зөвлөх ажилтантай хамтран байгууллагын үйл ажиллагаа болон мэдээллийн ургалын ерөнхий шинжилгээг 14 хоногийн дотор хийж дүгнэлтийг танилцуулсан. | |
| **7.9 Эрдэс түүхий эдийн боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих<br>/ЗГҮАХХАХТ-ний 55 дахь заалт/** | | | |
| 7.9.1. Нүүрсийг угаах, баяжуулах, коксжуулах, хагас коксжуулах, хийжүүлэх, шингэрүүлэх зэргээр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдийг дэмжих талаар санал боловсруулах, үйл ажиллагаанд нь хяналт тавьж, төр-хувийн хэвшлийн зарчмаар хамтран ажиллах, техник, технологид нь үнэлэлт, дүгнэлт, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгнө.<br>1. Уул уурхайн боловсруулах үйлдвэрлэлийн хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох талаар судалгааг хийж санал боловсруулах.<br>2. Үйл ажиллагаа явуулж буй боловсруулах үйлдвэрүүдийн тайлан, төлөвлөгөөг хүлээн авч хянах.<br>3. Шинээр хэрэгжих төслүүдийн ТЭЗҮ-г хүлээн авч танилцах, техник, технологид нь үнэлэлт дүгнэлт өгөх,<br>4. Боловсруулах үйлдвэрүүдийн талаар мэдээлэл танилцуулга бэлтгэж УУЯ | Тоо хэмжээ- 5 арга хэмжээ<br>Хугацаа – 1-12-р сард<br>Чанар –Тавигдах шаардлагад нийцсэн байна | - Хуурай аргаар нүүрс баяжуулах технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий ажлын хэсгийн ажлын хэрэгцээнд шаардлагатай элсний ордуудын талаарх мэдээллийг бэлтгэн Эрдэнэс Тавантолгой ХК-нд хүлээлгэн өгсөн.<br><br>- Монгол улсын ерөнхий сайдаас өгсөн үүргийн дагуу ДЦС-2-ыг түшиглэн байгуулсан хагас коксын үйлдвэрийн шахмал түлшний цехийн хэсгийг 2014-2015 оны өвлийн улирлаас өмнө ажиллуулах боломжийг тогтоох талаар эрдэмтэд, эдийн засагчдийн хамтарсан ажлын хэсгийг 2014 оны 04-р сарын 03-ны АББҮХорооны Ажлын албаны нарийн бичгийн даргын 14 тоот тушаалаар АМГ, ШУА, ЭЗЯ, ЭХЯ, СЯ, НАЧА-ны мэргэжилтнүүдийн бүрэлдхүүнтэйгээр байгуулан ажиллав. /Ажлын хэсгийн ахлагч Ж. Батбилэг/ Ажлын хэсгийн гишүүд ДЦС-2-ыг түшиглэн байгуулсан хагас коксын үйлдвэр байгуулах төслийн гүйцэтгэгч Аморе Интернэшнл ХХК-ийн удирдлагуудтай ДЦС-2 станцын байранд уулзалт зохион байгуулж, материалуудыг судлан дүгнэлт гарган АББҮХороонд танилцуулж шийдвэрлүүлсэн. Энэхүү шийдвэрийн дагуу тус төслийн үр дүнд бий болсон хагас коксын брикетийн цех, шингэн шилний үйлдвэрийг | |

| | | | |
|---|---|---|---|
| болон бусад байгууллагуудыг мэдээллээр хангах.<br>5. Үйлдвэр төслүүдтэй танилцах, томилолтоор ажиллах | | хэсэгчилэн хүлээн авах Улсын комиссын дүгнэлт гаргасан.<br>- Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос 2014 оны 04-р сарын 03-ны тушаалаар байгуулагдсан “Хагас кокс, шахмал түлшний MNS 5679:2011 стандартыг шинэчлэн өөрчлөх саналыг боловсруулан, батлуулах” үүрэг бүхий АББҮХ-ны ажлын алба, БОНХЯ, СХГ-тай хамтарсан ажлын хэсэг, Эрдэмтдийн зөвлөл 2 удаагийн хуралдааныг зохион байгуулж, стандартын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан, холбогдох байгууллагуудаас санал авч Стандарт хэмжилзүйн үндэсний төвийн Стандартчиллын техникийн хороо болон Үндэсний зөвлөлийн хурлаар оруулж “Сайжруулсан шахмал түлш. Техникийн шаардлага. MNS 5679:2014” Үндэсний стандартыг батлуулав.<br>- Хагас кокс, сайжруулсан түлшний үйлдвэрүүдийн өнөөгийн байдал, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын талаар танилцуулга бэлтгэж хэлтсийн даргад танилцуулав.<br>- “ДЦС-2 ТӨХК-г түшиглэсэн 210 000 тонн хагас коксжсон шахмал түлш үйлдвэрлэх хүчин чадалтай цогцолбор байгуулах төсөл”-ийн гэрээг судлаж, хууль эрх зүйн дүгнэлт боловсруулсан. Уг дүгнэлтийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж, холбогдох тэмдэглэл гарсан.<br>- Жижиг дунд үйлдвэрийн тоног төхөөрөмжийг гааль болон НӨАТ-аас чөлөөлөх ЗГ-ын 191 дүгээр тогтоолын хавсралтанд оруулах хагас коксон болон сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийн жагсаалтыг гаргаж АББҮХ-нд хүргүүлэв.<br>- Японы JICA байгууллагаас хэрэгжүүлж буй “Агаарын бохирдын хяналтын тогтолцоог сайжруулх” төслийн ажлын хүрээнд нүүрс болон шинэ түлш /сайжруулсан түлш/-д туршилт хийхээр аргачлалыг танилцуулах, гишүүдийн саналыг сонсох уулзалтад оролцож санал солилцов.<br>- АББҮХорооноос Боловсруулсан түлшний үйлдвэр байгуулахаар санал өгсөн гадаад дотоодын төслүүдийн хүчин чадал, сонгосон технологи, бүтээгдэхүүний өртөг, түүхий эдийн хангамж, түлшний техникийн үзүүлэлтүүдийн мэдээллийг нэгтгэв.<br>- Боловсруулах үйлдвэрүүдийн төлөвлөгөө, тайланг хүлээн | |

| | | | |
|---|---|---|---|
| | | авах бэлтгэл ажил болгож дотоод заавар боловсруулан, АМГ-ын даргын тушаалаар батлуулж, хэлтсийн даргын албан тоотын хамт компаниудад хүргүүлсэн.<br>- Нүүрс боловсруулах үйлдвэрүүдийн Техник эдийн засгийн үндэслэл хүлээн авах дотоод зааврын төслийг боловсруулсан.<br>- Багануурын уурхайн хөрс тээвэрлэлт, овоолгод конвейрийн систем нэвтрүүлэх ТЭЗҮ-г хүлээн авч танилцаад зохих шүүмж, саналуудыг бичиж, нэгтгүүлсэн.<br>- Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших Ээдэмт-2 шатдаг занарын ордыг ил уурхайгаар олборлон шингэн түлш боловсруулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлтэй танилцаж холбогдох мэдээллүүдийг авсан.<br>- Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргын 2014 оны 02-р сарын 25-ний өдрийн 03 тоот тушаалаар байгуулагдсан “Хагас кокс, антрацит болон бусад сайжруулсан түлшийг халаалтын болон гэрийн зууханд ашиглах, агаарын бохирдлын асуудлаар үнэлгээ дүгнэлт гаргах” үүрэг бүхий Эрдэмтдийн Зөвлөх ажлын хэсэгт ажиллаж, үйлдвэр байгуулах саналаа ирүүлсэн “Эрдэнэс МГЛ” ХК, “MSCE” ХХК, “Модун ресурс” ХХК, “Дэрст тохой” ХХК “Хур туг” ХХК, Улаан овоо-ийн төслүүдийн талаар дүгнэлт гаргаж Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороонд танилцуулан дэмжлэг үзүүлэхээр холбогдох шийдвэрүүдийг гаргуулав.<br>- Дархан-уул аймгийн Шарын голын уурхайн 600 мян тн нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ-г хүлээн авч танилцав | |
| **7.10. Нүүрсний салбарын шинжилгээ туршилтын ажлын чанарын түвшинг дээшлүүлнэ** | | | |
| 7.10.1. Лабораторийн шинэ тоног төхөөрөмжүүд болон Миреко төслийн багаж, тоног төхөөрөмжүүд ашиглаж эхлэхтэй холбогдуулан лабораторийн итгэмжлэлийн хүрээг өргөтгөнө.<br>Шинээр нэмэгдэж буй шинжилгээнүүдийн стандартуудыг ашиглах эрх авч мөрдөж ажилласнаар лабораторийн шинжилгээ, | Тоо хэмжээ- 2 ажил үйлчилгээ<br>Хугацаа –Тогтмол<br>Чанар –Холбогдох стандарт шаардлагын дагуу | Лабораторийн итгэмжлэлийн хүрээг өргөтгөх хүсэлт хүргүүлсэний дагуу СХЗГ-ын Итгэмжлэлийн албанаас үнэлгээний ажлын хэсэг ирж, лабораторийн сорилт, шинжилгээ, техникийн баримт бичигт хяналт, шинжилгээг 2 үе шаттайгаар хийж дуусгасан.<br>Лабораторийн итгэмжлэлийн хүрээг чулуун ба хүрэн нүүрс, антрацит, шатах занар, хагас кокс, кокс, шахмал түлшний шинжилгээ гүйцэтгэх 3 эрхээр, хөрс, усны шинжилгээ | |

| | | | |
|---|---|---|---|
| туршилтын ажлын бүтээмжийг нэмэгдүүлж, үр өгөөж, чанарыг сайжруулна. | | гүйцэтгэх 11 эрхээр, нийт 14 эрхээр өргөтгөн баталгаажуулав. | |
| 7.10.2. Лабораторийг олон улсын итгэмжлэлийн статустай болгох зорилт дэвшүүлэн шалгуур нөхцлүүдийг хангах цогц ажлыг хэрэгжүүлнэ.<br>Үүний үр дүнд гадаад улсад гүйцэтгүүлж буй зарим төрлийн шинжилгээний ажлыг дотооддоо хийх бололцоог бүрдүүлэх замаар шинжилгээний ажлын төлбөр хэлбэрээр гадаад руу шилжиж буй валютын урсгалыг бууруулахад бодитой хувь нэмэр оруулна. | Тоо хэмжээ- 1 арга хэмжээ<br>Хугацаа – жилдээ<br>Чанар –ОУ-ын итгэмжлэл авах нөхцөл хангагдсан байна | - Гэрээт ажлын гүйцэтгэлийн төлөвлөлтийн дагуу Тавантолгойн ордын 4, 8-р давхаргын баяжуулалтын туршилтын ажил гүйцэтгэж дуусган, судалгааны тайланг захиалагчид хүлээлгэн өгсөн.<br>- ГЕГ-ын Гаалийн төв лабораторитой хамтран ажиллаж Монгол орны хилээр нэвтэрч буй нүүрсний дээжний хяналтын шинжилгээг хийхээр аман хэлцэл хийсэн бөгөөд “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн төслийг боловсруулан Газрын даргын 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 1-860 тоот албан бичгээр “Санал авах тухай” албан бичиг хүргүүлсэн. Тус лабораториос 2014.03.14-ны өдрийн ирүүлсэн хүсэлтийн дагуу лабораторийн шинжилгээний нэр төрөл, лабораторийн чадавхитай холбоотой танилцуулга, шинжилгээний үнийн санал зэргийг 2014 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн 9-1126 тоотоор албан бичгээр хүргүүлэв.<br>Тус “Санамж бичиг”-ийг 06-р сарын 10-нд АМГ-ын хурлын танхимд хоёр талаас гарын үсэг зурж баталгаажуулав | |
| **Тусгай арга хэмжээний биелэлтийн ДУНДАЖ ОНОО** | | | |

АШИГТ МАЛТМАЛЫН ГАЗАР